


<p>Варшав. 2020 оны 5-р сарын 11</p> <p>Саналын дугаар.: JUD-MNG/362/2019</p> <p>[JB]</p> <p>www.legislationline.org</p>	
---	--

МОНГОЛ УЛСЫН ЭВЛЭРҮҮЛЭН ЗУУЧЛАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨГӨХ АИХЭГ-ЫН САНАЛ

**ЕАБХАБ-ын Ардчилсан Институт Хүний Эрхийн Газраас захиалан орчуулсан
хуулийн англи хэл дээрх албан бус орчуулгыг үндэслэн гаргав.**

Энэхүү санал дүгнэлтийг боловсруулахад Сингапурын Менежментийн Их Сургуулийн
Эрх зүйн профессор (практик), Сингапурын Олон Улсын Маргаан Шийдвэрлэх
Академийн Захирал Надяа Александер хувь нэмэр оруулав.

Энэхүү монгол орчуулга нь редакцийн шинэчилсэн найруулгад орно

ЕАБХАБ-ын Ардчилсан Институт Хүний Эрхийн Газар
Ulica Miodowa 10 PL-00-251 Warsaw утас. +48 22 520 06 00 факс. +48 22 520 0605

*Хуульд өгөх саналын монгол хэл дээрх орчуулга
Гэвч англи хэл дээрх хувилбар нь энэхүү баримт бичгийн албан ёсны хувилбар болно.*

ГАРЧИГ

I. ТАНИЛЦУУЛГА.....	4
II. САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХАМРАХ ХҮРЭЭ	4
III. ХУРААНГУЙ.....	5
IV. ДҮН ШИНЖИЛГЭЭ БА ЗӨВЛӨМЖ	7
1. Эвлэрүүлэн зуучлалын тухай олон улсын стандартууд.....	7
2. Хуулийн зорилт ба үйлчлэх хүрээ.....	10
2.1. <i>Ерөнхий тайлбарууд.....</i>	<i>10</i>
2.2. <i>Хуулийн зорилт</i>	<i>12</i>
2.3. <i>Хуулийн үйлчлэх хүрээ.....</i>	<i>13</i>
2.4. <i>Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд заасан эвлэрүүлэн зуучлалын болон бусад нэр томъёоны тодорхойлолтууд.....</i>	<i>14</i>
3. Эвлэрүүлэн зуучлах ажиллагааг санаачлах, өдөөх механизм.....	15
3.1. <i>Ерөнхий тайлбарууд.....</i>	<i>15</i>
3.2. <i>Өдөөх механизм.....</i>	<i>16</i>
4. Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны журмын талаарх заалтууд.....	19
4.1. <i>Ерөнхий тайлбарууд.....</i>	<i>19</i>
4.2. <i>Эвлэрүүлэн зуучлалын үндсэн зарчим.....</i>	<i>19</i>
4.3. <i>Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны оролцогчид.....</i>	<i>21</i>
4.4. <i>Ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой захиргааны асуудлууд (явуулах газар, хугацаа, зардал).....</i>	<i>22</i>
4.5. <i>Эвлэрүүлэн зуучлах ажиллагааг эхлүүлэх.....</i>	<i>23</i>
4.6. <i>Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны үйл явц.....</i>	<i>23</i>
4.7. <i>Эвлэрүүлэн зуучлах ажиллагааг дуусгавар болгох.....</i>	<i>24</i>
5. Эвлэрүүлэн зуучлагчийг сонгох.....	25
5.1. <i>Эвлэрүүлэн зуучлагчдад тавигдах шаардлага</i>	<i>25</i>
5.2. <i>Эвлэрүүлэн зуучлагчдад тавигдах стандарт</i>	<i>26</i>
5.3. <i>Эвлэрүүлэн зуучлагчийг татгалзан гаргах</i>	<i>27</i>
6. Эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөл	27
6.1. <i>Эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөлийн үүрэг ба бүрэлдэхүүн.....</i>	<i>27</i>
6.2. <i>Эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөлийн бүрэн эрх (11-р зүйл).....</i>	<i>28</i>
7. Эвлэрүүлэн зуучлагчид, талууд болон эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд оролцогчдын эрх, үүрэг	30
7.1. <i>Эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд оролцож буй талуудын эрх, үүрэг.....</i>	<i>30</i>
7.2. <i>Эвлэрүүлэн зуучлагчдын эрх, үүрэг.....</i>	<i>32</i>
7.3. <i>Өмгөөлөгчдийн эрх, үүрэг.....</i>	<i>33</i>
7.4. <i>Гуравдагч этгээдийн болон шүүхийн эрх, үүргүүд.....</i>	<i>34</i>

Монгол Улсын Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд өгөх АИХЭГ-ын санал дүгнэлт

8. Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны нууцлал, нотлох баримтаар үнэлэгдэхгүй байх	34
8.1. Нууцлалтай холбоотой үүрэг хариуцлагууд	34
8.2. Нууцлалыг хадгалахад үл хамаарах нөхцөлүүд	35

Хавсралт: Монгол Улсын Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль (2012 оны 5-р сарын 22)

Монгол Улсын Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд өгөх АИХЭГ-ын санал дүгнэлт**I. ТАНИЛЦУУЛГА**

1. Монгол Улсын Шүүхийн Ерөнхий зөвлөлөөс 2019 оны 9-р сарын 3-ны өдөр Монгол Улсын Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль (цаашид "Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль") болон шүүх засаглалтай холбоотой өөр дөрвөн хуулийн талаар санал дүгнэлт өгөх тухай хүсэлтийг ЕАБХАБ-ын Ардчилсан Институт, Хүний Эрхийн Газар (цаашид "АИХЭГ")-т ирүүлсэн болно.
2. Хүсэлт гаргагчтай зөвлөлдсөний дараа санал авахуулахаар ирүүлсэн хуулиудын эрх зүйн талуудаас нь хамаарч, гурван өөр санал дүгнэлт өгөх нь зүйтэй гэж зөвшилцөв. Энэхүү санал нь зөвхөн Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд хамаарах бөгөөд Шүүхийн тухай, Шүүхийн захиргааны тухай, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд өгсөн санал, мөн Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуульд өгсөн саналтай хамтад нь уншиж танилцах шаардлагатай.¹
3. 2019 оны 9-р сарын 11-ний өдөр АИХЭГ уг хүсэлтэд хариу өгч, Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль болон бусад хуулиуд нь ЕАБХАБ-ын хүний хэмжүүрийн талаар хүлээсэн үүрэг хариуцлага, хүний эрхийн олон улсын стандартад нийцэж буй эсэхэд хуулийн санал дүгнэлт гаргаж өгөхөд тус газар бэлэн байгааг нотлон илэрхийлэв.
4. Дээрх хүсэлтийн хариуд уг санал дүгнэлтийг бэлтгэн боловсруулав. АИХЭГ нь ЕАБХАБ-ын гишүүн орнуудад ЕАБХАБ-ын өмнө хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхэд нь туслах бүрэн эрхийнхээ хүрээнд энэхүү үнэлгээг хийлээ.²

II. САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХАМРАХ ХҮРЭЭ

5. Энэхүү санал дүгнэлтийн хамрах хүрээ нь зөвхөн хянан шинжлүүлэхээр ирүүлсэн Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийг хамарна. Тиймээс уг санал дүгнэлтийг хязгаарлагдмал хүрээнд авч үзэх нь зүйтэй бөгөөд Монгол Улсад эвлэрүүлэн зуучлах ажиллагааг зохицуулж буй хууль эрх зүйн болон институцийн тогтолцоог бүхэлд нь хамарсан бүрэн, нарийвчилсан судалгаа дүгнэлт биш юм.
6. Санал дүгнэлтээр гол чухал асуудлуудыг хөндөж, анхаарах ёстой асуудлуудыг тусгасан болно. Товч тодорхой байх үүднээс уг санал дүгнэлтээр Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн эерэг сайн талуудыг биш, харин засаж сайжруулах шаардлагатай заалтууд дээр илүү анхаарлаа. Тусгагдсан санал зөвлөмжүүд нь эвлэрүүлэн зуучлалтай холбоотой олон улсын стандарт, туршлага дээр үндэслэгдсэн. Шаардлагатай бол, санал дүгнэлтээр ЕАБХАБ-ын бусад оролцогч орнуудын энэ чиглэлээр хэрэгжүүлж буй сайн туршлагыг тодруулахыг эрэлхийлэх болно.

¹ Монгол Улсын хүчин төгөлдөр хэрэгжиж буй хуулиуд болон хуулиудын төсөлд өгсөн эрх зүйн санал дүгнэлтийг дараах вэбсайтаас үзэх боломжтой: <<https://www.legislationline.org/odhr-documents/page/legal-reviews/country/60/Mongolia/show>>.

² [ЕАБХАБ-ын нутаг дэвсгэр дээр эрх зүйт ёсыг дээдлэх явдлыг улам бэхжүүлэх тухай ЕАБХАБ-ын шийдвэр № 7/08](#) (2008) үзнэ үү. Уг шийдвэрийн 4-р зүйлд Сайд нарын зөвлөл нь "[o]ролцогч улс орнуудыг өөрсдийн бүрэн эрх болон байгаа нөөц бололцооныхоо хүрээнд, шаардлагатай тохиолдолд, ЕАБХАБ-ын холбогдох гүйцэтгэх бүтцүүдийн тусламжтайгаар [тухайлан] шүүх засаглалын хараат бус байдал, шүүх засаглалыг үр дүнтэй хэрэгжүүлэх, шударга шүүхээр шүүлгэх эрх, шүүхэд хандах, төрийн байгууллага, албан тушаалтнуудын хариуцлага, төрийн захиргааны байгууллагад эрх зүйт ёсыг дээдлэх, эрх зүйн туслалцаа авах эрх, саатуулагдан хоригдож буй хүмүүсийн хүний эрхийг хүндэтгэх [...] зэрэг асуудлууд дээр мэдээлэл, шилдэг туршлагаа хуваалцах, эрх зүйт ёсыг бэхжүүлэхийн төлөө хүчин чармайлтаа үргэлж сайжруулахыг сайшаан дэмжинэ" гэж заажээ.

Монгол Улсын Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд өгөх АИХЭГ-ын санал дүгнэлт

7. Түүнчлэн, эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенц³ (цаашид “CEDAW” гэх) болон ЕАБХАБ-ын 2004 оны жендерийн тэгш байдлыг дэмжих үйл ажиллагааны төлөвлөгөө, жендерийн үзэл баримтлалыг ЕАБХАБ-ын үйл ажиллагаанд нэвтрүүлэхээр хүлээсэн үүрэг амлалтын дагуу уг хуулийн эмэгтэй, эрэгтэй хүмүүст үзүүлж болзошгүй нөлөөллийг энэхүү санал дүгнэлтээр шинжилж үзсэн болно.⁴
8. Энэхүү санал дүгнэлт нь Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн англи хэл дээрх албан бус орчуулгад үндэслэсэн бөгөөд уг хуулийг энэхүү баримт бичигт хавсралт болгон оруулав. Орчуулгаас үүдэлтэй алдаа гарсан байж болно. Энэхүү санал дүгнэлтийг монгол хэл дээр мөн үзэх боломжтой. Гэвч англи хэл дээрх хувилбар нь уг баримт бичгийн албан ёсны хувилбар байх болно.
9. Дээр дурдсан зүйлсийг харгалзан, АИХЭГ нь цаашид Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актуудын талаар бичгэн ба аман хэлбэрээр нэмэлт санал зөвлөмж, тайлбар өгөх хүсэлтэй буйгаа зөвхөн энэхүү санал дүгнэлтээр хязгаарлахгүй гэдгийг онцлон тэмдэглэж байна.

Ш. ХУРААНГУЙ

10. ЕАБХАБ/АИХЭГ нь олон улсын өмнө хүлээсэн үүрэг хариуцлага, сайн стандартад нийцүүлэх үүднээс Монгол Улсын Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн талаар санал дүгнэлт гаргуулахаар ирүүлсэн санаачлагыг сайшаан хүлээн авлаа. Энэ чиглэлээр хууль эрх зүйн хувьд дорвитой дэвшил гарч буй нь харагдаж байгаа бөгөөд эвлэрүүлэн зуучлалын эрх зүйн орчныг бэхжүүлэх, зөвлөгөө авахаар хүчин чармайлт гаргаж буй нь сайшаалтай юм. Энэ санаачилга нь аливаа хуулийг уялдаа холбоотой батлах боломжийг бүрдүүлж байгаа бөгөөд тухайлбал, эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд оролцогчдын эрх, үүргийн талаарх зохицуулалт эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд бүхэлд нь орсон байна.
11. Хуулийн 3.1-д заасны дагуу эвлэрүүлэн зуучлалыг өргөн хүрээний маргаан (иргэний, хөдөлмөрийн, гэр бүлийн г.м.) шийдвэрлэхэд ашиглаж болох нь нааштай харагдаж байна. Цаашилбал, холбогдох хууль тогтоомжоор зөвшөөрвөл бусад чиглэлээр эвлэрүүлэн зуучлалыг ашиглах үүд хаалга нээлттэй байна. Үүнийг Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 6.1-д зааснаас холбогдох бусад хууль тогтоомжид илүү тусгаж тодруулж өгөх нь зүйтэй. [31 дэх хэсэг]
12. Түүнчлэн Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 30.1-д зааснаас үзвэл Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль нь заавал шүүхээс санал болгохгүйгээр хийгдэх эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд хамаарч буй эсэхийг тодруулах шаардлагатай байна. Монгол Улсад эвлэрүүлэн зуучлал хийх боломжийг нэмэгдүүлэхийн тулд хувийн эвлэрүүлэн зуучлах ажиллагааг хамруулах нь зүйтэй. [34 дэх хэсэг]
13. Илүү тодруулбал, дээр дурьдсанаас гадна хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийг боловсронгуй болгох үүднээс ЕАБХАБ/АИХЭГ нь дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

³ Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай НҮБ-ын конвенц (цаашид “CEDAW” гэх) нь Ерөнхий Ассемблейн 1979 оны 12-р сарын 18-ны өдрийн 34/180 дугаар тогтоолоор батлагдсан. Монгол Улс 1981 оны 7-р сарын 20-нд энэхүү конвенцэд нэгдэв.

⁴ МС.DEC/14/04 (2004), №14/04 тоот шийдвэрээр батлагдсан Жендерийн тэгш байдлыг дэмжих ЕАБХАБ-ын үйл ажиллагааны төлөвлөгөөний 32-р хэсгийг эндээс үзнэ үү: <http://www.osce.org/mc/23295?download=true>.

Монгол Улсын Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд өгөх АИХЭГ-ын санал дүгнэлт

- A. Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 1.1-д заасан “эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр” гэсэн утгыг тодруулах буюу эвлэрүүлэн зуучлагчийн үүргийг илүү нарийвчлан тодорхойлох.; [28 дахь хэсэг]
- B. Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 32.1 дэх заалт нь талууд эвлэрүүлэн зуучлах ажиллагааг өмнө нь явуулаад амжилтанд хүрээгүй байсан ч хэргийг шүүхэд гаргасны дараа гэр бүлийн холбогдолтой маргаан дээр эвлэрүүлэн зуучлах ажиллагааг дахин явуулах боломжийг баталж чадахгүй байна. Ийм боломжийг зөвхөн гэр бүлийн холбогдолтой маргаанаар хязгаарлахгүй байхыг зөвлөж байна. [35 дахь хэсэг]
- C. Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 4.1.1-д заасан эвлэрүүлэн зуучлалын тодорхойлолт нь тодорхой биш байгаа тул уг тодорхойлолтыг дахин хянан үзэж, боломжтой бол Сингапурын эвлэрүүлэн зуучлалын конвенцэд заасан *талууд маргаанаа шийдвэрлэхдээ маргалдагч талуудад аливаа шийдлийг тулгах эрх мэдэлгүй гуравдагч этгээд (“эвлэрүүлэн зуучлагч”)-ийн тусламжтай эвийн журмаар шийдэлд хүрэхээр эрмэлзэх үйл явцыг хэлнэ* гэж тодорхойлсон тодорхойлолтыг хэрэглэхийг зөвлөж байна. [37 дахь хэсэг]
- D. Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 4.1.2-т заасан “иргэн” гэсэн нэр томъёог гадаадын иргэдийг эвлэрүүлэн зуучлалаас хасахгүйн тулд “хувь хүн” гэсэн нэр томъёогоор солих. Түүнчлэн Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн хэд хэдэн зүйлд “оролцогч(ид)” гэсэн нэр томъёог мөн ашигласан байгаа тул 4-р зүйлд заасан “талууд” гэсэн нэр томъёонд нэгэн жигд нэр томъёог хэрэглэхийг зөвлөж байна. Үүнийг хуульд бүхэлд нь тууштай баримтлах нь зүйтэй; [хэсэг 38]
- E. Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 5.2-т “сайн дурын” гэсэн зарчмыг талуудын сайн дураар шийдвэр гаргах явдлыг бүрдүүлэхийн тулд тодорхой болгох нь зүйтэй; [48 дахь хэсэг]
- F. Хуулийн 12.1-т заасан эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд оролцогчдыг тодруулах, зуучлах ажиллагаанд оролцож буй талууд болон эвлэрүүлэн зуучлагчид зөвшөөрвөл бусад оролцогчдыг оролцуулах боломжийг өгөх. Түүнчлэн талууд эвлэрүүлэн зуучлагчтайгаа зөвлөлдөөд тохирвол өмгөөлөгч, орчуулагч, хэлмэрч болон бусад хүмүүсээс зохих тусламжийг авах боломжийг талуудад олгох нь зүйтэй; [51 дэх хэсэг]
- G. Талууд зөвхөн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан оролцохоос гадна биечлэн оролцох боломжийг олгох үүднээс 12.3 дахь заалтыг өөрчлөхийг зөвлөж байна. Технологийн хэрэгслээр дамжуулан биечлэн оролцохыг зөвшөөрөх нь зүйтэй; [52 дахь хэсэг]
- H. Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 22.1 болон 22.3-д заасан эвлэрүүлэн зуучлагчийг сонгох хугацааг оруулахыг зөвлөж байна. Түүнчлэн хэнд хандан хүсэлт гаргахыг тодруулах хэрэгтэй. [67 дахь хэсэг]
- I. Хуулийн 9.1.1 дэх заалтаар эвлэрүүлэн зуучлагчийг “хууль ёсны эрхтэй” байх тухай шаардлагыг тодруулах хэрэгтэй. Энэ нь эвлэрүүлэн зуучлагчийг эрх зүйн бүрэн чадамжтай, эсвэл эрх зүйч мэргэжилтэй байх, эсвэл үүнтэй ижил төстэй зэрэгтэй байх ёстой гэдэг нь тодорхойгүй байна. Эвлэрүүлэн зуучлагчийг хуулийн ямар нэг зэрэгтэй байх шаардлагыг тавихгүй байхыг зөвлөж байна. [70 дахь хэсэг]

Монгол Улсын Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд өгөх АИХЭГ-ын санал дүгнэлт

Нэмэлт зөвлөмжүүдийг хараар тодруулсан бөгөөд санал дүгнэлтийн хэсэгт багтаасан болно.

IV. ДҮН ШИНЖИЛГЭЭ БА ЗӨВЛӨМЖ**1. Эвлэрүүлэн зуучлалын тухай олон улсын стандартууд**

14. Эвлэрүүлэн зуучлал гэдэг нь хоёр ба түүнээс дээш талуудын хоорондох маргааныг шийдвэрлэхэд төвийг сахисан гуравдагч этгээд дэмжлэг үзүүлэн оролцох үйл явц гэж ерөнхийдөө ойлгодог. Эвлэрүүлэн зуучлах ажиллагааг явуулахад чухам ямар элементүүд шаардлагатай байдаг, мөн маргаан шийдвэрлэх бусад хувилбаруудаас юугаараа эвлэрүүлэн зуучлалын ажиллагаа ялгаатай вэ гэсэн нийтлэг, эсвэл нарийн тодорхой заасан тодорхойлолт байдаггүй тул энэхүү санал дүгнэлтээр эвлэрүүлэн зуучлах үйл явцыг өргөн хүрээнд тодорхойлон авч үзсэн болно. Тиймээс дотоодын болон олон улсын хууль тогтоогчдын хувьд харьцангуй шинэ сэдэв учраас эвлэрүүлэн зуучлалын үйл явц, хэрэгжүүлэх ажиллагаанд тусгайлан тохируулсан, олон улсын стандартыг суулгаж өгсөн баримт бичгийн тоо хэмжээ харьцангуй хязгаарлагдмал хэвээр байна.
15. Гэсэн хэдий ч Монгол Улсын нэгдэн орсон олон улсын хүний эрхийн чиглэлээрх стандартуудыг тогтоосон түгээмэл конвенцүүд болон бусад баримт бичгүүд нь эвлэрүүлэн зуучлах ажиллагаа, түүнийг хэрэгжүүлэх арга замуудад хамааралтай. Ялангуяа, шударга шүүхээр шүүлгэх эрх, шүүхэд хандах эрх, шүүхийн өмнө эрх тэгш байх зэрэг нь эвлэрүүлэн зуучлалын ажиллагааг зохицуулж буй хууль тогтоомжоор мөн хөндөгдөж болзошгүй. Тиймээс энэ асуудалд Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт⁵ (ICCPR)-ын шударга шүүхээр шүүлгэх эрхийн тухай 14 дүгээр зүйл хамааралтай. Пактын 14 дүгээр зүйлд шүүх ба тусгай шүүхийн өмнө эрх тэгш байх, гэм буруутай нь тодорхой хуулиар нотлогдох хүртэл гэм буруугүй гэж тооцогдох эрхийг баталгаажуулсан; уг эрхийн энэ хэсгийг эвлэрүүлэн зуучлах ажиллагааны бүхий л явцад цуглуулсан мэдээллийг шүүхэд зарга мэдүүлэх, эсвэл шүүх дээр ашиглахдаа зөрчиж болзошгүй юм.
16. Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа нь эмэгтэйчүүдийн эрх, хүүхдийн эрх, ялангуяа эрүүгийн хэрэг болон гэр бүлийн холбогдолтой асуудлууд дээр хөндөгдөх тохиолдолд НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвенц⁶ (CRC) болон Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай НҮБ-ын конвенц⁷ (CEDAW) зэрэг нь холбогдох хууль тогтоомж, тэдгээрийг хэрэгжүүлэхэд дагаж мөрдөх ёстой олон улсын стандарт болж байна. Эвлэрүүлэн зуучлах үйл явцын онцлог болоод зорилго нь оролцогчдын хооронд найрсаг харилцааг хадгалахад зорьдог тул эвлэрүүлэн зуучлал нь гэр бүлийн холбогдолтой маргаан, түүний дотор асран хамгаалахтай холбоотой асуудлуудад маш сайн тохирдог. Тиймээс Хүүхдийн эрхийг хэрэгжүүлэх тухай европын конвенцид хүүхдэд хамааралтай маргааныг шийдвэрлэхэд

⁵ НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1966 оны 12-р сарын 16-ны өдрийн 2200А (XXI) тогтоолоор баталсан *НҮБ-ын Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт* (ICCPR). Монгол Улс 1974 оны 11-р сарын 18-ны өдөр уг пактыг соёрхон баталсан.

⁶ 1989 оны 11-р сарын 20-ны өдөр батлагдсан *НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвенц* (CRC/ХЭК), 1990 оны 9-р сарын 2-нд хүчин төгөлдөр болсон, 1577 UNTS 3. Монгол Улс 1990 оны 7-р сарын 5-нд энэхүү конвенцид нэгдэн орсон.

⁷ 1979 оны 12-р сарын 18-ны өдөр батлагдсан *НҮБ-ын Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенц* (CEDAW) нь 1981 оны 9-р сарын 3-ны өдөр хүчин төгөлдөр болсон, 1249 UNTS 13. Монгол Улс 1981 оны 7-р сарын 20-нд энэхүү конвенцид нэгдэн орсон.

Монгол Улсын Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд өгөх АИХЭГ-ын санал дүгнэлт

эвлэрүүлэн зуучлал нь илүү тохиромжтой арга гэж тодорхой заасан байдаг.⁸ Монгол Улс хэдийгээр энэ бүс нутгийн зохицуулалтаар үүрэг хүлээдэггүй ч уг конвенц нь энэ агуулгад тохирох удирдамж байж болох юм.

17. ЕАБХАБ-ын түвшинд, ЕАБХАБ-ын өмнө хүлээсэн үүрэг амлалтуудаар эвлэрүүлэн зуучлалд хүрэх боломж нь эрхийг хамгаалах үр дүнтэй арга хэрэгслүүдийн нэг төдийгүй шүүх, захиргааны болон эвлэрлийн журам зохицуулалтуудын хамт шударга ёсыг хүртэх боломж гэж томъёолж өгсөн.⁹
18. Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 2.2 дахь зүйлд олон улсын гэрээгээр хүлээсэн үүрэг хариуцлагыг тусгайлан заажээ. Үүнийг анхаарахын зэрэгцээ Эвлэрүүлэн зуучлалын үр дүнд байгуулах олон улсын маргаан шийдвэрлэх хэлэлцээрийн тухай НҮБ-ын конвенц¹⁰ (цаашид “Сингапурын эвлэрүүлэн зуучлалын конвенц” гэх)-ийг лавлагаа болгон зааж өгөх хэрэгтэй. Монгол Улс энэхүү конвенцид гарын үсэг зураагүй, соёрхон батлаагүй байгаа¹¹ тул заавал дагаж мөрдөх үүрэг хүлээгээгүй гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Ямар ч тохиолдолд, цаашид эрх зүйн шинэчлэл хийх бол Сингапурын конвенцийн заалтуудыг анхаарч үзэхийг зөвлөж байна. Учир нь энэ хуулийг хянан үзэхэд уг конвенцийн заалтууд нь чухал лавлагаа баримт бичиг болж болох юм.
19. НҮБ-ын Олон улсын худалдааны эрх зүйн комисс (цаашид “UNCITRAL” гэх)-оос эвлэрүүлэн зуучлал, маргаан шийдвэрлэхтэй холбоотой өөрийн Загвар хууль буюу Олон улсын арилжааны зуучлалын болон зуучлалын үр дүнд байгуулах олон улсын маргаан шийдвэрлэх хэлэлцээрийн тухай ЮНСИТРАЛЫН Загвар хууль (2018) (цаашид “ЮНСИТРАЛ Загвар хууль” гэх)-д саяхан нэмэлт өөрчлөлт оруулсан ба уг хууль нь энэ чиглэлээр хууль тогтоомж батлах гэж буй улс орнуудын хувьд стандарт гарын авлага болохуйц хууль байж болох юм.¹² Загвар хуулийн 1.3 дахь заалтад “эвлэрүүлэн зуучлал” гэсэн нэр томъёог өргөн хүрээнд тодорхойлон ашигласан бөгөөд “гэрээний, эсвэл бусад эрх зүйн харилцаатай холбоотой маргааныг эвийн журмаар шийдвэрлэхэд гуравдагч этгээдийг ашиглах тухай” гэж заажээ.¹³ Загвар хуулийг дотоодын хэрэг маргаанууд дээр ч ашиглаж болно.¹⁴ Тиймээс энэ утгаараа хууль боловсруулагчдад тустай байж болох юм.
20. Монгол Улс нь Европын Зөвлөл (цаашид “ЕЗ” гэх)-ийн гишүүн улс биш тул ЕЗ-тэй холбогдох лавлагаа баримт бичгүүдийг харьцуулан харах талаас нь авч үзвэл ач холбогдолтой юм. Тэгээд ч энэ асуудлаар олон улсын эх сурвалж хязгаарлагдмал байгааг харгалзан үзэх нь зүйтэй. ЕЗ-д байдаг Шүүхийн үр нөлөөтэй байдлын талаарх Европын комисс (СЕРЕJ)-оос захиргааны эрх бүхий байгууллагууд болон хувийн талуудын хооронд үүссэн эрх зүйн янз бүрийн асуудлуудаар, тухайлбал гэр бүл, иргэний болон эрүүгийн хэрэг, маргаантай холбоотой эвлэрүүлэн зуучлах

⁸ 1996 оны 6-р сарын 25-нд батлагдсан [Европын Зөвлөлийн Хүүхдийн эрхийг хэрэгжүүлэх тухай Европын конвенц](#) нь 2000 оны 7-р сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр болсон, CETS No. 160.

⁹ Дараахыг үзнэ үү: ЕАБХАБ-ын III. 9 нутаг дэвсгэр доторх Рома, Синти нарын байдлыг сайжруулах талаар авах арга хэмжээний төлөвлөгөөний № 3/03 шийдвэрийн хавсралт.

¹⁰ [Эвлэрүүлэн зуучлалын үр дүнд байгуулах олон улсын маргаан шийдвэрлэх хэлэлцээрийн тухай НҮБ-ын конвенц](#), Тогтоолыг Ерөнхий Ассемблей 2018 оны 12-р сарын 20-ны өдөр баталсан. Монгол Улс энэхүү конвенцид хараахан гарын үсэг зураагүй, нэгдэн ороогүй байгаа.

¹¹ Монгол Улс 2019 оны 8-р сарын 7-ны өдөр Сингапурт болох гарын үсэг зурах ёслолд оролцох төлөөлөгчдийг илгээлээ: <https://www.montsame.mn/en/read/197778>

¹² [Олон улсын арилжааны зуучлалын болон зуучлалын үр дүнд байгуулах олон улсын маргаан шийдвэрлэх хэлэлцээрийн тухай ЮНСИТРАЛЫН Загвар хууль \(2018\)](#): https://uncitral.un.org/sites/uncitral.un.org/files/media-documents/uncitral/en/annex_ii.pdf

¹³ [Олон улсын арилжааны зуучлалын болон зуучлалын үр дүнд байгуулах олон улсын маргаан шийдвэрлэх хэлэлцээрийн тухай ЮНСИТРАЛЫН Загвар хууль \(2018\)](#)

Энэ баримт бичгийн 12 дахь болон 3 дахь ишлэлд дурдсан, (Олон улсын худалдааны эвлэрлийн тухай UNCITRAL Загвар хуулийн II хавсралт).

Монгол Улсын Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд өгөх АИХЭГ-ын санал дүгнэлт

ажиллагаанд зориулсан чухал стандартуудын доод түвшинг зааж өгсөн дөрвөн зөвлөмж гаргасан.¹⁵ Эдгээр стандартыг дагалдаж, зөвлөмжүүдийг тайлбарласан гурван багц удирдамж гарсан.¹⁶ Гэр бүлийн холбогдолтой маргаан болон иргэний хэрэг дээр эвлэрүүлэн зуучлал хийхтэй холбоотой одоо байгаа зөвлөмжийг илүү сайн хэрэгжүүлэхэд зориулан гаргасан удирдамж (цаашид “Гэр бүлийн болон иргэний хэрэг дээр эвлэрүүлэн зуучлал хийх тухай СЕРЕJ-ийн удирдамж” гэх)-даа СЕРЕJ нь гэр бүлийн маргаан дээр хийх эвлэрүүлэн зуучлалын онцлог байдлыг харгалзан үзэхийн зэрэгцээ Европын Холбооны Европын эвлэрүүлэн зуучлагчдын ёс зүйн дүрмийг иргэний болон гэр бүлийн холбогдолтой маргаанд зуучлал хийхдээ стандартын доод хэмжээ болгон баримтлахыг зөвлөмж болгосон.¹⁷ СЕРЕJ мөн саяхан Эвлэрүүлэн зуучлалын үйлчилгээ үзүүлэгчдийн Европын ёс зүйн дүрэм (2018 оны 12-р сар)-ийг боловсруулсан, тиймээс энэ дүрэм ч бас нэгэн чухал лавлах баримт бичиг юм.

21. Мөн Европын Холбооны хүрээнд Удирдамж 2008/52/ЕС¹⁸ (цаашид “Эвлэрүүлэн зуучлалын тухай Европын удирдамж” гэх) нь гишүүн орнуудын иргэний болон арилжааны асуудлаар эвлэрүүлэн зуучлал хийх стандартыг тогтоож өгсөн. Хэдийгээр Монгол Улс энэ удирдамжаар үүрэг хүлээгээгүй ч уг удирдамж нь эвлэрүүлэн зуучлалын стандартыг, ялангуяа нууцлалтай холбоотой асуудлаар, эвлэрүүлэн зуучлах явцад олж авсан мэдээллийг нотлох баримт болгон ашиглах стандартыг тогтоосон тул хууль тогтоогчид болон бусад оролцогч талуудад үнэ цэнтэй хэрэгсэл болж чадах юм.
22. Эрүүгийн хэрэг дээр мөн эвлэрүүлэн зуучлалыг хэрэглэхийг дурдахын зэрэгцээ эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд хохирогчдын байр суурийг хөндсөн олон улсын стандарт тогтоосон бусад баримт бичгүүдэд зөрчил, мөргөлдөөнийг шийдвэрлэх өөр альтернатив арга хэрэгсэл гэж санал болгосон байдаг.¹⁹
23. Эцэст нь, эвлэрүүлэн зуучлах ажиллагаа нь НҮБ-ын түвшинд мөргөлдөөнийг тайван замаар шийдвэрлэхэд энх тайвныг тогтоох үйл явц, мөн угсаатан хоорондын

¹⁵ Эдгээр нь Орлогч сайд нарын 1998 оны 1-р сарын 21-ний өдрийн 616-р хурлаар Сайд нарын хорооны баталсан *Гэр бүлийн эвлэрүүлэн зуучлалын асуудлаарх гишүүн улсуудын Сайд нарын хорооны Европын зөвлөлийн No. R (98) 1 зөвлөмж*; Орлогч сайд нарын 1999 оны 9-р сарын 15-ны өдрийн 679-р хурлаар Сайд нарын хорооноос баталсан *Эрүүгийн хэрэг дээр эвлэрүүлэн зуучлал хийх тухай Гишүүн орнуудын Сайд нарын хорооны No. R (99) 19 зөвлөмж*; Орлогч сайд нарын 2001 оны 9-р сарын 5-ны өдрийн 762-р хурлаар Сайд нарын хорооноос баталсан *эрх бүхий захиргааны байгууллагууд болон хувийн талуудын хооронд маргаан хянан шийдвэрлэх альтернатив хувилбаруудын талаарх Гишүүн орнуудын Сайд нарын хорооны (2001)9 зөвлөмж*; Орлогч сайд нарын 2002 оны 9-р сарын 18-ны өдрийн 808-р хурлаар Сайд нарын хорооноос баталсан *иргэний хэрэг дээр эвлэрүүлэн зуучлах тухай Гишүүн орнуудын Сайд нарын хорооны (2002)10 зөвлөмж* зэрэг болно. Дөрвөн зөвлөмжийг эндээс үзнэ үү: http://www.coe.int/t/dghl/cooperation/cepej/series/Etudes5Ameliorer_en.pdf.

¹⁶ Шүүх засаглалын үр ашгийг дээшлүүлэх Европын комисс (цаашид “СЕРЕJ” гэх), 2007 оны 12-р сарын 7-ны өдөр батлагдсан *Гэр бүлийн холбогдолтой маргаан болон иргэний хэрэг дээр одоо байгаа зөвлөмжийг илүү сайн хэрэгжүүлэх тухай удирдамж*, СЕРЕJ (2007)14; *Эрүүгийн хэрэг дээр эвлэрүүлэн зуучлал хийхэд одоо байгаа зөвлөмжийг илүү сайн хэрэгжүүлэх тухай удирдамж*, СЕРЕJ (2007)13; *Эрх бүхий захиргааны байгууллагууд болон хувийн талуудын хоорондох маргаан шийдвэрлэх альтернатив хувилбарууд дээр одоо байгаа зөвлөмжийг илүү сайн хэрэгжүүлэх тухай зөвлөмж*, СЕРЕJ (2007)15.

¹⁷ 1.8 дээрх 16 дахь ишлэлд дурдсан (Гэр бүлийн холбогдолтой маргааны эвлэрүүлэн зуучлал, иргэний хэрэг дээрх эвлэрүүлэн зуучлалын талаарх СЕРЕJ удирдамж); Мөн Европын Зөвлөлийн *Сербийн Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн төсөлд өгсөн Хүний эрх, эрх зүйт ёсны Ерөнхий газар Хууль зүй ба эрх зүйн хамтын ажиллагааны газрын санал дүгнэлт*, 2013 оны 4-р сарын 23-ны өдөр, 14-р хуудсыг үзнэ үү; мөн *Европын эвлэрүүлэн зуучлагчдын ёс зүйн дүрэм*. (2004)-ийг үзнэ үү.

¹⁸ Иргэний болон арилжааны маргаан дээрх эвлэрүүлэн зуучлалын тодорхой асуудлаар гаргасан Европын парламентын болон Зөвлөлийн 2008 оны 5-р сарын 21-ний өдрийн *2008/52/ЕС Удирдамж*.

¹⁹ Европын Зөвлөл, *Эрүүгийн гэмт хэргийн хохирогчдод үзүүлэх тусламжийн талаарх зөвлөмж Rec(2006)8*, 2006 оны 6-р сарын 14; Эрүүгийн хууль, процедурын хүрээнд хохирогчийн байр суурийн талаарх *Зөвлөмж №. (85)11*, 1985 оны 6-р сарын 28; *Хохирогчдод үзүүлэх тусламж, хохирогч болохоос урьдчилан сэргийлэх тухай R (87) 21 зөвлөмж*, 1987 оны 9-р сарын 17; НҮБ-ын Ерөнхий Ассемблейн 40/34-р тогтоол, *Эрүүгийн гэмт хэрэг болон эрх мэдлээ урвуулан ашигласан гэмт хэргийн хохирогчдод үзүүлэх шударга ёсны үндсэн зарчмуудын тунхаглал* (1985 оны 11-р сарын 29), GAOR-ын 40-р чуулганы нэмэлт 53, 213; *Гэмт хэргийн хохирогчдын хүний эрх, тэдэнд үзүүлэх дэмжлэг, хамгаалалтын талаарх стандартын доод хэмжээг тогтоох тухай Европын парламентын болон Зөвлөлийн 2012 оны 10-р сарын 25-ны Удирдамж 2012/29/EU*, Зөвлөлийн 2001/220/JHA шийдвэрийг сольсон.

Монгол Улсын Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд өгөх АИХЭГ-ын санал дүгнэлт

зөрчлийг шийдвэрлэх, урьдчилан сэргийлэхтэй холбоотой асуудлууд дээр ихэвчлэн хэрэглэгддэг арга хэрэгсэл юм. Эдгээртэй холбогдох стандартыг тогтоосон гарын авлага нь Үр дүнтэй зуучлалын тухай НҮБ-ын удирдамж (2012)²⁰ бөгөөд ялангуяа олон янзын угсаатантай газар нутагт эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд хамрагдахын ач холбогдлыг онцолсон баримт бичиг болно.²¹ ЕАБХАБ-ын түвшинд маргааныг тайван замаар шийдвэрлэх нь Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны бага хурлын Хельсинкийн төгсгөлийн баримт бичигт заасан арван зарчмын нэг бөгөөд үүнд эвлэрүүлэн зуучлалыг мөргөлдөөнийг тайван замаар шийдвэрлэх нэг арга хэрэгсэл хэмээн тодотгож өгсөн.²² Энэ мэтээр эвлэрүүлэн зуучлал нь ЕАБХАБ-ын хүрээнд оролцогч орнуудын зүгээс өөрсдийн дотоодын, бүс нутгийн болон олон улсын зөрчил мөргөлдөөнийг урьдчилан сэргийлэх, төгсгөл болгох нэгэн үүрэг амлалт болгон авч үздэг онцгой статустыг эзэлдэг. Энэхүү үүрэг амлалтыг ЕАБХАБ-ын баримт бичгүүд, ялангуяа Жендерийн мэдрэмжтэй эвлэрүүлэн зуучлалыг нэмэгдүүлэх удирдамж бичиг²³ болон Эртнээс сануулах, эртнээс арга хэмжээ авах, яриа хэлэлцээг хөнгөвчлөх, эвлэрүүлэн зуучлалыг дэмжих, мөн зөрчил мөргөлдөөний дараа сэргээн босгох ажиллагааны асуудлуудаар ЕАБХАБ-ын чадавхыг сайжруулахтай холбоотой мөргөлдөөний элементүүдийн талаарх ЕАБХАБ-ын Сайд нарын зөвлөлийн 3/11 тоот шийдвэр²⁴ болон бусад баримт бичгээр дахин баталгаажуулан, боловсруулсан болно.²⁵

2. Хуулийн зорилт ба үйлчлэх хүрээ

2.1. Ерөнхий тайлбарууд

24. Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль нь 35 зүйлийг зургаан бүлэгт хуваан багтаажээ. Хуулийн 5.2.1 дэх зүйлд зааснаар эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд орох нь сайн дурын үндсэн дээр гэсэн боловч хэрэв эвлэрүүлэн зуучлалыг сонгосон тохиолдолд хуульд өөрөөр заагаагүй л бол заавал биелүүлэхээс аргагүй болж байна. Ерөнхийдөө, эвлэрүүлэн зуучлалын тухай хуулиудыг хооронд нь дефолт буюу үл биелүүлэх дүрэм байдлаар үйлчлэх (“талууд өөрөөр санал нийлээгүй бол”), эсвэл заавал дагаж мөрдөх гэж ялгаж болдог.²⁶ Үл биелүүлэх дүрэм гэдэг нь талуудын бие даасан байдал гэдэг ойлголтыг дэмжихэд чиглэдэг ба талуудын зүгээс эсрэг талдаа тохиролцоо байхгүй гэдгээ илэрхийлэх үед зөвхөн хэрэглэгддэг. Маргалдагч талын бие даасан байдлын зарчим нь эвлэрүүлэн зуучлалын гол тулгуур багана болдог бөгөөд талуудын зүгээс эвлэрүүлэн зуучлах үйл явцыг хэрхэн бий болгох, түүний үр дүнг тодорхойлоход туслах чадварууд дээр нь тусгалаа олдог. Тиймээс эвлэрүүлэн зуучлах ажиллагааны талаарх зохицуулалтууд нь ихэвчлэн үл биелүүлэх дүрмийн хэлбэрийг оруулж өгдөг бөгөөд ингэснээр талууд үүнээс татгалзаж болдог.

²⁰ [НҮБ-ын Үр дүнтэй эвлэрүүлэн зуучлал хийх тухай удирдамж](#) (Нью-Йорк, 2012).

²¹ Түүнчлэн Элчин сайд Фред Таннер (ЕАБХАБ-ын дарга-Швейцарь) [“Эвлэрүүлэн зуучлах ажиллагаан дахь оролцоо”](#) сэдвээр Урьдчилан сэргийлэх дипломат ажиллагаа, эвлэрүүлэн зуучлалын тухай бүс нутаг, дэд бүсийн болон бусад олон улсын байгууллагын 3-р хурал дээр (2014 оны 2-р сарын 5-ны өдөр) хэлсэн үгийг үзнэ үү.

²² ЕАБХАК/CSCE, [Европын Аюулгүй Байдал, Хамтын Ажиллагааны Бага Хурлын Төгсгөлийн баримт бичиг](#) (1975 оны 8-р сарын 1-ний өдөр) 14 ILM 1292.

²³ ЕАБХАБ-ын Нарийн бичгийн дарга нарын газар, OSG/Жендерийн алба, Вена, 2013 оны 10-р сар, эндээс үзнэ үү: <http://www.osce.org/gender/107533?download=true>.

²⁴ ЕАБХАБ МС.ДЕС/3/11 (2011 оны 12-р сарын 27), эндээс үзнэ үү: <http://www.osce.org/mc/86621?download=true>.

²⁵ Мөн дараахыг үзнэ үү: НҮБ-тай хамтран боловсруулсан ЕАБХАБ-НҮБ, [Урьдчилан сэргийлэх дипломат ажиллагаа, маргааныг хөнгөвчлөх яриа хэлэлцээ ба эвлэрүүлэн зуучлах ажиллагааны талаарх НҮБ болон бүс нутгийн байгууллагуудын хэтийн төлвийн тайлан: Нийтлэг сорилт ба сайн туршилага](#) (2011 оны 2-р сар).

²⁶ Дараахыг үзнэ үү: Н Eidenmüller “Үндэсний болон олон улсын эвлэрүүлэн зуучлах ажиллагааны эрх зүйн орчин” (2002) 12, *Олон улсын маргаан шийдвэрлэх этгүүл* 15-ын 14. (Н Eidenmüller, ‘A Legal Framework for National and International Mediation Proceedings’ (2002) 12 *Journal of International Dispute Resolution* Beilage 14 at 15.)

Монгол Улсын Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд өгөх АИХЭГ-ын санал дүгнэлт

Эсрэгээр, эрх зүйн зохицуулалт нь эвлэрүүлэн зуучлал ба хууль эрх зүйн тогтолцоог хооронд нь холбож өгдөг холбоос (жишээ нь, эвлэрүүлэн зуучлалд оролцсон хүмүүсийн үүрэг) болж байвал тэдгээр зохицуулалтыг нэг мөр байдлыг хангахын тулд үл биелүүлэх хэлбэрээс илүү албадлагын буюу заавал дагаж мөрдөх хэлбэрийг авах ёстой гэсэн хүчтэй аргумент байдаг. **Тиймээс Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд заасан үүрэг, хариуцлагатай холбоотой заалтуудыг бүрхэг биш, харин заавал дагаж мөрдөх заалтууд гэдгийг нь маш тодорхой тусгахыг зөвлөж байна** (мөн доор буй 7-ын дэд хэсгийг үзнэ үү).

25. Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль нь таван үндсэн сэдвийг хамарсан байна. Нэгдүгээрт, хуулийн цар хүрээ, зорилгыг нарийвчлан тодорхойлсон. Хоёрдугаарт, эвлэрүүлэн зуучлах ажиллагаа хэрхэн хөндөгдөх болон эхлүүлэх талаар холбогдох заалтуудыг оруулсан. Гуравдугаарт, эвлэрүүлэн зуучлах ажиллагаа, зуучлалын үйл явц хэрхэн хийгдэх талаар нарийвчлан заажээ. Дөрөвдүгээрт, хуульд эвлэрүүлэн зуучлагчаар хэн оролцож болох талаар тайлбарласан заалтууд байна. Тавдугаарт, эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд оролцогчдын эрх, үүргийг тодорхойлжээ. Үүний зэрэгцээ, эдгээр сэдвийн зарим нь, тухайлбал, эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд оролцогчдын эрх, үүрэгтэй холбоотой заалтууд нь хуулийн энд тэнд орсон байна. Үүнийг эрх, үүргийн тухай үндсэн заалтууд дор багтаан зааж өгсөн бол илүү тодорхой ойлгомжтой болно. **Тиймээс сэдвүүдийг илүү тодорхой, цогц байдлаар харуулахын тулд хуулийн ерөнхий бүтцийг шинэчлэн засахыг зөвлөж байна.**
26. Дэлхий даяар буй эвлэрүүлэн зуучлалын системийг олон улсын хэмжээнд харьцуулан харахад бодлого боловсруулагчид болон хууль тогтоогчдод хэрэгтэй эвлэрүүлэн зуучлалын янз бүрийн загварууд байна. Хэрэв эдгээр загвараас хэд хэдийг нэгтгээд ашиглавал хүмүүст эвлэрүүлэн зуучлах аргыг авах боломжийг нэмэгдүүлэх сайн талтай. Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийг уншихад шүүхээр дамжуулж эвлэрүүлэн зуучлал авах (ө.х, шүүхэд хандан эвлэрүүлэн зуучлал хүсэх нэгдсэн арга нь эвлэрүүлэн зуучлалын үйлчилгээ авах гол арга байх)²⁷ болон хувийн/зах зээлийн журмаар эвлэрүүлэн зуучлал авах гэсэн арга хоёулаа Монгол Улсад ерөнхийдөө байгаа юм шиг сэтгэгдэл төрж байна. Энэ нь бүхэлдээ эерэг сайн зүйл боловч Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль нь зөвхөн шүүхтэй холбоотой эвлэрүүлэн зуучлалын ажиллагаанд л хамааралтай нь харагдаж байна (Доор буй 31, 32-р хэсгийг үзнэ үү). Уг хуульд эвлэрүүлэн зуучлалын бусад хэлбэрүүд²⁸ хамааран зохицуулагдах эсэх нь тодорхойгүй байна. Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 8-р зүйлд энэ талаар хөндсөн байж магадгүй, гэхдээ илүү тодорхой байх шаардлагатай. Цаашилбал, хил дамнуулан эвлэрүүлэн зуучлах ажиллагаа хийх, түүний сонирхол татахуйц байдал зэрэг нь, ө.х. хөрөнгө оруулалтын маргаан, нөөц баялагтай холбоотой зэрэг маргаанууд нь энэ чиглэлээр уг хуульд нэмэлт, өөрчлөлт

²⁷ Шүүхээр дамжуулан хийх эвлэрүүлэн зуучлах ажиллагаа нь өөрөө дараах загваруудад хуваагдаж болно. Үүнд: (1) шударга ёсны загвар буюу эвлэрүүлэн зуучлалын үйлчилгээ нь шүүх засаглалын тогтолцооны салшгүй хэсэг гэж тооцогддог учраас шүүхийн үйл ажиллагааны нэг чиглэл болдог ба шүүх дэх эвлэрүүлэн зуучлагчдыг шүүхээс гаргаж, шүүхийн ажилтнууд, шүүхэд ажилладаг зуучлагчдын бүрэлдэхүүнээс бүрдэх бөгөөд тэдгээр эвлэрүүлэн зуучлагчдыг шүүхээс сонгож, томилж, зуучлалын зардлыг шүүхийн байгууллага хариуцдаг (шүүх дэх эвлэрүүлэн зуучлалын шударга ёсны загварын жишээг Словени, Герман, Скандинавын зарим хэсэг, мөн бусад (ихэвчлэн иргэний хуульд) шүүхийн харьяалалуудаас харж болно, гэхдээ Сингапур зэрэг зарим нийтлэг хууль эрх зүйн харьяаллын улс орнууд ч энэ загварыг авсан байдаг); (2) зах зээлийн загвар буюу шүүхээр дамжуулан хийх эвлэрүүлэн зуучлалын хувьчлагдсан хэлбэрийг тусгасан загвар бөгөөд шүүх нь шүүхийн баталсан эвлэрүүлэн зуучлалын үйлчилгээ эрхлэгч байгууллагуудын гишүүдээс гэрээлэн зуучлалын үйлчилгээ авах ба тэдгээр байгууллагууд нь төлбөрөө өөрсдөө тогтоон, маргаантай этгээдүүдээс гаргуулан авдаг (ерөнхийдөө Канад, Австрали, Англи, Хонконг, АНУ зэрэг нийтийн эрх зүйтэй улс орнууд ашигладаг. Гэхдээ энэ загварыг Герман зэрэг зарим иргэний эрх зүйтэй улс орноос ч харж болно).

²⁸ Жишээ нь, нийгэмд суурилсан эвлэрүүлэн зуучлалын байгууллагууд болон дүрвэгсэд, эмэгтэйчүүдийн байр, засгийн газрын ивээн тэтгэдэг хууль эрх зүйн төвүүд, эрх зүйн туслалцаа, цагдаа гэх зэрэг бусад олон нийтийн байгууллагуудаар дамжуулан эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд өргөнөөр хамрагдах боломжтой.

Монгол Улсын Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд өгөх АИХЭГ-ын санал дүгнэлт

оруулах шаардлагатайг улам бүр чухалчлан харуулж байна (доор буй 83-д бичсэн тайлбарыг үзнэ үү). Эцэст нь, цаашид зөвлөмж авах шаардлагатай бол эвлэрүүлэн зуучлах ажиллагаа Монгол Улсад хэрхэн хэрэгжиж байгаа талаарх мэдээлэл, дүн шинжилгээн дээр үндэслэн боловсруулж болох юм. Тиймээс Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд бусад засвар хийх талаар саналаа өгөхөд энэ талын мэдээлэл авах нь тустай байна.

27. Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа нь уян хатан үйл явц бөгөөд энэ онцлог нь зуучлалын ажиллагааг зохицуулахад хүндрэл учруулдаг гэдгийг онцлон тэмдэглэх нь зүйтэй. Ерөнхийдөө, ийм уян хатан байдлыг тааруулахын тулд эвлэрүүлэн зуучлах ажиллагааг янз бүрийн хатуу (хууль тогтоомж) болон зөөлөн зохицуулалтаар буюу эвлэрүүлэн зуучлагчдын ёс зүйн дүрэм, институцын эвлэрүүлэн зуучлалын дүрэм журам болон салбарын бусад стандартууд, маргаан шийдвэрлэх өөр үүрэг амлалт, заалтууд зэргээр зохицуулж байх хэрэгтэй. Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд эвлэрүүлэн зуучлагчдын ёс зүйн дүрмийг дурдаж өгсөн (9.2-р зүйл) ч албан ёсны эвлэрүүлэн зуучлалын хууль тогтоомж л дангаар үйлчлэх ёсгүй гэдгийг онцлох нь чухал бөгөөд олон улсын түвшинд буй сайн туршлагаас харахад эрх зүйн бус зохицуулалтын хэлбэрээр Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийг нөхөж өгөх нь илүү тохиромжтой болохыг харуулж байна. Энэ үүднээс үзвэл, Эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөл (10, 11-р зүйлүүд) нь Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийг нөхөж өгөх зөөлөн бөгөөд илүү уян хатан зохицуулалтыг хүлээн авч буй нь сайшаалтай.

2.2. Хуулийн зорилт

28. Хуулийн зорилгыг 1.1-р зүйлд “эрх зүйн маргааныг шүүхийн бус аргаар эвлэрүүлэн зуучлагчдын дэмжлэгтэйгээр шийдвэрлэх эрх зүйн үндэслэл” гэж заажээ. “Дэмжлэг” гэсэн үгээр ямар утгыг илэрхийлэх гэсэн нь тодорхойгүй байна. **Иймд эвлэрүүлэн зуучлагчийн үүргийг илүү нарийвчлан тодруулахыг зөвлөж байна.**

29. Тодруулбал, хуулийн зорилгыг товч тодорхой тусгасан боловч шүүх эрх мэдлийн ажлын ачаалал, бизнесийн харилцаанд үзүүлэх эвлэрүүлэн зуучлалын үр өгөөжийн талаар, үүнээс гадна, хамгийн чухал нь, хувь хүмүүст эвлэрүүлэн зуучлалын ашиг тусын талаар илүү нарийн тодорхой тусгаж өгөх боломжтой; Түүнчлэн эвлэрүүлэн зуучлалыг хөхиүлэн дэмжих, үүнийг хуулиар зохицуулах учир шалтгааныг дэлгэрүүлж тайлбарлах хэрэгтэй.²⁹ Ийм байдлаар шүүх болон нөлөөлөлд өртсөн хүмүүсийн аль аль нь эвлэрүүлэн зуучлах аргын давуу талыг төдийгүй хэмжээ хязгаарыг нь, мөн эвлэрүүлэн зуучлал нь хувь хүмүүсийн авч болох бусад аргуудтай харьцуулахад ямар болохыг илүү сайн ойлгох болно.
30. Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 5.1-д эвлэрүүлэн зуучлах ажиллагааны зорилгыг нарийвчлан тодорхойлсон төдийгүй маргааныг үр ашигтай, шуурхай, эвийн журмаар шийдвэрлэх зорилтыг сайтар тодорхойлон тусгасныг тэмдэглэх нь зүйтэй. Ийм зорилтыг 1-р зүйлд яагаад тусгаагүй нь тодорхойгүй байгаа тул **эдгээр зорилтыг хуулийн зорилтын нэг хэсэг болгон, маргааныг илүү үр ашигтай байдлаар шийдвэрлэх, мөн бизнес, ажлын байр, гэр бүлийн харилцааг хамгаалах гэдэг утгаар 1 дэх зүйлд тодорхойлсон зорилт дор нэгтгэн оруулахыг санал болгож байна.**

²⁹ Дараахыг үзнэ үү: АИХЭГ, [Маргааныг эвлэрүүлэн зуучлалаар шийдвэрлэх тухай Киргиз Улсын хуулийн төслийн талаар болон бусад холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах талаар өгсөн санал дүгнэлт](#), 2015 оны 8-р сарын 5. 20-р догол мөр.

2.3. Хуулийн үйлчлэх хүрээ

31. Хуулийн 3.1-д зааснаар уг хууль нь гол төлөв иргэний эрх зүйн маргаан, хөдөлмөрийн болон гэр бүлийн харилцаанаас үүссэн маргаанд тус тус хэрэглэх эвлэрүүлэн зуучлалд хамаарна. Үүний зэрэгцээ 3.2 дахь зүйлд “эвлэрүүлэн зуучлалыг энэ хуулийн 3.1-д зааснаас бусад маргааныг шийдвэрлэхэд зөвхөн холбогдох хууль тогтоомжоор заасан тохиолдолд хэрэглэж болно” гэж заажээ. Тиймээс бусад салбарт эвлэрүүлэн зуучлалыг ямар хэмжээнд хэрэглэж болох нь тодорхойгүй байна. **Үүнийг уг хуульд тодотгож өгөх, эсвэл хууль тогтоомжийг бүрхэг, өргөн утгаар заахын оронд, харин тодорхой, ойлгомжтой заан оруулж өгөхийг зөвлөж байна.** Тухайлбал, Хуулийн 6.1 дэх заалтад эвлэрүүлэн зуучлах хүсэлт гаргах талуудын эрхийг тогтоож өгөхийн зэрэгцээ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 14-16 дугаар зүйлийг лавлагаа болгон зааж өгсөн байна.
32. Ялангуяа, эрүүгийн хэрэг дээр зарим тусгай журам баримталдаг хэдий ч эвлэрүүлэн зуучлал үйлчлэх эсэх нь тодорхойгүй байна. Энэ үүднээс зарчмын хувьд иргэний, захиргааны болон эрүүгийн хэрэг дээр эвлэрүүлэн зуучлах журам нь тус тусын зорилгоос хамаарч өөр хоорондоо эрс ялгаатай гэдгийг тэмдэглэх нь зүйтэй.³⁰ Тухайлбал, эрүүгийн бус хэрэг дээр үйлчлэх эвлэрүүлэн зуучлалын тодорхой зарчмууд нь эрүүгийн хэрэг дээр хэрэглэх эвлэрүүлэн зуучлалд хамаарахгүй бөгөөд өвөрмөц зорилгод нийцсэн, тусгай журмын дагуу зохицуулагдах ёстой байдаг. Ялангуяа хохирогч-гэмт хэрэгтэн хоёул оролцож буй эвлэрүүлэн зуучлах ажиллагаан дээр хохирогч, гэмт хэрэгтний аль аль нь эвлэрүүлэн зуучлах аргыг хэрэглэх хүсэлтэй байх, мөн болсон явдал/гэмт хэрэг, эсвэл үйлдсэн буруу үйлдлийн баримт фактууд дээр санал нэгдэх нь чухал юм. Эрүүгийн хэрэг дээр хэрэглэх эвлэрүүлэн зуучлалын бүх онцлогийг, түүний дотор хохирогчдод үзүүлж болох нөлөөллийг нарийвчлан авч үзэхийн тулд гэмт хэрэг үйлдсэн хүний эрхийг хамгаалах үүднээс **эрүүгийн хэрэгтэй холбоотой асуудлыг уг хуулинд тусад нь нэг хэсэг болгон авч үзэх, эсвэл бүр тусдаа өөр хуулиар шийдвэрлэхийг зөвлөж байна.**
33. Хуулийн 3.4 дэх заалтаар талуудын хууль ёсны ашиг сонирхол, эсвэл нийтийн эрх ашиг хөндөгдвөл эвлэрүүлэн зуучлах аргыг хэрэглэхгүй гэж заажээ. Энэ заалт юунд хамаатай нь тодорхойгүй байна. **Шүүх хэрэг маргааныг эвлэрүүлэн зуучлах журмаар шийдвэрлэх эсэхээ шийдэхдээ гуравдагч этгээдийн эрх, нийтийн ашиг сонирхлыг харгалзан үзэхийн тулд шалгуур үзүүлэлтийг сайтар тодорхойлох нь зүйтэй.**
34. Хуулийн 3.5-д зааснаар талууд маргааныг эвлэрүүлэн зуучлагчийн оролцоогүйгээр сайн дураараа, эсвэл эвийн журмаар шүүгчийн шийдвэргүйгээр шийдвэрлэвэл энэ хууль хамаарахгүй гэжээ. Орчуулгын асуудал л биш бол энэ заалт тодорхойгүй байна, гэхдээ **Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль нь эвлэрүүлэн зуучлал хэрэглэхийг шүүхээс санал болгоогүй тохиолдолд шүүхээс гадуур хийгдэх эвлэрүүлэн зуучлалд хамаарахгүй гэж ойлгогдож байгаа тул хувийн эвлэрүүлэн зуучлах ажиллагааг хассан байна.** Энэхүү тайлбарыг 30.1 дэх заалтаар дэмжиж байгаа мэт бөгөөд уг заалт нь Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн үйлчлэх хүрээг шүүхэд иргэний хэрэг маргаан үүсгэснээс хойш хамаарах байдлаар хязгаарласан байх ба, хэрэг маргаан шүүхэд үүсгэхээс өмнөх шүүхээс гадуурх хувийн эвлэрүүлэн

³⁰ *ibid.* догол мөр 23 (2015 АИХЭГ [Маргааныг эвлэрүүлэн зуучлалаар шийдвэрлэх тухай Киргиз Улсын хуулийн төсөлд өгсөн санал дүгнэлт](#)).

Монгол Улсын Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд өгөх АИХЭГ-ын санал дүгнэлт

зуучлалд хамаарахгүй гэж харагдаж байна. **Хэрэв ийм бол, хувийн зуучлалыг мөн зохицуулна гэдгийг баталгаажуулах үүднээс уг хуулийг шинэчлэн боловсруулахыг хууль санаачлагчдад зөвлөж байна**, ингэснээр эвлэрүүлэн зуучлалд хандах иргэдийн боломжийг нэмэгдүүлж, Монгол Улсад эвлэрүүлэн зуучлалын зохицуулалтыг нэг мөр тууштай зохицуулах боломжийг мөн дэмжиж өгнө. (Дээр буй 26-г үзнэ үү.)

35. Гэр бүлийн холбогдолтой маргааны талаар хуулийн 32.1-д заахдаа талууд шүүхэд хандахаас өмнө эвлэрүүлэн зуучлах ажиллагаа хийсэн нь хэргийг шүүхэд үүсгэсний дараа эвлэрүүлэн зуучлал дахин хийхийг нь хорихгүй гэж тодорхой тусгажээ. **Энэ бол зөв зүйтэй зарчим бөгөөд зөвхөн гэр бүлийн холбогдолтой маргаанаар хязгаарлалгүй, Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн бусад хэсэгт ч илүү өргөн хэрэглэж болохоор байна.** Энэ боломжийг зөвхөн гэр бүлийн маргаантай холбоотойгоор тусгаж өгсөн нь ижил зарчмыг бусад маргаанд үйлчлэхгүй гэж байгаа мэт харагдуулж байна.
36. Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 3.6-д арбитрын ажиллагаа эхэлмэгц аливаа хэрэг маргааныг эвлэрүүлэн зуучлалын аргаар шийдвэрлэх эсэх асуудлыг зохицуулахаар заажээ. **Энэ заалтыг арбитрын хүрээнд явагдах эвлэрүүлэн зуучлалд яг тодорхой ямар хууль үйлчлэх ёстой гэдгийг зааж өгч тодруулах хэрэгтэй. Түүнчлэн арбитрын тохиролцоонд эвлэрүүлэн зуучлалыг зохицуулах тодорхой журам (арбитрын болон эвлэрүүлэн зуучлалын байгууллагуудын боловсруулсан) байх ёстой.**

2.4. Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд заасан эвлэрүүлэн зуучлалын болон бусад нэр томъёоны тодорхойлолтууд

37. Эвлэрүүлэн зуучлалын тодорхойлолтыг Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 4.1.1-д “эвлэрүүлэн зуучлал гэдэг нь талуудын хооронд үүссэн эрх зүйн маргааныг энэ хуульд заасан журмын дагуу шүүхээс гадуур шийдвэрлэхээр оролдох эвлэрүүлэн зуучлагчийн ажиллагаа” гэж заажээ. Энэ тодорхойлолт нь “эвлэрүүлэн зуучлагч”-ийн ажиллагаа гэж хамааруулж буйгаараа бөөрөнхийлсөн тодорхойлолт бөгөөд өөрөө маргааныг “эвлэрүүлэн зуучлах”-ад туслалцаа үзүүлдэг мэргэшсэн хүн гэж тодорхойлсон байна (4.1.3 дахь зүйл). **Эвлэрүүлэн зуучлалын ажиллагааг илүү нарийвчлан тодорхойлсон тодорхойлолтыг буюу Сингапурын конвенцийн 2.3-т заасан “талууд маргаанаа шийдвэрлэхдээ маргалдагч талуудад аливаа шийдлийг тулгах эрх мэдэлгүй гуравдагч этгээд, эсхүл этгээдүүд (“эвлэрүүлэн зуучлагч”)-ийн тусламжтай эвийн журмаар шийдэлд хүрэхээр эрмэлзэх үйл явцыг [...] хэлнэ” гэсэн тодорхойлолттой адил төстэй тодорхойлолтыг авч үзэхийг зөвлөж байна.**³¹
38. Хуулийн 4.1.2-д зааснаар “талууд” гэдэг нь “эвлэрүүлэн зуучлах ажиллагааг санаачилсан иргэн, хуулийн этгээд, эсхүл хуулийн этгээдийн эрхгүй боловч шүүхийн шийдвэрээр эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд эвлэрүүлэн зуучлагчаар оролцох болсон этгээдийг хэлнэ” гэж тодорхойлжээ. **Нэгдүгээрт, иргэн гэдэг нэр томъёо нь гадаадын иргэд ийм ажиллагаанаас гадуур үлдэх юм шиг харуулж байж болох тул “хувь хүн” болгон солих нь зүйтэй.** Хоёрдугаарт, орчуулгын алдаа л биш бол “оролцогчид” ба “талууд” гэсэн нэр томъёог энэ хуульд нэгэн жигд хэрэглээгүй байх шиг байна (Доорх 53-ыг үзнэ үү). Түүнчлэн, 32.4 дэх зүйлд “талууд” гэдэгт гэр

³¹ Жишээ нь, Сингапурын [Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль](#) (2017)-ийн 3-р хэсэгт заасан; Хонконгийн [Эвлэрүүлэн зуучлалын захирамж](#) (2013)-ийн 4-р хэсэгт заасан “эвлэрүүлэн зуучлал”-ын тодорхойлолтыг үзнэ үү.

Монгол Улсын Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд өгөх АИХЭГ-ын санал дүгнэлт

бүлийн маргаантай холбоотой эвлэрүүлэн зуучлалд “сэтгэл зүйч, садан төрөл, найз нөхөд, хамтран ажиллагсад” орно гэжээ. **Ерөнхийдөө 4-р зүйлд заасан “талууд” (маргалдагч этгээдүүд) гэсэн утгыг “оролцогчид”** (ө.х. маргалдагч талд орохгүй оролцогчид буюу өмгөөлөгч, орчуулагч, шинжээч, мэргэжлийн болон мэргэжлийн бус (төлбөргүй) дэмжлэг үзүүлэх хүмүүс) гэсэн утгаас ялган тодруулж, эдгээр нэр томъёог хуульд бүхэлд нь нэг мөр жигд хэрэглэхийг зөвлөж байна.

39. “Эвлэрүүлэн зуучлалын гэрээ” (“Эвлэрлийн гэрээ”) гэсэн нэр томъёог 4.1.4-д заахдаа “*маргаан болон санал зөрөлдөөнтэй асуудалд эвлэрүүлэн зуучлалын үр дүнд талуудын хүрсэн бичгээр хийсэн хэлцэл*” гэж тодорхойлон, эвлэрүүлэн зуучлалын үр дүн буюу зөвшилцөл тохиролцоонд хамаатуулжээ. “*Эвлэрүүлэн зуучлалын гэрээ*” гэсэн нэр томъёо нь, ялангуяа олон улсын тавцанд өргөн хэрэглэгддэг бөгөөд эвлэрүүлэн зуучлалд оролцохын тулд зуучлагч, маргалдагч талууд, хууль ёсны төлөөлөгч нар гарын үсэг зурдаг, маргаан гарсны дараах хэлцлийг хэлдэг тул зарим нэг төөрөгдөлд хүргэж болзошгүй юм. **Тиймээс ийм төөрөгдлөөс зайлсхийхийн тулд үүний оронд “Эвлэрлийн гэрээ” гэсэн нэр томъёог хэрэглэхийг зөвлөж байна.**
40. Хуулийн 12.3 дахь зүйлд “эвлэрүүлэн зуучлах ажиллагаа” гэсэн нэр томъёог “reconciliation mediation activity” гэж оруулсан (эсвэл орчуулсан) байна, энэ нэр томъёо анх удаа тааралдаж байгаа ба тодорхойлолтын хэсэгт оруулаагүй тул тодорхойгүй байна.

3. Эвлэрүүлэн зуучлах ажиллагааг санаачлах, өдөөх механизм

3.1. Ерөнхий тайлбарууд

41. Өдөөх механизм гэдэг нь эвлэрүүлэн зуучлуулах эрэлт хэрэгцээг хэрхэн дэмжин сайшааж, санаачилж байгаа эсэхийг авч үздэг. Судалгаанаас харахад ихэнх талууд гуравдагч этгээдийн чиглүүлэггүйгээр, эсвэл зохицуулж өгөх ямарваа хөшүүрэг байхгүй бол эвлэрэн зохицох арга замыг хэзээ ч олж чаддаггүй байна.³² Түүнчлэн дэлхийн олон улс орны эрх зүйн туршлагаас үзэхэд шүүх дэх хэрэг маргаан шийдвэрлэх сонголтот хувилбар буюу маргаан шийдвэрлэх альтернатив хувилбар (ADR)-ыг тодорхой хэмжээгээр тулган хүлээлгэх тохиолдолд шүүх ажиллагаанд жинхэнэ ёсоор хувилбар болон хөгжиж эхэлдэг болохыг харуулж байна.³³ Мөн энэ үзэл баримтлалыг нотлох зарим нэг баримт гэвэл эвлэрүүлэн зуучлах арга туршлага нэмэгдэхийн хэрээр энэ үйл явцыг тулган хүлээлгэх шаардлага буурч байгаа явдал юм.³⁴ Эдгээр шалтгааны улмаас, эвлэрүүлэн зуучлалын сайн туршлага бүхий зохицуулалт нь олон төрлийн хөшүүрэг буюу “өдөөх механизм”-уудыг агуулдаг. Ийм “өдөөх механизм”-уудад, жишээ нь, шүүх дэх эвлэрүүлэн зуучлал (сайн дурын, ердийн журмаар заавал биелүүлэх, сонголтоор заавал биелүүлэх, бусад г.м.), эвлэрүүлэн зуучлалын талаар мэдээлэл өгөх, эвлэрүүлэн зуучлалыг заавал дагаж мөрдөх хуулийн заалтууд, шүүхэд хэрэг үүсгэхээс өмнө талуудыг эвлэрэн зохицохыг шаардсан хууль тогтоомж, эсвэл шүүхийн практик байж болно. Жишээ нь, Эвлэрүүлэн зуучлалын тухай Европын удирдамжийн 5-р зүйлд гишүүн орнууд

³² Дараахыг үзнэ үү: М. Пел, *Эвлэрүүлэн зуучлалд хандах нь: Эвлэрүүлэн зуучлалын үр дүнтэй санал тавих практик гарын авлага* (2008). Шүүх дэх эвлэрүүлэн зуучлалын Нидерландын төсөл. (англи. M Pel, *Referral To Mediation: A Practical Guide For An Effective Mediation Proposal* (2008). Netherlands Project on Court-Connected Mediation <www.mediationnaastrechtspraak.nl>.

³³ Дараахыг үзнэ үү: N Alexander, “*Эвлэрүүлэн зуучлалын дэлхийн чиг хандлага: Гуравдагч давалгааг унах нь*” N Alexander (ed), *Эвлэрүүлэн зуучлал дахь дэлхийн чиг хандлага*. (2nd ed, Alphen aan den Rijn: Kluwer Law International 2006) 1 at 25.

³⁴ Дараахыг үзнэ үү: N Alexander, “*Шүүх дэх эвлэрүүлэн зуучлал: Маргаан шийдвэрлэх альтернатив хувилбар - 10 тогтоол*” (2004) 22 *Хууль эрх зүйн тусгай дугаар: Маргаан шийдвэрлэх альтернатив хувилбар ба Шүүх* 8.

Монгол Улсын Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд өгөх АИХЭГ-ын санал дүгнэлт

эвлэрүүлэн зуучлалын талаар шүүхээс хийх мэдээлэл, шүүх болон бусад эрх бүхий байгууллагуудаас сайн дурын болон заавал дагаж мөрдөх журам зэргийг багтаасан зохицуулалтын бодлогодоо авч үзэж болох эвлэрүүлэн зуучлалын төрөл бүрийн механизмыг тусгасан байдаг.

42. Түүнчлэн төрөл бүрийн хэлбэрийн хөшүүргийн талаар тайлбарласан тайлбаруудыг, тухайлбал эвлэрэн зохицохоос үндэслэлгүй татгалзсан талуудад тавигдах эвлэрүүлэн зуучлал хийх шаардлагууд, мөн төлбөр хураамжийн хориг санкцууд зэргийг багтаасан янз бүрийн зохицуулалтын хэлбэрүүд хууль тогтоомж, практик чиглүүлэг зэрэг хэлбэрээр байгааг Англи,³⁵ Сингапур,³⁶ Хонконг,³⁷ Австрали,³⁸ Герман,³⁹ АНУ⁴⁰ болон бусад эрх зүйн системээс харж болно. Шүүхэд хамаарах загвар нь харилцан адилгүй байх бөгөөд тухайлбал, зөвхөн бүх талуудын зөвшилцлөөр эвлэрүүлэн зуучлалд шилжүүлэх,⁴¹ талуудын дор хаяж аль нэгнийх нь хүсэлтээр эвлэрүүлэн зуучлалд шилжүүлэх,⁴² талуудын хүсэл зоригоос үл хамааран эрх бүхий этгээдийн үзэмжээр эвлэрүүлэн зуучлалд заавал хамрагдахыг шаарддаг нь ч байна.⁴³

3.2. Өдөөх механизм

43. Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 6-р зүйлд маргааныг эвлэрүүлэн зуучлалын үндсэн дээр шийдвэрлэх эрх мэдэлтэй холбоотой асуудлаар, ялангуяа эвлэрүүлэн зуучлах ажиллагааг хэрхэн өдөөх буюу таниулах талаар заажээ. Энэ нь эвлэрүүлэн зуучлалыг талуудын хүсэлтээр хийхийг зөвшөөрч байгаа бөгөөд талууд шүүхийн эвлэрүүлэн зуучлагч, эсвэл гаднаас эвлэрүүлэн зуучлагч сонгох боломжийг олгож байна (6.1. дэх зүйл нь 8-р зүйлд хамаарч байна). Гэхдээ уг заалтыг 30.1-р зүйлтэй хамт уншиж үзвэл, энэ нь 30.1 дэх заалтаар талууд эвлэрүүлэн зуучлах ажиллагааг

³⁵ Жишээ нь, дараахыг үзнэ үү: [Үйл ажиллагааны өмнөх протоколд өгөх практик чиглэл](#) (Англи), догол мөр 8; [Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх журам \(Англи\) \(1998\), г 1.4](#); мөн and the case of [Halsey v. Milton Keynes General NHS Trust and Steel v Joy and Halliday](#) [2004] EWCA Civ 576. Мөн дараахыг үзнэ үү: Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх журам (Англи), г 44.3 зардалтай холбоотой тушаал гаргахдаа шүүх “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны өмнө болон ажиллагааны үеэр, ялангуяа үйл ажиллагааны өмнөх протоколуудад хамаарах бүх нөхцөл байдлыг, онцгойлон (a) бүх талуудын оролцоог нэгтгэн” харгалзан үзэх ёстой.

³⁶ Жишээ нь, дараахыг үзнэ үү: [Сингапурын шүүхийн журам \(Бүлэг 322, R 5\), O59 г 5\(1\)\(c\)](#), үүнд заахдаа: “Шүүх зардлын талаар өөрийн үзэмжээр шийдвэр гаргахдаа, хэрвээ шаардлагатай тохиолдолд нөхцөл байдлыг харгалзан үзнэ - [...] талууд шалтгаан, асуудлыг шийдвэрлэхээр ямарваа оролдлого хийхдээ эвлэрүүлэн зуучлалаар болон маргаан шийдвэрлэх бусад арга замаар шийдвэрлэнэ.”

³⁷ Жишээ нь, дараахыг үзнэ үү: [Хонг Конгийн практик чиглэл – 31 \(Эвлэрүүлэн зуучлал\)](#). Дараахыг үзнэ үү: https://mediation.judiciary.hk/en/doc/GeneralGuide_PD31-Eng.pdf. Дараахыг үзнэ үү: Nadja Alexander, Хонг Конгийн эвлэрүүлэн зуучлалын гарын авлага, Lexis Nexis (2014), 9-р бүлэг.

³⁸ Жишээ нь, дараахыг үзнэ үү: [Австралийн иргэний хэрэг шийдвэрлэх хууль 2011](#), ss 6-11. Жишээ нь, хэрэг хянан шийдвэрлэхээс өмнө эвлэрүүлэн зуучлалыг зайлшгүй хийх үүрэгтэй (s 86B заалтаар), дараах хуультай холбоотой маргаануудын хувьд: Native Title Act 1993 (No. 110, 1993).

³⁹ Дараахыг үзнэ үү: Kristina Osswald ба Gustav Flecke-Giammarco, *Герман*, Nadja Alexander et al (eds) болон бусад, *ЕХ-ны Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн гарын авлага – Эвлэрүүлэн зуучлалын ажиллагаан дахь зохицуулалтын тогтвортой байдлын үнэлгээ*, Wolters Kluwer (2017), at 381.

⁴⁰ Жишээ нь, дараахыг үзнэ үү: Миннесотад Маргаан шийдвэрлэх альтернатив хувилбарыг зайлшгүй авч үзэх нь: [Миннесота Ерөнхий практик дүрмийн 114](#).

⁴¹ Энэхүү арга барилын талаарх тайлбарыг дараах улс орны жишээнээс харж болно: [Франц: Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх хууль C pr civ. Art. 131-1](#); [Герман: Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, § 278a](#); мөн Австрали улсад: Холбооны шүүхийн дүрэм (Нэмэлт өөрчлөлт) 1991 N° 461, г 4(1).

⁴² Энэхүү арга барилын талаарх тайлбарыг дараах улс орны жишээнээс харж болно: [АНУ: Флорида Florida Statutes 2008, s 44.102\(2\)\(a\)](#); ба [Австрали: Farm Debt Mediation Act \(2018\), s 9\(1\)](#).

⁴³ Энэхүү арга барилын талаарх тайлбарыг АНУ-ын жишээнээс харж болно: Калифорни мужийн шүүхийн тухай журам – USD50 000-ээс дээшгүй маргаанд хамаарах иргэний хэргийн журам, г 3.891; Флорида мужийн хууль 2008, § 44.102, давж заалдах шатны эвлэрүүлэн зуучлалтай холбоотой § 44.1011(2)(a); Техасын Иргэний хэргийн практик, шүүхээр хамгаалуулах эрхийн хууль, § 154.021 ба § 154.022. Австрали улсын Квинслендэд, жишээ нь, зайлшгүй шүүхэд хандах загвар байдаг тул маргааны талууд эвлэрүүлэн зуучлуулах зөвшөөрөл авах боломжтой: Квинсландын Дээд шүүх 1991 оны хууль (Qld), s 102; ба Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 1999 оны 320-р зүйлд, шүүхээс маргалдагч талыг эвлэрүүлэн зуучлалд хандахыг зөвшөөрдөг бол, маргааны тал нь шүүхийг шийдвэр гаргахыг хүсдэг. Түүнчлэн, Австралийн Шинэ Өмнөд Уэльсийн шүүхээс шүүх дэх эвлэрүүлэн зуучлалыг заавал дагаж мөрдөхийг шаарддаг. Дэвид Спенсер, [Маргааныг эвлэрүүлэн зуучлах ажиллагаа ШӨУ-ээс эхлэн](#), 4 (4) ADR Bulletin 52 (2001) нийтлэлийг үзнэ үү.

Монгол Улсын Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд өгөх АИХЭГ-ын санал дүгнэлт

хүсээгүй байсан ч шүүх эвлэрүүлэн зуучлалыг тогтоож болно гэж үзсэн мэт эргэлзээг төрүүлж байна. Энэ нь 30.1-т зааснаар шүүхэд эвлэрүүлэн зуучлах эрх олгоно гэсэн үг болно. **Хэрэв ийм бол, үүнийг 6-р зүйлд мөн тодруулах хэрэгтэй.** Эвлэрүүлэн зуучлах ажиллагааг заавал хэрэглэх нь шүүхэд хандах эрхийг хязгаарлаж буй эсэх талаар нэлээдгүй маргаан гардаг ба тиймээс Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт (ICCPR)-ын 14-р зүйл (мөн Хүний эрхийн европын шүүх/ECtHR-ийн 6-р зүйл)-ийг зөрчих явдал гарсан гэдгийг тэмдэглэх нь зүйтэй.⁴⁴ Гэхдээ эвлэрүүлэн зуучлалд албан журмаар оролцох нь ICCPR пактын 14-р зүйл/ECtHR-ийн 6-р зүйлийг зөрчсөн гэсэн үг биш бөгөөд энэ нь гагцхүү эвлэрүүлэн зуучлах оролдлого хийх тухай шаардлага болохоос зуучлалаар дамжуулан үр дүнд хүрэхгүй байх тухай шаардлага биш, хэрэв талууд эвлэрүүлэн зуучлалаар дамжуулан шийдэлд хүрч чадахгүй бол шүүхэд хандах уламжлалт арга зам нээлттэй хэвээр байна гэдгийг онцлон хэлэх ёстой. Үүнээс гадна, Эвлэрүүлэн зуучлалын тухай Европын удирдамж нь эвлэрүүлэн зуучлалыг сайн дурын үйл явц гэж тодорхойлсон хэдий ч гишүүн улс орнууд зуучлал хийхийг тулган хүлээлгэсэн хуультай байж болохыг хүлээн зөвшөөрдөг.⁴⁵ Түүнчлэн, ICCPR пактын 14-р зүйлд өгсөн Ерөнхий тайлбарын 32-рт эвлэрүүлэн зуучлалыг онцгойлон авч үзэхийг зөвлөсөн байдгийг тэмдэглэе. Үүнд “*эрүүгийн хуулиар хориглосон үйлдэл хийсэн гэж буруутгагдаж байгаа насанд хүрээгүй хүмүүсийг засан хүмүүжүүлэхэд эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанаас бусад арга хэмжээ авах буюу гэмт хэрэгтэн ба хохирогчийг хооронд нь эвлэрүүлэн зуучлах, гэмт хэрэгтний ар гэрийнхэнтэй уулзах, зөвлөгөө өгөх, олон нийтийн ажил хийлгэх, сургалт боловсролын хөтөлбөр хэрэгжүүлэх г.м.*” гэж заажээ.⁴⁶

44. Хуулийн 6.4 дэх заалтаар “талууд эвлэрүүлэн зуучлах ажиллагааг хэрэглэхээр тохиролцсон бол зуучлал нь маргааныг шүүхийн бус аргаар шийдвэрлэх гэж үзнэ” гэсэн мөртлөө 6.5-р зүйлд “шүүх 6.3 ба 6.4-т заасныг зөрчин гаргасан нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзана” гэж заажээ. Эдгээр заалтын утга нь тодорхойгүй байгаа боловч энэ нь эвлэрүүлэн зуучлах ажиллагаа үргэлжилж байгаа үед шүүх нэхэмжлэлийг хүлээн авахгүй гэсэн үг байж болох юм. **Хэрэв ийм бол, үүнийг тодруулах хэрэгтэй.**
45. Эцэст нь, Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулиар эвлэрүүлэн зуучлалыг санал болгох заалтуудын талаар хөндөөгүй байна. *Эвлэрүүлэн зуучлалын саналын заалтууд нь худалдааны гэрээнд улам бүр ашиглагдаж байгаа (олон улсын) төдийгүй зуучлалын ажиллагааны чухал өдөөгч болдог тул эвлэрүүлэн зуучлалын саналын заалтуудыг уг хуулиар зохицуулан тусгаж өгөхийг зөвлөж байна. Хэрэв энэхүү сонголтыг хуулийн төсөл санаачлагчид хуулинд үлдээсэн бол эвлэрүүлэн зуучлалын саналын заалтыг биелүүлэх хүртэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хүлээлгэх шүүхийн эрхийг зааж өгөх, мөн эдгээр заалтын утгыг илүү нарийвчлан тодорхойлоход чухал байх байсан,*⁴⁷ ингэснээр саналын заалтуудыг хүлээн зөвшөөрөх, дагаж мөрдүүлэх

⁴⁴ Жишээ нь, дараахыг үзнэ үү: T Naughton, “Эвлэрүүлэн зуучлал ба Шинэ Өмнөд Уэльсийн газар, байгаль орчны шүүх”(1992) 9 *Байгаль орчин ба төлөвлөлт Хуулийн сэтгүүл* 219, 223 дахь тал. Мөн дараахыг үзнэ үү: [Halsey v. Milton Keynes NHS Trust and Steel v. Joy and Halliday](#) [2004] EWCA Civ 576. Мөн дараахыг үзнэ үү: Эвлэрүүлэн зуучлалыг дэмжих үүднээс төлбөр хураамжийг өндөр үнээр тогтоох нь хуульд нийцэхгүй, энэ нь практик утгаараа шүүхэд хандах эрхэд сөргөөр нөлөөлнө гэсэн дүгнэлт хийсэн Laws J in *Ex parte Witham* тайлбарыг үзнэ үү: *R v. Lord Chancellor, Ex parte Witham* [1998] QB 575 Div Ct. Жишээ нь, дараахыг үзнэ үү: S Fielding, ‘Mediation post-Halsey’ (2004) 154 *New Law Journal* 1394, T Allen, ‘A closer look at Halsey and Steel’ (2004) эндээс үзнэ үү: [www.cedr.com](#) болон ‘What happens now? The impact of Halsey’ (2004) эндээс үзнэ үү: [www.cedr.com](#).

⁴⁵ 18-р шилэлд тайлбарласан, 12-р зүйл ([Directive 2008/52/EC](#))

⁴⁶ НҮБ-ын Хүний эрхийн хороо, Ерөнхий тайлбар №. 32, 14-р зүйл, Шүүхийн өмнө тэгш байх, шударга шүүхээр шүүлгэх эрх, 44-р догол мөр.

⁴⁷ Дараахыг үзнэ үү: [Сингапурын Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль](#), 4 ба 8-р хэсэг, тайлбарыг үзнэ үү.

Монгол Улсын Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд өгөх АИХЭГ-ын санал дүгнэлт

боломжтой болно. Үүнтэй адил, Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль нь эвлэрүүлэн зуучлалын гэрээ хэлэлцээ (ө.х., ерөнхийдөө зуучлагч, маргааны талууд болон хууль ёсны төлөөлөгч нар гарын үсэг зурж, эвлэрүүлэн зуучлалд оролцох тухай маргааныг шүүхэд үүсгэсний дараах хэлэлцээрүүд)-г зохицуулахад хэрэгтэй байх байсан. Түүнчлэн эвлэрүүлэн зуучлалын саналын заалтууд болон гэрээг хүлээн зөвшөөрөхөөс гадна шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх эрх олгох, мөн эвлэрүүлэн зуучлах саналын заалтууд, гэрээ зэргийн төслийг боловсруулахад тавигдах шаардлагууд болгож нэмэлт удирдамж, журам гаргах нь ч ач холбогдолтой. Эдгээрийг эрх зүйн бус дүрэм журам, эвлэрүүлэн зуучлалын загвар гэрээ,⁴⁸ мөн хууль тогтоомж зэрэг олон янзын зохицуулалтын механизмаар боловсруулж болно. Австрали,⁴⁹ Сингапур,⁵⁰ Хонконг,⁵¹ АНУ,⁵² Англи,⁵³ Герман,⁵⁴ Франц⁵⁵ зэрэг олон оронд хөгжиж буй чиг хандлага нь эвлэрүүлэн зуучлалын саналын заалтыг тодорхой нөхцөл хангасан тохиолдолд хүлээн зөвшөөрч, дагаж мөрддөг боловч зуучлалын саналын заалтыг хэрэгжүүлэхэд өөр өөр шүүх эрх мэдэл бүхий улс оронд өөр өөр стандартыг ашигладаг. Жишээ нь, нийтийн эрх зүйн тогтолцоотой шүүх эрх мэдлийн хувьд зохих ёсоор боловсруулсан зуучлалын саналын заалтуудад дараах шинж чанарыг ерөнхийд нь авч үздэг. Үүнд (i) заалт нь эвлэрүүлэн зуучлах үйл явцыг эхлүүлэхэд хангалттай тодорхой бөгөөд үүрэг амлалтууд нь хоёрдмол утгагүй байгаа эсэх; (ii) заалтаас үйл явцыг урагшлуулахын тулд талууд тус тусдаа ямар алхам хийх шаардлагатай байгаа нь ойлгогдохоор байгаа эсэх; (iii) заалт нь шүүхэд дараах зүйлсийг бодитой тогтоох боломжийг олгохын тулд хангалттай ойлгомжтой тодорхойлогдсон эсэх, үүнд: (a) тухайн үйл явцын дагуу маргаанд оролцоход маргалдагч талуудаас хамгийн багадаа юу шаардагдах (б) үйл явц хэзээ, хэрхэн явагдаж дуусах, эсвэл ямар нэг байдлаар

⁴⁸ Жишээ нь, [Сингапурын олон улсын эвлэрүүлэн зуучлалын төв \(SIMC\)](#)- өөс санал болгож буй загвар эвлэрүүлэн заалтыг үзнэ үү. Үүнд:

‘Маргаан гарахаас өмнө ашиглахаар бол:

Энэхүү гэрээтэй холбоотой үүсэж буй бүх маргаан, санал зөрөлдөөн, ялгаатай байдал, түүний дотор эдгээрийн байгаа явдал, хүчинтэй байх, дуусгавар болох зэрэг бүх асуудлыг Сингапур Улсад эхлээд Сингапурын Олон улсын эвлэрүүлэн зуучлалын төвд хүчин төгөлдөр үйлчилж буй Эвлэрүүлэн зуучлалын журамд заасны дагуу эвлэрүүлэн зуучлуулахаар хандах болно.

Маргаан үүссэний дараа ашиглахаар бол:

Энэхүү гэрээтэй холбоотой үүсэж буй бүх маргаан, санал зөрөлдөөн, ялгаатай байдал, түүний дотор эдгээрийн байгаа явдал, хүчинтэй байх, дуусгавар болох зэрэгтэй холбоотой аливаа асуулт нь, аливаа хянан шийдвэрлэх ажиллагаа эхлэх эсэхээс үл хамааран, Сингапур Улсад эхлээд Сингапурын Олон улсын эвлэрүүлэн зуучлалын төвд хүчин төгөлдөр үйлчилж буй Эвлэрүүлэн зуучлалын журамд заасны дагуу эвлэрүүлэн зуучлуулахаар хандах болно.
(2018 оны 11-р сарын 25-нд хандав).

⁴⁹ Жишээ нь, дараахыг үзнэ үү: [Computershare Ltd v Perpetual Registrars Ltd \(No 2\) \[2000\] VSC 233](#), 6-р догол мөрд.

⁵⁰ Дараахыг үзнэ үү. [International Research Corp PLC v Lufthansa Systems Asia Pacific Pte Ltd and another \[2014\] 1 SLR 130](#).

⁵¹ Жишээ нь, дараахыг үзнэ үү: [Hyundai Engineering and Construction Co Ltd v Vigour Ltd \[2005\] HKEC 258](#), 29-р догол мөрд.

⁵² Гэхдээ дандаа ингэж зохицуулж байгаагүй. Жишээ нь, АНУ-ын шүүх хэд хэдэн хэрэгт эвлэрүүлэн зуучлал болон маргаан шийдвэрлэх бусад заалтуудыг хэрэглэх нь үр ашиггүй гэсэн үндэслэлээр хэрэгжүүлэхээс татгалзаж байсан: *In re Estate of Ferdinand Marcos Human Rights Litigation*, 94 F 3d 539 (9th Cir 1996), citing *Virginian Ry Co v System Fed’n* N° 40, 300 US 515, 550, 57 S Ct 592, 601 (1937). Зарим шүүх ийм заалтуудыг хэрэгжүүлэхээр тушаал гаргах нь “дэмий” гэж үзэн татгалзжээ: *Lorch Inc. v Bessemer Hall Shopping Center Inc*, 294 Ala 17, 310 So 2d 872 (1975) and *Livoti v Elston*, 52 AD 2d 444, 384 NYS 2d 484 (App Div 1976). Харин энэ практикийг эвдсэн шинэ тохиолдол бол [AMF Inc v Brunswick Corp](#), 621 F Supp 456, 462 (EDNY 1985) бөгөөд маргаан шийдвэрлэх зөвлөмж заалтуудыг хүлээн зөвшөөрч мөрджээ. Энэ сэдвээр АНУ-ын хэрэг шийдвэрлэсэн хуулийн хөгжлийг үзэхийг хүсвэл дараахыг үзнэ үү: Peter Tochtermann, *Agreements to Negotiate in the Transnational Context – Issues of Contract Law and Effective Dispute Resolution*, Uniform Law Review 685 (2008), at 696-706.

⁵³ Жишээ нь, дараахыг үзнэ үү: [Wah \(aka Alan Tang\) and another v Grant Thornton International Ltd and others \[2012\] EWHC 3198](#).

⁵⁴ Peter Tochtermann, “Германы эвлэрүүлэн зуучлах ажиллагаа: Герман Улсын Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль – Маргаан шийдвэрлэх өөр арга зам” - Klaus J. Hopt & Felix Steffek (eds), мөн “Эвлэрүүлэн зуучлал – Зарчим ба зохицуулалтыг харьцуулах нь” - OUP (2013), 549 дээр хэвлэгдсэн. Tochtermann бичихдээ Германд, эвлэрүүлэн зуучлалын талаарх заалтууд нь “тухайн заалтыг хэрхэн найруулж томъёолсноос шалтгаалаад ... нь эвлэрүүлэн зуучлах ажиллагаа хийгдэхээс өмнө талуудыг заавал дагаж мөрдүүлэхээр заахдаг учраас аливаа нэхэмжлэлийг гаргаж ирэх боломжгүй болгодог” гэжээ. § Германы иргэний хууль *Bürgerliches Gesetzbuch* (BGB)-ийн 307-ийг “хэрэв заалтууд нь эвлэрүүлэн зуучлал нь заавал дагаж мөрдөх процедур биш бөгөөд зөвшилцөл тохиролцооны аль ч шатанд таслагдаж болно гэж тодорхой заагаагүй тохиолдолд эвлэрүүлэн зуучлалын заалтуудыг хүчин төгөлдөр бус болгож болно” гэж хөрвүүлж болдог.

⁵⁵ Францад шүүхүүд эвлэрүүлэн зуучлалын заалтыг хууль ёсны бөгөөд *prima facie* буюу шууд хэрэгжүүлнэ гэж үздэг.

Монгол Улсын Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд өгөх АИХЭГ-ын санал дүгнэлт

заалтыг зөрчилгүйгээр зохих ёсоор дуусгавар болгох.⁵⁶ Эдгээр шалгуурыг эвлэрүүлэн зуучлалын саналын төслийг боловсруулахад хууль тогтоомждоо, эсвэл бусад заавал биелүүлэх болон заавал биелүүлэхийг шаарддаггүй баримт бичгүүддээ удирдамж болгон ашиглаж болно.

4. Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны журмын талаарх заалтууд

4.1. Ерөнхий тайлбарууд

46. Журмаар эвлэрүүлэн зуучлах ажиллагаа хэрхэн явагдах, зуучлагчдыг томилоход ямар журам хэрэглэх, төлбөр тооцоо болон захиргааны бусад асуудлыг авч үздэг. Ялангуяа, процедурын зохицуулалт нь эвлэрүүлэн зуучлах ажиллагаа эхлэх, цуцлах, зуучлах ажиллагааны протокол, зуучлагчдыг сонгох, томилох зэрэг асуудлыг зохицуулдаг. Эвлэрүүлэн зуучлалын зохицуулалтын практикт хийсэн тойм судалгаагаар ихэнх улс орнууд дотоод үйл явцтай нь холбогдуулан хууль тогтоомжийн бус зохицуулалтын хэлбэрийг хэрэглэхийг илүүд үздэг.⁵⁷
47. Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд дээр дурдсан бүх асуудлыг, ялангуяа зуучлагчдыг сонгох, томилох, явуулах газар, хугацаа, зардал, эхлүүлэх, дуусгавар болгох гэх мэт захиргааны журамтай холбоотой заалтуудыг багтаажээ. Түүнчлэн хувийн нууц, оролцоо, хамтарсан ба тусдаа уулзалтууд (caucus), зуучлагчийн үүрэг (доорх 7.2-ыг үзнэ үү), зуучлалын тэмдэглэл зэрэгтэй хамааралтай заалтууд оржээ. Тиймээс Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль нь журмын талаар нэлээд олон заалтыг оруулсан байна. Гэхдээ уг заалтуудын дийлэнх нь эвлэрүүлэн зуучлалын нарийн ширийнийг хатуу, заавал дагаж мөрдөх байдлаар зохицуулдаггүй тул эдгээрийг Эвлэрүүлэн зуучлах гэрээ, эсвэл эвлэрүүлэн зуучлагчийн үйл ажиллагаатай холбогддог ёс зүйн дүрмэнд зааж үлдээдэг. Шинэчлэн засварлах тухайд авч үзвэл, доор дурьдсан тодорхой саналуудаас гадна энэ хуулинд журамтай холбоотой нэмэлт заалтууд оруулахгүй байхыг зөвлөж байна, ингэснээр эвлэрүүлэн зуучлалын үйл явцад талуудад уян хатан, бие даасан байдлыг үлдээж чадах юм. Хэрэв нэмэлт зохицуулалт хийхийг хүсч байвал үүнийг Эвлэрүүлэн зуучлалын гэрээ зэрэг зөөлөн хуульд тусгаж өгөх боломжтой.

4.2. Эвлэрүүлэн зуучлалын үндсэн зарчим

48. Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 5.2-т эвлэрүүлэн зуучлах ажиллагааны зарчмуудыг заасан бөгөөд үүнд талуудын сайн дурын үндсэн дээр хэрэгжих, эвлэрүүлэн зуучлалд оролцож буй оролцогчдын нууцлал, эвлэрүүлэн зуучлагч нь төвийг сахисан байх, эвлэрүүлэн зуучлалд талуудын тэгш байдлыг хангах зэрэг зарчмууд багтжээ. “Сайн дурын” гэдэг нэр томъёо нь эргэлзээ төрүүлэхээр байна. Хэрэв энэ нь эвлэрүүлэн зуучлалд сайн дураар оролцохыг хэлж байгаа бол шүүх талуудыг зуучлалд оролцохыг шаардах нь тэдний эвлэрүүлэн зуучлуулах идэвх хөшүүргийг боогдуулж болзошгүй. Эсвэл талууд эвлэрүүлэн зуучлах ажиллагаатай холбоотой шийдвэр гаргахдаа сайн дурын үндсэн дээр байхыг хэлж байгаа эсэх нь тодорхойгүй байна. Ер нь сүүлийнх нь байх ёстой бөгөөд энэ үүднээс Хуулийг

⁵⁶ Дараахыг үзнэ үү: *Wah (aka Alan Tang) and another v Grant Thornton International Ltd and others* [2012] EWHC 3198; and *Sulamérica Cia Nacional de Seguros SA v Enesa Engenharia SA* [2012] EWCA Civ 638, [35]-д. Харьцуулбал, Сингапурын давж заалдах шатны шүүхээс тодорхойлохдоо Эвлэрүүлэн зуучлалын тухай заалтыг маш нарийн, тодорхой ойлгомжтой найруулан үгчилж өгсөн байхаас гадна маргаан шийдвэрлэх үйл ажиллагаанд оролцох шаардлагатай ажилтнууд, ажиллагааны янз бүрийн шатанд хийгдэх уулзалт бүрийн зорилго зэргийг маш нарийн тодорхой, заавал дагаж мөрдөх байдлаар зааж өгөх ёстой гэсэн байдаг.

⁵⁷ Дараахыг үзнэ үү. F Steffek, ‘Mediation in Europa und der Welt’ (2009) 1 *Zeitschrift für Konfliktmanagement* 21 at 23.

Монгол Улсын Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд өгөх АИХЭГ-ын санал дүгнэлт

тодорхой болгох хэрэгтэй. Ерөнхийдөө, талуудын бие даасан байдал нь эвлэрүүлэн зуучлалын тухай хууль тогтоомжид өргөн хэрэглэгддэг бөгөөд сайн дурын гэсэн утгыг өөртөө агуулж байдаг (эвлэрүүлэн зуучлах үйл явцад талуудын шийдвэр гаргах сайн дурын шинж чанар гэж ойлгож болно), тиймээс хуулийн 5.2 дахь заалтанд тусгаж өгөх хэрэгтэй.

49. Нууцыг хадгалах талаар зааж өгсөн нь ерөнхийдөө зөв зүйтэй боловч энэ заалт нь “эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд оролцож буй оролцогчдын нууц”-д хамааруулж буй нь уг үзэл баримтлалыг хязгаарлагдмал хүрээнд ойлгоход хүргэж байна. Нууцлалын гурван хэмжигдэхүүн байдаг бөгөөд эдгээрийг бүгдийг нь хууль тогтоомжид тусгах шаардлагагүй ч гэсэн эвлэрүүлэн зуучлах ажиллагааг зохицуулахдаа анхаарч үзэх нь чухал юм. Нэгдүгээрт, дотогш/гадагш гэсэн урсгал бүхий нууц буюу нууцлал нь нууцлалын үндсэн үүрэгт хамаарах ба гадны этгээдтэй харилцахад баримталдаг. Энэ нь эвлэрүүлэн зуучлалд орж буй талуудаас гадны этгээдэд мэдээллийг задруулахгүй байхыг шаарддаг. Энэхүү үүрэг нь эвлэрүүлэн зуучлалд оролцож буй янз бүрийн оролцогчдод, тухайлбал маргааны талууд, зөвлөх, шинжээч, хэлмэрч, гэрч, эвлэрүүлэн зуучлагч болон холбогдох туслах ажилтнууд зэрэг хүмүүст хамаарч болох бөгөөд тэднийг эвлэрүүлэн зуучлалын явцад олж авсан мэдээллийг гадны болон бусад оролцогч бус этгээдүүдэд задруулахыг хориглодог.⁵⁸ Хоёрдугаарт, дотогш/дотогш урсгалтай нууц⁵⁹ нь эвлэрүүлэн зуучлах ажиллагаан доторх, ялангуяа зарим улс оронд хувийн уулзалт (мөн бүлгийн уулзалт хурал ч гэж нэрлэдэг)-уудад хамаарах мэдээллийн урсгалыг зохицуулдаг боловч үүнийг ерөнхийдөө хууль тогтоомжоор зохицуулдаггүй, харин эвлэрүүлэн зуучлагч ба маргааны талуудад үлдээдэг. Дотогш/гадагш урсгалтай нууцлалын журмыг хууль тогтоомжид зааж өгөх бол тэдгээр нь ерөнхийдөө дефолт хуулийн хэлбэрээр байдаг. Гуравдугаарт, дотогш/шүүх гэсэн урсгалтай нууцлал нь тодорхой зорилгоор, ямар нэг байдлаар хэлсэн, эсвэл хийсэн зүйл байж болох учраас эвлэрүүлэн зуучлах ажиллагааг иргэний болон эрүүгийн хэргийн хянан шийдвэрлэх дараа дараачийн ажиллагааны явцад талуудын сул тал болгож ашиглаж болзошгүй гэдэг үүднээс зуучлалд орж буй талууд, тэдний өмгөөлөгчдийн хувьд санааг нь зовоодог томоохон асуудлын нэг юм. Энэ нь янз бүрийн зан араншин, харилцаатай холбоотой

⁵⁸ Дараахыг үзнэ үү: § Австри улсын 2001 оны Иргэний хэрэг шүүхэд эвлэрүүлэн зуучлах тухай хуулийн 18-д “Эвлэрүүлэн зуучлагч нь зуучлалын явцад мэдсэн, эсхүл өөрөөр олж мэдсэн баримт материалын нууцыг хадгалах үүрэгтэй. Тэрээр эвлэрүүлэн зуучлалын явцад түүнд өгсөн эсвэл түүнд хүлээлгэн өгсөн баримт бичгүүдтэй ажиллахдаа нууцлалыг хадгална. Энэ нь эвлэрүүлэн зуучлагчийн туслах ажилтнууд болон практик сургалтын явцад түүний удирдлаган дор зуучлагчийн үүрэг гүйцэтгэгч буй хүмүүст мөн хамаарна.” (Герман хэлнээс орчуулсан Мария Тереза Трофайер MA (KCL) DipICArb, Solicitor (Англи, Уэльс), Австри улсад магадлан итгэмжлэгдсэн эвлэрүүлэн зуучлагч (Vienna Rechtsanwaltskammer)-т бүртгэгдсэн (Хууль зүйн яамны жагсаалт). Нууцлалыг хангах үүргийг мөн [Эвлэрүүлэн зуучлалын үр дүн бий болсон Олон улсын худалдааны зуучлалын тухай UNCITRAL Загвар хууль \(2018\)](#), [Европын эвлэрүүлэн зуучлагчдын ёс зүйн дүрмийн](#) 4-р зүйл, Францын [1995 оны хуулийн](#) 24-р зүйлээс үзэж болно.

⁵⁹ Ерөнхийдөө эвлэрүүлэн зуучлагчид дотогш/дотогш урсгалтай нууцыг хоёр аргаар зохицуулдаг: нээлттэй харилцааны арга ба итгэлцлийн арга. (1) [Нээлттэй харилцааны аргад](#) зуучлагч нар хувьчилж уулзсан уулзалт дээр дамжуулж өгсөн мэдээллийг холбогдох талуудаас тусгайлан хүсэлт гаргаагүй тохиолдолд нууцлалыг хадгалах үүрэг хүлээхгүй. Энэ нь зуучлал дахь мэдээллийн урсгал чөлөөтэй байвал итгэлцэл, харилцан ойлголцлыг бий болгох, талуудын хооронд бүрэн бөгөөд нээлттэй тохиролцоог дэмжихэд чухал ач холбогдолтой гэдэг зарчимд үндэслэдэг. Үүний зэрэгцээ энэ арга нь талууд зуучлагчтай нууцлалтай холбоотой асуудал дээр ч харилцахыг хүсч байгаа хүлээн зөвшөөрч байж болохыг харуулдаг гэж үздэг. Практикт ийм аргыг янз бүрийн арилжааны контекст, гэр бүлийн зуучлалын зарим практик, өөрчлөн хувиргах зуучлалын хөтөлбөрүүдэд ч ашигладаг бөгөөд JAMS International ADR Center (<<https://www.jamsadr.com/>>), [Эвлэрүүлэн зуучлалын үр дүн бий болсон Олон улсын худалдааны зуучлалын тухай UNCITRAL Загвар хууль \(2018\)-ийн](#) 9-р зүйл, [UNCITRAL Эвлэрлийн дүрэм](#)⁵⁹ мөн [Байнгын арбитражын шүүхийн эвлэрлийн дүрэм](#) (1996)⁵⁹ зэрэг батлан хэрэглэж байна. (2) Итгэлцлийн арга нь эсрэгээрээ нууцыг дэлгэж буй та өөрөөр заагаагүй бол хувьчлан дэлгэсэн бүх мэдээллийг нууц гэж үздэг. Энэ нь зуучлагч нь мэдээллээр хангаж буй талын шууд зөвшөөрөлгүйгээр ийм мэдээллийг задруулах боломжгүй гэсэн үг юм. Итгэлцлийн арга нь оролцогчид мэдээллийг нууцлалтайгаар дэлгэж задруулсан гэдгээ мэдэж байгаа тохиолдолд зуучлагчид мэдээллээ дэлгэхдээ санаа зовохгүй байх гэсэн итгэл дээр суурилдаг. Энэ аргыг дараах зохицуулалтуудад хэрэглэсэн байдаг: Лондонгийн Олон улсын арбитражын шүүх (LCIA)-ийн Эвлэрүүлэн зуучлалын дүрэм 1999, Стокгольмын Худалдаа аж үйлдвэрийн танхимын Эвлэрүүлэн зуучлах институтын дүрэм 1999, Нидерландын Эвлэрүүлэн зуучлалын институт (NMI)-ийн Эвлэрүүлэн зуучлалын дүрэм 2008, Дэлхийн оюуны өмчийн байгууллага (WIPO)-ын Эвлэрүүлэн зуучлалын дүрэм 2002, Маргааныг шийдвэрлэх олон улсын төв (ICDR)-ийн Олон улсын эвлэрүүлэн зуучлалын дүрэм 2008.

Монгол Улсын Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд өгөх АИХЭГ-ын санал дүгнэлт

асуудлууд (үүнд, жишээ нь, эвлэрүүлэн зуучлалын хамтарсан болон хувийн уулзалт хурлууд дээр үүссэн, хуваалцсан мэдээлэл, бичиг баримт, бичлэг болон бусад мэдээллүүд, талуудын зан авирын талаарх ажиглалт, шийдвэрлэж чадахгүй байгаа шалтгаан, аль нэг талын санал болгосон саналын баримт гэх мэт)-ыг дараа дараачийн шүүх болон арбитрын ажиллагаанд хуулийн дагуу олж илрүүлэх, нотлох баримтаар хүлээн зөвшөөрөх зэргээс хамгаалах ёстой гэсэн үг юм. Дотогш/шүүх гэсэн урсгалтай нууцлал нь эвлэрүүлэн зуучлах ажиллагаанаас олж авсан мэдээллийг дараа дараачийн шатны шүүх ажиллагаанд нотлох баримтаар хүлээн зөвшөөрөх, эс зөвшөөрөх тухай асуудал юм (доорх 8-ыг үзнэ үү).⁶⁰ **Хууль санаачлагчид нууцлалын эдгээр гурван хэмжигдэхүүнийг анхааран авч үзэж, Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд тусгана гэвэл ямар хэмжээнд тусгах, улмаар 5.2 дахь заалтыг шаардлагатай бол тодруулах хэрэгтэй.**

50. Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны гол зарчим гэж тодотгож болох өөр нэг тал бол эвлэрүүлэн зуучлагч маргаантай талуудад шударга, алагчлахгүй хандах явдал юм.⁶¹ **Үүнийг 5.2 дахь зүйлд нийцүүлэн нэмж оруулахыг зөвлөж байна.**

4.3. Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны оролцогчид

51. Хуулийн 12-р зүйл эвлэрүүлэн зуучлах ажиллагааны оролцогчдод хамаарчээ. Тухайлбал 12.1-д зааснаар оролцогч талууд гэдэгт маргааны талууд, тэдний хууль ёсны төлөөлөгч, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, эрх ашиг нь хөндөгдсөн гуравдагч этгээд болон бусад хуулийн этгээдийг хамруулж болно гэж заажээ. **Энэ заалтыг талууд болон эвлэрүүлэн зуучлагчдын оролцохыг зөвшөөрсөн бусад оролцогчдыг хамруулах байдлаар өргөжүүлэхийг санал болгож байна.** Мөн 12.4 дэх заалтын өмгөөлөгч, орчуулагч, хэлмэрчийн оролцоог хамаатуулахдаа “хуульд өөрөөр заагаагүй бол” гэсэн хэлц юуг илэрхийлж байгаа нь тодорхойгүй байна. Талууд нь өмгөөлөгч, орчуулагч, хэлмэрч болон бусад хүмүүсээс зохих туслалцаа авах боломжтой байх ёстой бөгөөд энэ нь эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд орж буй талуудын ерөнхий эрх байх ёстой ба талууд эвлэрүүлэн зуучлагчтайгаа зөвшилцөөд хэлэлцэн тогтсон байх ёстой зүйл. Үүнийг 12.1-р зүйлд тусгах хэрэгтэй. Эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд эксперт шинжээч оролцож болох бөгөөд үүнийг ч бас дурдаж өгөх хэрэгтэй.
52. Хуулийн 12.3 дахь заалтад талууд өөрийн биеэр болон өөрсдийн төлөөллөөр дамжуулан оролцож болно гэжээ. **Энэ заалтыг талууд эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд биечлэн оролцох ёстой гэж шинэчлэхийг зөвлөж байна.** Мөн “биечлэн” оролцох гэдгийг онлайнгаар, эсвэл бусад технологийн арга хэрэгслээр болон харилцах утсаар дамжуулж оролцохыг оруулан тодорхойлж өгөхийг зөвлөж байна. Биечлэн оролцох шаардлага нь эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд талуудын өөрийгөө тодорхойлох чадвар дээр үндэслэдэг. Энэ нь өөрөө өөрийгөө тодорхойлох, бие даасан байх ардчилсан зарчмуудад нийцдэг тул буулт хийн тохиролцох боломжгүй юм. Цаашлаад эвлэрүүлэн зуучлал гэдэг нь талуудын хууль ёсны бусад ашиг сонирхол болон энэ ашиг сонирхол, эрэлт хэрэгцээгээ илэрхийлэх чадвар зэрэг нь чухал үүрэг гүйцэтгэдэг, үйлчлүүлэгчдээ төвлөрсөн маргаан шийдвэрлэх үйл явц юм. Хуульч өмгөөлөгч нар эрх зүйн асуудлаар маргалддаг шүүн таслах ажиллагаа

⁶⁰ Энэ бол нууцлалын талаар Европын [Directive 2008/52/EC](#) удирдамж, түүнчлэн АНУ-ын [Uniform Mediation Act](#) (UMA) Эвлэрүүлэн зуучлалын тухай нэгдсэн хууль (2001), [Эвлэрүүлэн зуучлалын үр дүн бий болсон Олон улсын худалдааны зуучлалын тухай UNCITRAL Загвар хууль \(2018\)-ийн](#) 11-р зүйлд тусгагдсан ганцхан тохиолдол юм.

⁶¹ [Эвлэрүүлэн зуучлалын үр дүн бий болсон Олон улсын худалдааны зуучлалын тухай UNCITRAL Загвар хууль \(2018\)-ийн](#) 7(3) дахь заалт.

Монгол Улсын Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд өгөх АИХЭГ-ын санал дүгнэлт

болон арбитрын ажиллагаан дээр маргааны талууд ихэнхдээ өөрсдийн дуу хоолойг хүргэх боломжгүй байдаг бол, эвлэрүүлэн зуучлах ажиллагаа нь үйлчлүүлэгч/маргалдагч талуудад өөрсдийн дуу хоолойг сонсгох боломжийг өгдөг үйл явц юм. Маргаан шийдвэрлэх ажиллагаан дээр талууд өмгөөлөгчдийг өөрсдийнхөө өмнөөс яриулах нөхцөлд энэ нь ихэвчлэн нэг бол төвийг сахисан үнэлгээ буюу зөвлөх үйл явц, эсвэл арбитрын болон шүүн таслах ажиллагаа буюу хэрэг шийдвэрлэх үйл явц байдаг.

53. Хуулийн 21.2 дахь заалт нь эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд оролцож буй олон янзын оролцогчийн талаар заасан өмнөх заалттай зөрчилдөж байгаа бололтой. Энэ заалтад эвлэрүүлэн зуучлах ажиллагаа нь хувьчилсан хэлбэрээр явагдах бөгөөд үүнд зөвхөн оролцсон талуудыг хамруулна гэжээ. Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа нь эвлэрүүлэн зуучлагч зөвшөөрсний дагуу талуудтай зөвшилцсөний үр дүнд оролцогчид (дан ганц маргааны талуудыг ч биш)-ыг бас оролцуулах нь ойлгомжтой юм. **Орчуулгын асуудал биш л бол уг заалтыг дахин авч үзэх шаардлагатай.**
54. Хуулийн 32.4 дэх заалтад гэр бүлийн маргаан гарсан тохиолдолд сэтгэл зүйч, төрөл садан, найз нөхөд, хамтран ажиллагсад нь гэрлэгчдийг эвлэрүүлэх ажиллагаанд тал байж болно гэжээ. Нэгдүгээрт, дээр дурдсанчлан “тал” гэсэн нэр томъёог энд буруу хэрэглэсэн мэт санагдаж байгаа ба “оролцогч”-оор солих хэрэгтэй. Хоёрдугаарт, уг заалт нь дан ганц гэрлэлтийн эвлэрлээр хязгаарлагдахгүй, харин гэр бүлийн холбогдолтой бүх төрлийн эвлэрүүлэн зуучлалд хамаарах ёстой. **Иймээс “гэрлэлтийг эвлэрүүлэх” гэсэн нэр томъёог хасахыг зөвлөж байна.**

4.4. Ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой захиргааны асуудлууд (явуулах газар, хугацаа, зардал)

55. Хуулийн 19-р зүйлд эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулах газрын талаар заажээ. Энэ заалт шаардлагагүй бөгөөд хасаж болно. Ихэвчлэн эдгээр асуудлыг эвлэрүүлэн зуучлагч нь талуудтай зөвшилцөөд шийдвэрлэдэг бөгөөд нөхцлийг нь Эвлэрүүлэн зуучлалын гэрээ (Эвлэрүүлэн зуучлуулах гэрээ)-нд оруулж болно.
56. Хуулийн 20.1 дэх заалтад эвлэрүүлэн зуучлах ажиллагааг 30 хоногийн дотор явуулна гэж заажээ. Гэхдээ цаг хугацааг хэрхэн тооцоолох дүрэм, ялангуяа аль өдрөөс эхлэх талаар зааж өгөөгүй учраас уг заалт тодорхойгүй байна. Хуулийн 20.2-д зааснаар 30 хоногийн хугацааг шүүхийн шийдвэр гарсан өдрөөс эхэлнэ (31-р зүйлийг үзнэ үү) гэсэн боловч үүнийг тодруулах нь зүйтэй. Түүнээс гадна хугацаа нь арай богино байж болох бөгөөд **сунгах хугацааг 30 хоногоос 45 хоног болгохыг зөвлөж байна.** Мөн 20.2 дахь заалтаар хугацааг талууд хүсэлт гаргасан тохиолдолд зөвхөн нэг удаа сунгаж болно гэжээ. **Эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд оролцож буй бүх тал үүнийг зөвшөөрч байвал хэд хэдэн удаа сунгах боломж олгохыг зөвлөж байна.**
57. Хуулийн 29.1 дэх зүйлд төлбөрийн талаар заажээ. Үүнд шүүхээс тодорхой төлбөрийг төлнө гэж харуулж байна. Гэсэн хэдий ч хоёр дахь өгүүлбэрт эвлэрүүлэн зуучлуулах хүсэлт гаргасан тал урьдчилгаа төлбөр төлнө гэж заажээ. Өөр төлбөрийн талаар заагаагүй бол **үүнийг тодруулах шаардлагатай**, учир нь эхний заалттай зөрчилдөж байна. Эвлэрүүлэн зуучлуулах хүсэлт гаргасан тал хэдий хэмжээний хураамж төлөх, мөн нөгөө тал ер нь ямар нэгэн төлбөр хураамж төлөх шаардлагатай эсэх нь тодорхойгүй байна. Энэ шаардлагаас болж зөвхөн нэг тал нь зардлыг хариуцахаар бол талууд эвлэрүүлэн зуучлуулах хүсэлт гаргахаас зайлсхийхэд хүргэж болзошгүй юм. **Тиймээс хуульд нөгөө тал нь мөн төлбөр хураамж төлнө гэдгийг тодорхой болгох хэрэгтэй.**

Монгол Улсын Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд өгөх АИХЭГ-ын санал дүгнэлт

58. Хуулийн 29.2-т шүүх дэх эвлэрүүлэн зуучлагчийг улсын төсвөөс санхүүжүүлнэ гэж заажээ. Дахиад л талууд ямар төлбөр хураамж төлөх нь тодорхойгүй байна. Шүүхийн бус эвлэрүүлэн зуучлагчийн төлбөрийг 29.3-т заасан ба талууд тохиролцож, төлөх ёстой. Ерөнхийдөө шүүхийн ажилтнууд/шүүхийн эвлэрүүлэн зуучлагчид нь цалингаасаа санхүүждэг, орон тооны бус эвлэрүүлэн зуучлагч нар Шүүхийн ерөнхий зөвлөлөөс тогтоосон тогтмол ажлын хөлстэй байхаар (29.4-р зүйл), харин 8-р зүйлд заасан эвлэрүүлэн зуучлагчид нь талууд зөвшөөрсөн тохиолдолд хүссэн хөлсөө авах боломжтой мэт зохицуулж гэж харагдаж байна. Хэрэв энэ нь зөв бол, шударга ёс ба зах зээлийн загварыг хоёуланг нь дэмжих үндэслэлтэй арга байна (дээрх 26-г үзнэ үү).

4.5. Эвлэрүүлэн зуучлах ажиллагааг эхлүүлэх

59. Хуулийн 21-р зүйлд эвлэрүүлэн зуучлах ажиллагааг эхлүүлэх тухай заажээ. Гарчигтаа үүнийг тусгах хэрэгтэй гэдгийг санал болгож байна. Мөн эвлэрүүлэн зуучлах ажиллагааг эхлүүлэх хүчин төгөлдөр хугацаа нь янз бүрээр заасан эхлүүлэх хугацааны хамгийн эхнийх нь юм гэдгийг нарийн тодорхой болгох үүднээс уг заалтыг шинэчлэн найруулах нь зүйтэй. Ер нь, эвлэрүүлэн зуучлах ажиллагааг эхлүүлэх нь хөөн хэлэлцэх хугацаа болон нууцын тухай заалттай холбоотой байдаг. Энэхүү хуулиар маргаан үүсгэснээс хойших асуудлыг авч үзэж байгаа тул хөөн хэлэлцэх хугацаа нь хамааралгүй юм шиг харагдаж байна. Нууц, нууцлалтай холбогдуулан хэлэхэд Хонконг, Сингапурын аль алины хуулийн заалтууд нь нууцын талаар авч үзэхдээ эвлэрүүлэн зуучлах ажиллагааг эхлүүлэх, дуусгавар болгох тухай тодорхойлолтыг шаардахгүй байхаар зохицуулсан байдаг. **Үүнийг Монгол Улсын энэхүү хуулийн зорилгод нийцүүлэх үүднээс хянан үзвэл зохистой юм. Энэ талаар хуулийн 21.3-аас 21.6 дахь зүйлд хамааруулан доор нууцлалын тухай хэсэгт дурдсан болно.**

4.6. Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны үйл явц

60. Хуулийн 24-р зүйлд эвлэрүүлэн зуучлах ажиллагааны журмыг авч үзжээ. Хуулийн 24.1-д эвлэрүүлэн зуучлах ажиллагааны эхний уулзалтаар хүлээх хүлээлтийг заасан байна. **Энэ нь ерөнхийдөө хэрэгтэй заалт боловч энэ асуудлыг хууль тогтоомжид бус, эвлэрүүлэн зуучлагчдад зориулсан ёс зүйн дүрэм, практик стандартад тусгахыг зөвлөж байна.** Эвлэрүүлэн зуучлал нь олон янзын хэлбэртэй байж болох бөгөөд энэ заалт тохиромжгүй байж болох эвлэрүүлэн зуучлалын олон өөр ажиллагаа байж болно, жишээ нь хөрөнгө оруулагч ба улс хоорондын маргаан. Үүний нэгэн адил, эвлэрүүлэн зуучлах ажиллагаа нь эвлэрүүлэн зуучлагч аль нэг талтай нь ганцаарчлан уулзахаас бусад тохиолдолд бүх талыг оролцуулна гэж заасан **24.2 дахь заалт, мөн эвлэрүүлэн зуучлах уулзалтын үргэлжлэх хугацааг заасан 24.3 дахь заалтыг ч ёс зүйн дүрэм, практик стандарт зэрэгт оруулан зааж өгвөл илүү зохимжтой.**

61. Хуулийн 30.4-т зааснаар хэрэв иргэний хэрэгт нэгээс олон нэхэмжлэл гаргасан бол талууд эвлэрүүлэн зуучлагчийн туслалцааг нэг, эсвэл бүх нэхэмжлэлд ашиглаж болно. Энэ заалт нь хэрэв талууд зөвшөөрч байгаа бол эвлэрүүлэн зуучлах ажиллагаагаар нэг ижил бодит зөрчилд хамаарах хэд хэдэн холбогдох маргааныг шийдвэрлэх боломжтой гэсэн үзэл санааг бататгасан заалт юм шиг санагдаж байна. Өөрөөр хэлбэл, талууд эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд орсон л бол маргааны эрх зүйн үзүүлэлтүүдээр хязгаарлагдахгүй гэсэн үг. Энэ бол эвлэрүүлэн зуучлах ажиллагааны гол зарчим бөгөөд үүнийг 30.4-р зүйлд тусгасан бололтой. Гэхдээ

Монгол Улсын Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд өгөх АИХЭГ-ын санал дүгнэлт

үүнийг Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд илүү нарийвчлан тусгах хэрэгтэй бөгөөд уг зарчим нь тусдаа заалт байх хэрэгтэй гэдэг үндэслэл ч болох юм.

4.7. Эвлэрүүлэн зуучлах ажиллагааг дуусгавар болгох

62. Хуулийн 28-р зүйлд эвлэрүүлэн зуучлал дуусгавар болгох тухай асуудлыг авч үзсэн ба эвлэрүүлэн зуучлах ажиллагааг эхлүүлэх талаар заасан 21-р зүйлтэй холбон уншихаар байна. Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа хэд хэдэн янзаар дуусгавар болж болох ба эдгээрийг 28-р зүйлд зааж өгчээ. Хуулийн 28.1-д талууд болон эвлэрүүлэн зуучлагчийн хүсэлтээр цуцлах тухай заасан байна. **Үүнийг талууд, эсвэл эвлэрүүлэн зуучлагчийн хүсэлтээр дуусгавар болж болно гэж өөрчлөн найруулах хэрэгтэй.**
63. Түүнчлэн, хоёр талын аль нь шударга бус хандаж буйг хэн тодорхойлох нь тодорхой биш, бас энэ нь эвлэрүүлэн зуучлагчийн төвийг сахисан байдалд сөргөөр нөлөөлөх магадлалтай тул түүний хүлээх үүрэг байх ёсгүй учраас 28.1.3 дахь заалтыг хасахыг санал болгож байна. Аль ч тохиолдолд, эвлэрүүлэн зуучлагчийн зүгээс аль нэг талыг шударга бус байна гэж үзэх нөхцөл үүсвэл энэ нь зуучлагчийг тохиролцоонд хүрэх магадлал багатай гэж үзэх нөхцөл байдалд хүргэнэ, тэгээд ч үүнийг 28.1.2 дахь заалтад тусгасан байна.
64. Эвлэрлийн гэрээ (ЭГ)-ний тухайд, 26.2 дахь заалтаар гэрээг монгол хэл дээр үйлдсэн байх, эсвэл монгол хэл дээрх албан ёсны орчуулгатай байхыг шаардаж байна. Энэ нь шүүхээс баталсан, эсвэл нотариатаар гэрчлүүлсэн гэрээнд шаардлагатай байж болох ч, харин ердийн гэрээ хэлцэл, ялангуяа гадны тал оролцсон гэрээ хэлцлийн хувьд гадаад хэл дээр бичигдсэн байхад хангалттай байж болох учраас уг заалт шаардлагагүй байж болох юм. Талуудын аль нэг нь шүүхийн өмнө ийм гэрээг дагаж мөрдөхийг хүсч байгаа тохиолдолд монгол хэл дээрх албан ёсны орчуулгыг шаардаж болно, гэхдээ үүнийг шүүхэд маргаан шийдвэрлэх ажиллагааны үеэр зохицуулж болно.
65. Хуулийн 26.3-г эвлэрлийн гэрээний агуулгыг, тухайлбал талуудын маргаан, тэдний байр суурь болон “бусад асуудал” зэргийг нарийн тайлбарласан байна. Энэ нь олон тохиолдолд нууцын асуудлыг зөрчиж болзошгүй юм. Түүнчлэн, эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд оролцож буй талууд өөрсдийн байр суурь, асуудлуудаа гэрээнд баримтжуулан оруулах ёстой гэдгийг мэдэж байгаа учраас эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд тэр бүр сайн нээлттэй оролцож чадахгүй байж магадгүй. Энэ бүх элементийг эвлэрлийн гэрээнд оруулах шаардлагагүй бөгөөд зөвхөн маш тодорхой, дагаж мөрдөх гэрээ байх ёстой бөгөөд хэрэв үүгээр эрх зүйн маргааныг шийдвэрлэж байгаа бол, ийм маргааныг шийдвэрлэх ёстой гэдгийг нь тодруулж зааж өгөөд, өөр илүү мэдээлэл байх шаардлагагүй. Эвлэрлийн гэрээ нь нууцлалын тухай заалтуудтай байж болно гэдгийг онцлон тэмдэглэх нь зүйтэй.
66. Хуулийн 26.3-г зааснаар бол эвлэрүүлэн зуучлагчийг эвлэрлийн гэрээнд гарын үсэг зурахыг шаардаж байна. Энэ нь эвлэрүүлэн зуучлагчийг гэрээний агуулгыг шууд бусаар зөвшөөрч байгаа гэж ойлгогдож болохгүй, учир нь энэ нь зуучлагчийн шударга байх үүрэгтэй зөрчилдөнө. Үүний оронд хуулийн төсөл боловсруулагчид **эвлэрүүлэн зуучлагчийн хийж гүйцэтгэсэн эвлэрүүлэн зуучлах ажиллагааны үр дүнд бий болсон эвлэрлийн гэрээний баримт буюу актад зуучлагч гарын үсэг зурна гэх байдлаар тусгаж болох юм.** Өөр хувилбар (эсвэл нэмэлт байдлаар) гэвэл, хэрэв энэ нь институцийн хийж буй эвлэрүүлэн зуучлах ажиллагаа бол **эвлэрүүлэн зуучлалын байгууллага нь эвлэрүүлэн зуучлах ажиллагааны үр дүнд**

Монгол Улсын Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд өгөх АИХЭГ-ын санал дүгнэлт

эвлэрлийн гэрээ байгуулсныг баталгаажуулсан акт гаргаж болно. Ийнхүү шинэчилсэн найруулга нь Сингапурын эвлэрүүлэн зуучлалын гэрээний 4-р зүйл болон UNCITRAL Загвар хуулийн холбогдох заалтуудтай нийцэж байгаа юм. **Түүнчлэн, Сингапурын эвлэрүүлэн зуучлалын гэрээний 4(2) ба 2(2) зүйлүүд, UNCITRAL Загвар хуулийн холбогдох заалтуудтай нийцүүлэх үүднээс цахим харилцааны үр дүнд бий болсон эвлэрлийн гэрээг хүлээн зөвшөөрч, Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн заалтуудад оруулахыг зөвлөж байна.**

5. Эвлэрүүлэн зуучлагчийг сонгох

67. Хуулийн 22.1-22.3-т эвлэрүүлэн зуучлагчийг сонгох талуудын өргөдлийн талаар заажээ. Энд хугацаа зааж өгөөгүй байх шиг байна, **хугацааны талаар оруулахыг санал болгож байна.** Түүнчлэн хэнд өргөдлөө гаргах нь тодорхойгүй байна. Энэ нь талууд шүүх дэх эвлэрүүлэн зуучлагч, эсвэл хувийн эвлэрүүлэн зуучлагч авахыг хүсэж байгаа эсэхээс хамаарч болох юм. **Энэ асуудлыг тодруулахыг зөвлөж байна.**

68. Хуулийн 23-р зүйлд эвлэрүүлэн зуучлагчийг сонгох асуудлыг тусгажээ. Хөдөлмөрийн маргааныг эвлэрүүлэн зуучлах, иргэний хэрэгт эвлэрүүлэн зуучлах, түүний дотор хил дамнасан эвлэрүүлэн зуучлах ажиллагааг ихэвчлэн нэг эвлэрүүлэн зуучлагч хийдэг боловч хоёр, бүр гурван зуучлагчтай ч байх боломжтой. Гэр бүлийн холбогдолтой асуудлыг ихэвчлэн хоёр эвлэрүүлэн зуучлагч хамтран шийдвэрлэдэг. Хуулийн 23.2-т зааснаар нэгээс олон эвлэрүүлэн зуучлагч байгаа тохиолдолд зуучлагчид дотроосоо ахлагч зуучлагчаа сонгоно. Арбитрын ажиллагаанаас ялгаатай нь, эвлэрүүлэн зуучлагчид ахлагч, даргагүйгээр хамтарч ажилладаг. **Иймээс энэхүү заалтыг хасахыг санал болгож байна.**

69. Хуулийн 23.3-р зүйлд шүүх дэх эвлэрүүлэн зуучлагч болон орон тооны бус эвлэрүүлэн зуучлагч ажиллахтай холбоотой нөхцөлийн талаар заажээ. Энд орон тооны бус эвлэрүүлэн зуучлагч хамтран зуучлагчаар ажиллаж болох эсэх нь тодорхойгүй байна. Мөн талууд орон тооны бус эвлэрүүлэн зуучлагчийг сонгож болох уу, үгүй юу гэдэг нь тодорхойгүй байгаа тул **үүнийг тодруулах хэрэгтэй.** Талууд эвлэрүүлэн зуучлах ажиллагааны хөлс төлдөггүй шүүхийн эвлэрүүлэн зуучлалын нөхцөлд зуучлагчаа сонгох боломжтой байх нь ховор гэдэг нь ойлгомжтой ч, талуудад эвлэрүүлэн зуучлагчаа сонгох сонголт аль болох өгөхийг зөвлөж байна.

5.1. Эвлэрүүлэн зуучлагчдад тавигдах шаардлага

70. Хуулийн 9.1-д шүүх дэх эвлэрүүлэн зуучлагч, эсвэл бусад байгууллагаас томилогдсон эвлэрүүлэн зуучлагч эсэхээс үл хамааран зуучлагчдад тавигдах шаардлагуудыг тусгажээ (ө.х. Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 7, 8-р зүйл). Хуулийн 9.1.1 дэх заалтаар эвлэрүүлэн зуучлагчийг “хууль ёсны эрхтэй” байхыг шаардсан байна. Орчуулгын асуудал биш бол, **эвлэрүүлэн зуучлагчийг эрх зүйн бүрэн чадамжтай, эсвэл эрх зүйч мэргэжилтэй байхыг шаардаж байгаа эсэх нь тодорхойгүй байна. Үүнийг тодруулахыг зөвлөж байна. Түүнчлэн эвлэрүүлэн зуучлагчид эрх зүйн мэргэжилтэй байх шаардлагыг тавихгүй байхыг зөвлөж байна.** Олон улсын чиг хандлагаас харахад зуучлагчид олон янзын мэргэжлийн хүмүүс байдаг.

Монгол Улсын Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд өгөх АИХЭГ-ын санал дүгнэлт

71. Төгсгөлд нь, *Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд шүүгчдийг эвлэрүүлэн зуучлагчаар томилох эсэх нь тодорхойгүй байна. Шүүхээс томилогдсон эвлэрүүлэн зуучлагчид нь гаднаас ажиллах (орон тооны бус), эсвэл шүүхийн ажилтан (орон тооны) байх юм байна гэсэн ойлголт байна. Шүүгчдийг зуучлагчаар томилохоор болбол энэ нь эвлэрүүлэн зуучлалын үйл ажиллагаа нь Үндсэн хууль, хүний эрхийн зарчим, ялангуяа процедурын шударга байдал, хараат бус байдал, алагчлахгүй байх зэрэгт нийцэх ёстой гэдэгт асуудал үүсгэж болзошгүй юм. Иймд, хэрэв Монгол Улсын нөхцөлд шүүгчид зарим тохиолдолд эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулдаг бол шүүхийн шударга байдал, алагчлахгүй байх зарчим (мөн эдгээрийн талаарх олон нийтийн ойлголт)-ыг хадгалахын тулд ингэж ажиллаж буй шүүгчдийг адилхан асуудлаар шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанаас тусад нь байлгах үүднээс хуульд заасан зохих механизмыг бүрдүүлэх нь нэн чухал юм.*

5.2. Эвлэрүүлэн зуучлагчдад тавигдах стандарт

72. Хуулийн 10, 11-р зүйлд эвлэрүүлэн зуучлагчийн стандарт (ёс зүйн дүрэм), бэлтгэх, давтан сургах зэрэг арга хэрэгсэл бүхий гэрчилгээ итгэмжлэл олгох тогтолцоог боловсруулах үүрэгтэй Эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөлийг байгуулахаар заасан нь Монгол Улс уян хатан арга барил (ө.х. хууль эрх зүйн орчин дотроо хууль эрх зүйн бус салбарын шийдлийг боловсруулан оруулсан арга)-ыг сонгосон гэж харагдаж байна. Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 10.1-д, мөн зарим нэг заалтууд дээр “лиценз буюу тусгай зөвшөөрөл” гэж дурдсан байгаа нь хэрэв орчуулгын асуудал биш л бол, энэ нэр томъёог нэгэн жигд хэрэглээгүй мэт харагдаж байна. Гэхдээ олон улсад эвлэрүүлэн зуучлагчийн мэргэжлийн үйл ажиллагаатай холбогдуулан тусгай зөвшөөрөл, итгэмжлэл, эрхийн гэрчилгээ олгох, мэргэшүүлэх гэх зэргээр янз бүрийн нэр томъёог ашиглаж болдог гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Итгэмжлэл, эрхийн гэрчилгээ олгох гэдэг нь эдгээр бүх нэр томъёог багтаасан ерөнхий буюу “шүхэр, дээвэр” нэр томъёо юм. Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд “тусгай зөвшөөрөл” биш, харин “гэрчилгээ олгох” гэсэн нэр томъёог ашигласнаар Эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөлөөс эвлэрүүлэн зуучлагчдыг мэргэжлийнх нь хувьд хүлээн зөвшөөрөх уян хатан байдлыг хадгалж байна. Тиймээс Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд “тусгай зөвшөөрөл” биш “гэрчилгээ олгох” гэсэн нэр томъёог тууштай хэрэглэхийг зөвлөж байна.

73. Монгол Улсын гэсэн стандарт, эрхийн гэрчилгээ олгох мэдээлэл байхгүй бол дараах сайн туршлагауд нь Эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөл ямар арга замыг дагах нь зүйтэй вэ гэдээ тодорхойлоход тус болж магадгүй. Эвлэрүүлэн зуучлагчдад эрхийн гэрчилгээ олгох шаардлагыг дараах гурван элементээр ангилдаг: (i) босго буюу сонгон шалгаруулалтын шаардлагауд (ө.х. нас, боловсролын түвшин, мэргэшлийн талбар, ажлын туршлага, эрүүгийн ял шийтгэлгүй байх, эсвэл зан байдлын тодорхойлолт зэрэг *чиглэлээр тавигдах шаардлагауд*); (ii) мэргэшлийн шаардлага/стандартууд (ө.х. чадварлаг эвлэрүүлэн зуучлагч бэлтгэх сургалтанд хамрагдаж, эрхийн гэрчилгээ авах *чиглэлээр тавигдах шаардлагауд* - сургалтын цаг, сургалтын агуулга, дадлага, бичгийн шалгалтын үнэлгээ);⁶² (iii) стандартыг

⁶² Хонконг, Австрали, Канад, АНУ, Сингапур, Шинэ Зеланд зэрэг ихэнх нийтийн эрх зүйн тогтолцоотой орнуудад эвлэрүүлэн зуучлалын сургалт нь 40 цагийн мэргэшсэн, интерактив ур чадварын сургалт байхаас гадна дүрд тоглуулах байдлаар үнэлэх, зарим тохиолдолд бага зэргийн бичгийн шалгалт авдаг. Иргэний эрх зүйн ихэнх орнуудад сургалтыг нэгээс хоёр жилийн хугацаанд гурван өдрийн блокоор 90-ээс 400 цагийн хооронд явуулдаг, жишээ нь Франц (400), Австри (365), Герман (200), Бельги (с. 90). Үнэлгээнд онолын болон практик хэсгүүд багтахад гадна эдгээр нь ихэвчлэн хэд хэдэн бодит хэрэг дээр ажиллах, тэдгээрийнхээ талаар тайлан бичдэг. Иргэний болон нийтийн эрх зүйт улс орнуудад сургалт явуулж, үнэлгээ хийсний дараа эвлэрүүлэн зуучлагч болохоор нэр дэвшиж буй хүмүүс нь эвлэрүүлэн зуучлагчийн гэрчилгээ авах өргөдөл гаргах

Монгол Улсын Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд өгөх АИХЭГ-ын санал дүгнэлт

баримтлах (ө.х. боловсрол мэдлэг, дадлага туршлага, бусад шаардлагуудыг үргэлжлүүлэн хөгжүүлэх чиглэлээр тавигдах шаардлагууд).⁶³ Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд сургалтанд тавигдах шаардлагуудын талаар заагаагүй бөгөөд үүнийг Эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөлийн үүрэгт үлдээж (11-р зүйл), давтан сургах ажлыг зохион байгуулах талаар 10-р зүйлд зааж өгсөн боловч ямар нэг стандарт тогтоох тухай тусгаагүй, үүнийг мөн л Эвлэрүүлэн зуучлагчийн зөвлөлийн үүрэгт үлдээжээ. **Эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөл дээр дурдсан элементүүдийг эвлэрүүлэн зуучлагчдад эрхийн гэрчилгээ олгох асуудалдаа харгалзан үзэхийг зөвлөж байна.**

74. Ерөнхийдөө, шинээр эвлэрүүлэн зуучлагчдыг элсүүлэх, сургах ажилд нийгмийн бүх давхаргын төлөөллийг хангахад анхаарал хандуулах хэрэгтэй.⁶⁴ Үнэн хэрэгтээ эвлэрүүлэн зуучлалын ажиллагааг эерэг үр дүнтэй хийхийн тулд зуучлагчид тухайн газар, орон нутгийн соёл, хүмүүсийн талаар сайн ойлголттой байх ёстой. Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн тоог тэгш байлгах, цөөнхийн төлөөллийг шударгаар хангах ёстой.⁶⁵

5.3. Эвлэрүүлэн зуучлагчийг татгалзан гаргах

75. Хуулийн 17.4-т эвлэрүүлэн зуучлагч ёс зүйн дүрэм зөрчсөн, нууцыг задруулсан бол эвлэрүүлэн зуучлагчаас татгалзах талуудын эрхийн талаар заажээ. Талууд эвлэрүүлэн зуучлагчаас ямар ч тохиолдолд татгалзах (13-р зүйл), татгалзан гаргах эрхтэй (17.1-р зүйл) бөгөөд ямар нэгэн шалтгаан тайлбар өгөх шаардлагагүй. Эвлэрүүлэн зуучлагчид дүрэм журам, стандартыг зөрчсөн тохиолдолд сахилгын арга хэмжээ (Эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөл), тэр ч байтугай иргэний хэрэг үүсгэхэд нээлттэй байх ёстой.

6. Эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөл

6.1. Эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөлийн үүрэг ба бүрэлдэхүүн

76. Хуулийн 10.1-д эвлэрүүлэн зуучлагчдын сонгон шалгаруулалт; эвлэрүүлэн зуучлагчдад “тусгай зөвшөөрөл” олгох, давтан сургалт зохион байгуулах (“эрхийн гэрчилгээ олгох” гэсэн нэр томъёогоор солих талаар дээрх 72-д бичсэн тайлбарыг үзнэ үү) талаар заажээ. Уг заалтанд буй “сонгох” гэсэн нэр томъёоны хувьд энэ үг нь зохимжгүй мэт санагдаж байгаа тул Эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөл нь

боломжтой (мөн акредитаци, эрхийн гэрчилгээ олгох гэж нэрлэдэг). Австрали, Австри зэрэг зарим улсууд жагсаалтад нэрээ баталгаатай оруулахын тулд эвлэрүүлэн зуучлагчдаас мэргэжлийн нөхөн төлбөрийн даатгал хийлгэхийг шаарддаг.

⁶³ Ихэнх иргэний болон нийтлэг эрх зүйт улс орнуудад эвлэрүүлэн зуучлагчдад эрхийн гэрчилгээгээ хадгалахын тулд мэргэжлийн түвшин байнга дээшлүүлэх (CPD) шаардлагыг тавьдаг. Зарим улс орон практик дадлагын шаардлагууд ч тавьдаг. Жишээ нь, **Австрали:** CPD 2 жилийн хугацаанд 25 цаг, дээрээс нь эвлэрүүлэн зуучлалын дадлагын цаг; **Бельги:** 2 жилийн хугацаанд CPD 18 цаг; **Австри:** 5 жилийн хугацаанд CPD 50 цаг.

⁶⁴ (Эрүүгийн хэрэг дэх эвлэрүүлэн зуучлалын талаарх E3-ийн зөвлөмж R (99) 19), Хавсралт V2 par 22.

⁶⁵ Энэ нь CEDAW-ийн 7 дахь зүйлтэй нийцэж байна. Ишлэл тайлбар 11-д заасныг үз, үүнд Оролцогч улсууд “улс орны улс төрийн болон нийгмийн амьдралд буй эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах байдлыг арилгах талаар шаардлагатай бүх арга хэмжээг авна” гэж заасан. CEDAW 4-р зүйлд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн олон нийтийн амьдралд оролцох тэгш боломж, тэгш хүртээмжийг хангах тусгай арга хэмжээг тусгасан болно; энэ байр суурийг CEDAW хорооны Ерөнхий тайлбарын 23, 25-д дахин баталгаажуулав. ЕАБХАБ-ын түвшинд ЕАБХАБ-ын Москвагийн Баримт бичгийн 40-р зүйлийг эндээс харна уу: <http://www.osce.org/odihr/elections/14310?download=true>, үүнд оролцогч улс орнуудыг олон нийтийн болон нийгмийн амьдралд, түүнчлэн ажил хөдөлмөр эрхлэхэд ч эрэгтэй эмэгтэй хүмүүсийн хүйсийн тэнцвэр, тэгш байдлыг харгалзан үзэхийг уриалсаг. Цаашлаад НҮБ-ын гишүүн орнуудад хандсан, эмэгтэйчүүдийг дэмжих, нийгмийн амьдралд болон маргаан шийдвэрлэхэд тэгш оролцох боломжийг хангах чиглэлээр гаргасан үүрэг амлалтыг Бээжингийн тунхаглал ба үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр (ялангуяа 144, 183-р зүйлүүд) болон “Бээжингийн тунхаглал ба үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх цаашдын үйл ажиллагаа, санаачлагууд” баримт бичгийн 23-р хэсгээс үзэж болно. http://www.unwomen.org/~media/headquarters/attachments/sections/csw/pfa_e_final_web.pdf

Монгол Улсын Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд өгөх АИХЭГ-ын санал дүгнэлт

эвлэрүүлэг зуучлагчдыг сонгохгүй, харин сонгон шалгаруулж, эрхийн гэрчилгээ олгох гэх нь зүйтэй юм.

77. Эвлэрүүлэн зуучлагчдын давтан сургалтыг зохион байгуулахтай холбогдуулан хэлэхэд, Зөвлөлөөс давтан сургалт зохион байгуулахыг шаардахгүй байх нь илүү зохимжтой бөгөөд харин эвлэрүүлэн зуучлагчдад зориулсан давтан сургалтанд тавигдах шаардлагуудыг тодорхойлж, давтан сургалт олгох байгууллагаар энэ ажлыг гүйцэтгүүлбэл зүйтэй.
78. Хуулийн 10.2 дахь зүйлд шүүгч, өмгөөлөгч, шинжээчийн талаар заажээ. Энэхүү заалтад буй “шинжээч” гэсэн үгийн утга тодорхойгүй байна. Энэ орчуулгын асуудал байж болох юм, гэхдээ энэ заалтын найруулгыг аль болох өргөн хүрээнд болгохыг зөвлөж байна, ингэснээр Зөвлөл бүрэлдэхүүндээ оруулах хүсэлтэй төлөөлөгчдийнхөө талаар бодлоо өөрчлөх тохиолдолд энэ боломж нь нээлттэй үлдэнэ. Иймд одоо байгаа найруулгыг “... болон бусад” гэх байдлаар найруулбал зүйтэй.
79. Хуулийн 10.3-т эвлэрүүлэн зуучлагчид гаргах өргөдөл, гэрээ, мэдэгдэх хуудасны талаар заажээ. Эдгээр маягыг боловсруулж, Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд оруулж өгөх нь зүйтэй.
80. Хуулийн 10.3-т “гэрээ” гэсэн нэр томъёог ашигласан нь “Эвлэрүүлэн зуучлалын гэрээ” (дээрх Эвлэрүүлэн зуучлах гэрээ гэсэн хэсгийг үзнэ үү), эсвэл “Эвлэрлийн гэрээ”-нд хамаарч байгаа нь тодорхойгүй байна. Үүнийг тодруулсан зүйл, эсвэл холбогдох тодорхойлолт алга байна. **Ямар ч тохиолдолд энэ үг нь тодорхойгүй байгаа тул үүнийг өөрчлөх шаардлагатай байна. Уг 10.3 дахь заалтыг өргөдөл, гэрээ, мэдэгдэх хуудаст хамаарах хуулийн бусад заалтуудтай холбож өгөх нь зүйтэй байж болох юм.**

6.2. Эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөлийн бүрэн эрх (11-р зүйл)

81. Хуулийн 11.1.1 дэх заалтаар ажлын байрны стандартыг авч үзжээ. Уг нэр томъёог энэ агуулга дотор тайлбарлаагүй бөгөөд энэ нь **ялангуяа хөдөлмөрийн маргаантай холбогдвол тодорхойгүй байдалд хүргэж болзошгүй тул үүнийг тодруулах шаардлагатай байна.**
82. Хуулийн 11.1.1-д Зөвлөл нь эвлэрүүлэн зуучлагчдын зардал, ажлын хөлс, урамшууллын журмыг боловсруулан тодорхойлно гэж заажээ. Зардлын хувьд, энэ нь шүүхээс томилогдсон зуучлагч (7-р зүйл) болон гаднаас ажиллах зуучлагчдын аль алинд нь хамаарч байх шиг байна (8-р зүйл). Энэ нь Зөвлөл эвлэрүүлэн зуучлагчдын ажлын хөлсийг журамлан зохицуулна гэсэн үг бол, үүнийг хэрхэн хэрэгжүүлэх нь тодорхойгүй байна. Цаашилбал, аливаа маргаан дээр талууд гаднаас зуучлагч авч ажиллуулж болох эсэх, мөн Зөвлөлөөс тогтоосон ажлын хөлснөөс өндөр хөлс төлж болох эсэхийг тодруулах шаардлагатай. **Мөн Зөвлөл ажлын хөлсөн дээр хязгаар тогтоож болох эсэх талаар мэдээлэл алга байна. Үүнийг тодруулах хэрэгтэй.**
83. *Гаднаас авч ажиллуулах эвлэрүүлэн зуучлагчийн ажлын хөлсний* талаарх журам боловсруулбал зуучлагчдын үйл ажиллагаанд нөлөөлж болно. Хэрэв хувийн болон гаднаас авах зуучлагчдын ажлын хөлсийг доогуур тогтоовол чадварлаг мэргэжилтнүүд эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд орж ирэхэд саад болж болзошгүй юм. Энэ нь мөн арилжааны, эсвэл хөрөнгө оруулалтын томоохон маргаан дээр “хэрэглэгчид нь хөлс төлөх” гэсэн үндэслэлээр гаднаас тодорхой эвлэрүүлэн зуучлагч томилохыг хүсч буй хоёр тал байж болох ба, тэрхүү зуучлагч нь арай өөр

Монгол Улсын Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд өгөх АИХЭГ-ын санал дүгнэлт

(өндөр) хөлс шаардвал талууд өөрсдийн сонгосон зуучлагчийг томилж чадахгүйд хүрнэ. Ингэвэл гаднаас эвлэрүүлэн зуучлагч сонгох талуудын бие даасан байдлын зарчимд хүндрэл учруулж болзошгүй. **Тиймээс шүүхээс томилогдоогүй эвлэрүүлэн зуучлагчдын ажлын хөлсийг боловсруулахаас зайлсхийхийг зөвлөж байна.** Шүүхээс томилогдсон эвлэрүүлэн зуучлагчдын хувьд маргаантай талууд биш, харин төрөөс цалинжуулдаг зохицуулалт түгээмэл байдаг.

84. Хуулийн 11.1.2-т сургалтын хөтөлбөр боловсруулах талаар заажээ. Хуулийн 9.1.3 дахь заалттай уялдуулж өгөхийг зөвлөж байна. Мөн Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 9.1 дэх заалтад 11-р зүйлд хамаарах заалт байх нь зүйтэй. Нэмж дурдахад, 11.1.2-т үнэлгээний талаар заагаагүй, зөвхөн сургалт зохион байгуулах талаар тусгажээ. Эвлэрүүлэн зуучлагчаар нэр дэвшигчдийн ур чадварыг тодорхойлох чадамжид суурилсан тогтолцоог бий болгох гэсэн Зөвлөлийн бүрэн эрхэд хамаарах заалтыг 11.1.2-т оруулж өгөхийг зөвлөж байна.
85. Хуулийн 11.1.3-т эвлэрүүлэн зуучлагчийг сонгон шалгаруулж, эрхийн гэрчилгээ олгох тухай заажээ. **“Эрхийн гэрчилгээ олгох” гэсэн нэр томъёог ашиглахыг дээр дурьдсан болно. Түүнчлэн эвлэрүүлэн зуучлагчийг сонгох гэх нь төөрөгдөлд оруулж болзошгүй тул хасахыг зөвлөж байна.**
86. Хуулийн 11.1.4-т эвлэрүүлэн зуучлагчдыг “бүртгэх” тухай заажээ. Энэ нэр томъёог ашиглахгүй байх нь зүйтэй бөгөөд үүний оронд энэхүү заалтыг “эвлэрүүлэн зуучлагчдын нэрийн жагсаалтыг гаргах”, эсвэл “эвлэрүүлэн зуучлагчдын батлагдсан нэрийн жагсаалтыг гаргах” гэж өөрчлөн найруулахыг зөвлөж байна. “Бүртгэх” гэдэг үг нь зуучлагчдад лиценз зөвшөөрөл олгох гэсэн утгаар эрх зүйн талаасаа далд ойлголт төрүүлж болзошгүй. Эвлэрүүлэн зуучлалын хөгжлийн энэ үе шатанд эрхийн гэрчилгээ олгох тогтолцоог илүү өргөн хүрээнд байлгах талаар өгүүлсэн өмнөх тайлбарыг үзнэ үү, ингэснээр Зөвлөл Монгол Улсад эвлэрүүлэн зуучлагчдад зориулан хөгжүүлэхийг хүсч буй эрхийн гэрчилгээ олгох тогтолцооны төрлөө илүү сайн судлах боломжтой болно. Цаашилбал, 11.1.4-т “гэрчилгээтэй” гэсэн нэр томъёог бас хэрэглэжээ; үүний оронд “батлагдсан жагсаалт” гэсэн нэр томъёог ашиглахыг зөвлөж байна. Өөр өөр нэр томъёог ашиглах нь эрх олгох өөр өөр итгэмжлэлийн тогтолцоо байгаа мэт ойлгуулж, будлиулна. Улс орнууд Эвлэрүүлэн зуучлалын тухай Сингапурын конвенцод гарын үсэг зурж, соёрхон баталснаар, эвлэрүүлэн зуучлагчийн стандарт, итгэмжлэлийн үүрэг улам бүр анхаарлын төвд байх болно. Тиймээс энэ тал дээр тодорхой ойлгомжтой байх нь чухал гэсэн үг юм. Цаашилбал, зөөлөн хуулийн журмаар итгэмжлэл буюу эрх олгох (ө.х. Зөвлөлөөр дамжуулан)-ыг зөвлөж байна, учир нь уг арга нь зохицуулалтын хувьд илүү мэдрэмжтэй байдаг тул ирээдүйд эвлэрүүлэн зуучлагчдын мэргэжлийн ур чадвар хөгжиж, олон улсын хэмжээнд өөрчлөгдөхийн хэрээр нэн чухал болж ирнэ.
87. Хуулийн 11.1.5-д зааснаар эвлэрүүрэн зуучлагчийн лицензийг түдгэлзүүлэх, дараа нь гэрчилгээг хүчингүй болгох талаар заажээ. **“Эвлэрүүлэн зуучлагчийн эрхийг хасах”, “Эвлэрүүлэн зуучлагчийн нэрийн жагсаалтаас хасах”, эсвэл “Эвлэрүүлэн зуучлагчийн эрхийн гэрчилгээ/итгэмжлэлийн эрхийг хүчингүй болгох” гэх мэт илүү ерөнхий хэллэг ашиглахыг зөвлөж байна.**
88. Хуулийн 11.2-т Зөвлөл нь эвлэрүүлэн зуучлагчийн нэрсийн жагсаалтыг 8-р зүйлд дурдсан төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодод санал болгоно гэж заажээ. Энэ нь 8-р зүйлд дурдсан эдгээр байгууллагууд зөвхөн Зөвлөлөөс гаргасан жагсаалтад буй эвлэрүүлэн зуучлагчдыг авах шаардлагатай болно гэсэн үг юм. Энэ нь Монгол Улсад эвлэрүүлэн зуучлагчдын нэгдсэн нэг ижил стандарттай байх гэдэг талаасаа зөв юм. Гэхдээ Монгол Улсын шүүхэд эвлэрүүлэн

Монгол Улсын Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд өгөх АИХЭГ-ын санал дүгнэлт

зуучлах ажиллагаа хийх шаардлагатай хил дамнасан буюу гадаад улстай үүссэн маргаан гарсан тохиолдолд талууд Монгол Улсын тогтолцоогоор эрхийн гэрчилгээ байхгүй, Зөвлөлийн жагсаалтад ороогүй гадаад орны эвлэрүүлэн зуучлагч томилохыг хүсч болно. **Ийм нөхцөл байдалд гадаадын болон бусад эвлэрүүлэн зуучлагч ажиллуулахыг хүсч байгаа бол Зөвлөл эрхийн гэрчилгээ олгох нэмэлт хувилбартай байх нь зүйтэй.** Жишээ нь, эрхийн гэрчилгээ олгох ердийн нэг арга бол эвлэрүүлэн зуучлагчийн сургалт, ур чадварын үнэлгээ байж болдог, өөр нэг арга зам нь эвлэрүүлэн зуучлагчийн туршлага, өөр улсад авсан ижил төрлийн эрхийн гэрчилгээ байж болно. Гадаадын эвлэрүүлэн зуучлагчид нь зөвхөн тухайн эвлэрүүлэн зуучлах ажиллагааны зорилгоор Монгол Улсын хуульд заасны дагуу эвлэрүүлэн зуучлагчаар итгэмжлүүлэхээр Зөвлөлд өргөдөл гаргаж болно; Эсвэл гадаад улсын эвлэрүүлэн зуучлагч нь Монгол Улсад зуучлагчаар итгэмжлэгдэн зөвшөөрөгдөж, нэрийн жагсаалтад бүртгүүлэх бас боломжтой. Эвлэрүүлэн зуучлалын практикийг хөгжүүлэхийг хүсч буй ихэнх эвлэрүүлэн зуучлалын тогтолцоо нь гадаад улсын болон бусад туршлагатай эвлэрүүлэн зуучлагчдад өөрсдийн тогтолцоонд итгэмжлэгдэн зөвшөөрүүлэх хүсэлт гаргах боломжийг олгодог механизмтай байдаг.

89. Хуулийн 11.3-т “8-р зүйлд дурдсан байгууллага” болон Шүүхийн ерөнхий зөвлөл жагсаалтаас эвлэрүүлэн зуучлагчийг сонгон бүртгэж, ажиллах нөхцөл боломжоор хангана гэж заажээ. Энэ утга нь тодорхойгүй байна, гэхдээ “8-р зүйлд дурдсан байгууллага” болон шүүхийн байгууллагууд нь Зөвлөлөөс тогтоосон журмын дагуу батлагдсан жагсаалтад бүртгэгдсэн эвлэрүүлэн зуучлагч нарт ажиллах боломж нөхцөлийг олгоно гэсэн утгаар заасан байх. Зөвлөл нь эвлэрүүлэн зуучлагч нартай шууд ажил санал болгохгүй, харин эвлэрүүлэн зуучлагчаар итгэмжлэгдэх боломжтой нэр дэвшигчдийг тодруулах юм байна. Гэхдээ шүүх болон “8-р зүйлд дурдсан байгууллага” нь талуудад эвлэрүүлэн зуучлагчийг сонгоход тусалж, жагсаалтад байгаа зуучлагч нарыг ажлаар хангах юм байна. **Энэ заалтыг тодруулахыг зөвлөж байна.**

7. Эвлэрүүлэн зуучлагчид, талууд болон эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд оролцогчдын эрх, үүрэг

7.1. Эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд оролцож буй талуудын эрх, үүрэг

90. Эрх, үүргийг хууль тогтоомж, нийтлэг эрх зүйн зарчим, шүүхийн шийдвэр, ёс зүйн дүрэм, хувийн гэрээ хэлцэл зэргээр зохицуулж болно.

Шүүх эрх мэдлийн харьяаллаас хамааран дараах эрх, үүргүүд байж болно. Үүнд:

- Үндэслэлтэй гэж үзвэл, эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд оролцох үүрэг;
- Шударга итгэл үнэмшлээр эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд оролцох;
- Тохиролцоонд хүрч чадаагүй эвлэрүүлэн зуучлах ажиллагааны дараа шүүхийн хянан шийдвэрлэх ажиллагаа эхлүүлэх эрх;
- Эвлэрлийн гэрээг дагаж мөрдөхийг шаардах эрх;
- Нууцлалтай холбоотой үүрэг.

91. Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 13.2.3 дахь заалт нь дээрх b) дугаарт заасантай, 13.2.1 дэх заалт нь дээрх d) дугаарт заасантай дүйцэж байгаа боловч энэ нь хэрэгжүүлэх эрх биш, харин дагаж мөрдөх үүрэг байхаар тусгасан байна. Хуулийн 13.2.1-ийг хэрэгжүүлэх эрх болгож өөрчлөхийг зөвлөж байна. Хуулийн 13.1.9 дэх заалт нь дээрх c) дугаарт заасантай дүйж байна. Хуулийн 13.1.7-д заасан

Монгол Улсын Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд өгөх АИХЭГ-ын санал дүгнэлт

“татгалзах” гэснийг “татгалзан гарах” гэж тодотгон оруулахыг санал болгож байна, учир нь талууд хүссэн үедээ эвлэрүүлэн зуучлах ажиллагаанаас татгалзан гарч болно. Хуулийн 13.1-д заасан бусад эрх нь хүлээн авах боломжтой эрхүүд байна.

92. Дээрх а) дугаарт заасан санаа Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд тусгагдаагүй байна. Энэ бол Англи, Австрали, Сингапур, БНХАУ-ын тусгай захиргааны бүс Хонг Конг болон бусад улс оронд ашигладаг өдөөх механизм бөгөөд маргаантай талуудыг шүүхийн оролцоогүйгээр эвлэрүүлэн зуучлалын ширээнд ирүүлэх үр дүнтэй арга юм. Энэ талаар Хонг Конгийн туршлагын удирдамж 31 болон Иргэний маргаан шийдвэрлэх тухай хуулийн 11 (Австрали) зэргийг үзнэ үү. Эвлэрүүлэн зуучлах ажиллагааг өдөөх талаар дээр бичсэн хэсгийг үзнэ үү.
93. Хуулийн 18.2-т заасан эрх, үүрэгтэй холбоотой заалтууд, 18.3-т заасан нууцлалтай холбоотой заалтуудын талаар дээр бичсэн 4-р хэсэгт нарийвчлан тайлбарласан болно.
94. Хуулийн 18-р зүйлийн талаар хэлэхэд, 18.1-д талуудыг шударга ажиллахыг хүсэж, эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажиллахыг шаардсан заалт байна. Уг заалт нь мөн ажиллагааны ил тод байдлыг дэмжсэн заалт байна. Энэ заалтыг талууд шударгаар буюу сайн итгэл үнэмшлээр ажиллах, эвлэрүүлэн зуучлах ажиллагааны ил тод байдлыг хангах үүрэг хариуцлагатай гэх байдлаар найруулан бичихийг зөвлөж байна. Энэ заалтыг талуудын эрх, үүрэгтэй холбоотой бусад заалтуудтай хамт нэгтгэн оруулж болно (Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 13-р зүйлийг үзнэ үү).
95. Хуулийн 21.3 дахь заалт нь хэдийгээр тусгайлан заагаагүй ч өмгөөлөгч, эвлэрүүлэн зуучлагчдад талуудыг албадахгүй байх үүргийг хүлээлгэсэн гэж харагдаж байна. Энэ үүргийг хэн хүлээх гэдгийг тодорхой болгох үүднээс уг заалтыг дахин боловсруулж, Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн өөр хэсэгт оруулахыг зөвлөж байна.
96. Хуулийн 21.4 дэх заалт нь нууцлалыг хадгалах, мэдээллийг задруулахгүй байх үүрэгтэй хамаатай бөгөөд энд буруу хэсэгт оруулсан гэж санагдаж байна. Доорх 8-р хэсэгт бичсэн нууцлалын талаарх тайлбарыг үзнэ үү.
97. Хуулийн 26.5-р зүйл тодорхойгүй байна. Эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр талууд эвлэрлийн гэрээг хэрэгжүүлэх нь зуучлагчийн хүлээх үүрэг биш. Мөн “нэхэмжлэлээсээ татгалзах” гэдэг нь төөрөгдүүлэхээр байна. **Хэрэв талууд тохиролцоонд хүрсэн бол, эвлэрлийн гэрээнд заасны дагуу нэхэмжлэлээсээ татгалзсан гэсэн заалт байх ёстой.**
98. Хуулийн 27-р зүйлд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дагуу эвлэрлийн гэрээгээр хүлээсэн үүргийг хэрэгжүүлэхийн тулд шүүхэд хандаж болно гэж заажээ. **Олон улсын хэмжээнд эвлэрлийн гэрээг хэрэгжүүлэх тохиолдолд хил дамнасан арилжааны эвлэрлийн гэрээг түргэвчилсэн журмаар хэрэгжүүлэх механизмыг бүрдүүлж өгдөг Сингапурын эвлэрүүлэн зуучлалын конвенц, ЮНИСТРАЛЫН Загвар хуульд заасан нөхцөлүүдийг харгалзан үзэх нь зүйтэй.** Эмпирик судалгаанаас харахад олон улсын эвлэрүүлэн зуучлах ажиллагааг хэрэглэгчид гэрээний үүргийг түргэвчилсэн журмаар сахиулах боломжтой

Монгол Улсын Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд өгөх АИХЭГ-ын санал дүгнэлт

хувилбарыг ашиглахыг хүсдэг байна⁶⁶. Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулбал ЮНИСТРАЛЫН Загвар хууль (16-р зүйлээс хойших)-ийн нөхцөлүүдээс тусгаж болох бөгөөд уг хуульд хил дамнасан арилжаатай холбоотой эвлэрлийн гэрээнд тохирох энэхүү механизмыг оруулж өгсөн байдаг төдийгүй өөр бусад эвлэрлийн гэрээнүүдэд ч адилхан хамаардаг. Үүнийг Монгол Улс Сингапурын эвлэрүүлэн зуучлалын конвенцод гарын үсэг зурж, нэгдсэн эсэхээс үл хамааран хийж болно; гэхдээ уг конвенцод нэгдэн орсон тохиолдолд ЮНИСТРАЛЫН Загвар Хуулийн заалтууд хэрэгжиж, Сингапурын эвлэрүүлэн зуучлалын конвенцийн шаардлагууд тусгагдах болно.

99. Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг хийхдээ уг хуулийн үйлчлэх хүрээг шүүхэд хэрэг үүсгэхээс өмнөх маргаан дээр нэхэмжлэл гаргах (ө.х. шүүхээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хийгдэхгүй)-тай холбон тэлэхээр бол Сингапурт хэрэглэсэн энэхүү шинэ заалт (Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн s12-р хэсэг) сонирхолтой байж магадгүй. Энэ заалтаар хувийн эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд орж буй талууд (хуулийн дагуу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа эхлээгүй байх үед) шүүхээс эвлэрлийн гэрээгээ шүүхийн шийдвэрээр бүртгүүлэх хүсэлтийг гаргаж болдог.
100. Хуулийн 29.1-р зүйлийн талаарх дээр дурдсан тайлбарыг үзнэ үү. Энд зарим тохиолдолд талууд эвлэрүүлэн зуучлах ажиллагааны хөлсийг урьдчилан төлөх үүргийн талаар заасан байна.
101. Хуулийн 30.4-т зааснаар талууд эвлэрүүлэн зуучлах ажиллагааны хүрээг тодорхойлох боломжтой гэж харагдаж байна. Энэ нь талуудын бие даасан байдалтай нийцэж байгаа ч илүү тодорхой болгох нь зүйтэй.

7.2. Эвлэрүүлэн зуучлагчдын эрх, үүрэг

102. Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 14 дүгээр зүйлд эвлэрүүлэн зуучлагчийн эрх, үүргийг тусгасан байна. Эдгээртэй холбогдох ерөнхий зөвлөмжийг доор жагсаав.
103. Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 14.1.1-д “маргааны шинж байдлаас шалтгаалан” гэснийг хасахыг зөвлөж байна, учир нь энэ нь ажлын хөлсний хэмжээг тодорхойлох үзүүлэлт биш юм.
104. Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 14.1.2-т “үйл ажиллагааныхаа талаар олон нийтэд мэдээлэх” гэсэн нь эвлэрүүлэн зуучлах ажиллагааг ерөнхийд нь сайшаан дэмжихтэй холбоотой гэж санагдлаа. Хэрэв тийм бол, үүнийг тусад нь заалт болгон оруулахыг санал болгож байна.
105. Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 14.1.5 дэх заалт нь эвлэрүүлэн зуучлагчид санал тавих, ө.х. зөвлөх, эсвэл үнэлгээний арга барил хэрэглэхийг зөвшөөрч байгаа мэт харагдаж байна. Энэ нь бусад загварын оронд үнэлгээний эвлэрүүлэн зуучлах ажиллагааг сайшаан дэмжих талтай тул уг заалтыг хасахыг санал болгож байна. Хэрэв эвлэрүүлэн зуучлалын тухай санал болгож буй энэ тодорхойлолтыг зөвшөөрч байгаа бол энэ нь эвлэрүүлэн зуучлах ажиллагааны төрөл бүрийн загварыг багтаасан өргөн хүрээтэй байж чадаж байна. Үүнд үнэлгээ хийх эвлэрүүлэн зуучлал ч орж байгаа. **Тэхээр 14.1.5-д заасантай адил зохицуулалтыг хууль тогтоомжоор**

⁶⁶ Eunice Chua, “Эвлэрүүлэн зуучлалын тухай Сингапурын конвенцийг ашиглахгүйгээр олон улсын эвлэрүүлэн зуучлалыг хэрэгжүүлэх”, Сингапурын Хуулийн Академийн сэтгүүл 2019 31 х. 572: <https://journalsonline.academypublishing.org.sg/Journals/Singapore-Academy-of-Law-Journal-Special-Issue/Current-Issue/ct/eFirstSALPDFJournalView/mid/503/ArticleId/1472/Citation/JournalsOnlinePDF>

Монгол Улсын Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд өгөх АИХЭГ-ын санал дүгнэлт

- биш, институцийн дүрмээр зохицуулбал илүү сайн.** Харьцуулбал: 14.2.7-д зааснаар эвлэрүүлэн зуучлагч нь эрх зүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлж болохгүй. Бодитой, үндэслэлтэй санал дэвшүүлэхэд эрх зүйн санал зөвлөмж агуулж болохоор байгаа учраас эрх зүйн зөвлөгөөг 14.1.5-т заасан хувилбараас ялгахад хэцүү байна.
106. Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 17.2-т “саад болох аливаа нөхцөл байдал” гэдэг нь тодорхойгүй байна. Хэрэв яг тодорхой утга байхгүй бол үүнийг хасахыг зөвлөж байна.
107. Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 21.5, 21.6-р зүйлд эвлэрүүлэн зуучлагч нь талуудтай холбоо тогтоохоор заасанд асуудал алга байна. Гэхдээ орчуулгад эвлэрүүлэн зуучлагч нь талуудыг шаардан ирүүлэх, “дуудаж ирүүлэх” гэсэн хэллэгийг ашигласан байгаа нь эвлэрүүлэн зуучлагчийн шударга, алагчлалгүй байхад нөлөөлж болзошгүй тул үүнийг ямар нэг шаардлага болгож оруулах ёсгүй.
108. Протокол, тэмдэглэлтэй холбоотой эвлэрүүлэн зуучлагчийн үүргийг 25-р зүйлд тусгасан байна. Энд “эвлэрүүлэн зуучлалын гэрээ” гэсэн нэр томъёог өмнө нь тайлбарласны дагуу хэрэглэнэ.
109. Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 26.1-т зааснаар талууд хүсэлт гаргасан тохиолдолд эвлэрүүлэн зуучлагч эвлэрлийн гэрээний төслийг боловсруулж болно гэжээ. Энэ заалт нь зуучлагчийн шударга байх зарчимд эрсдэл учруулах магадлалтай тул хасахыг санал болгож байна. Зарим эвлэрүүлэн зуучлагч ийнхүү боловсруулах явдал байдаг боловч буруу хэрэглэх эрсдэлтэй тул ийм практикийг Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулиар сайшаах ёсгүй.⁶⁷
110. Талуудын бичгээр гаргасан зөвшөөрлөөс бусад тохиолдолд адилхан хэрэг дээр эвлэрүүлэн зуучлагч арбитрын үүрэг гүйцэтгэгчээр ажиллахыг сэргийлсэн заалтыг анхаарч үзэх хэрэгтэй. Ийм заалт нь энэ мэт холимог үйл явц дээр эвлэрүүлэн зуучлагч, арбитрчдын эсрэг гардаг нэг талд үйлчилсэн гэх нэхэмжлэлийг бууруулж өгнө.

7.3. Өмгөөлөгчдийн эрх, үүрэг

111. Өмгөөлөгчид дараах үүргийг хүлээж болно. Үүнд:
- үйлчлүүлэгчийнхээ эрх ашигт нийцсэн үйл ажиллагаа явуулах;
 - тухайн нөхцөл байдалд тохирч байвал үйлчлүүлэгчээ эвлэрүүлэн зуучлуулахыг зөвлөх
 - эрх ашигт нь нийцэж байвал үйлчлүүлэгчээ тохиролцоонд хүрэхийг зөвлөх;
 - нууцлал болон бусад үүрэг, эрхийн талаар үйлчлүүлэгчдээ зөвлөгөө өгөх;
 - бусад талууддаа болон өмгөөлөгчдөд шударга, итгэл үнэмшлээр хандах үүрэг;
 - нууцлалтай холбоотой үүрэг.
112. Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн өмгөөлөгчийн эрх, үүргийн талаар заасан 15-р зүйлд дараах үүргийг заагаагүй байна. Эдгээр үүргийг оруулахыг зөвлөж байна. Үүнд:
- үйлчлүүлэгчийнхээ эрх ашигт нийцсэн үйл ажиллагаа явуулах;
 - тухайн нөхцөл байдалд тохирч байвал үйлчлүүлэгчээ эвлэрүүлэн зуучлуулахыг зөвлөх (талуудын хүлээх үүргийн талаар заасан дээрх 90-ийг үзнэ үү);
 - эрх ашигт нь нийцэж байвал үйлчлүүлэгчээ тохиролцоонд хүрэхийг зөвлөх;

⁶⁷ Жишээ нь дараахыг үзнэ үү: [Tappohi v Lewenberg No. 2 \(2003\) VSC 410 \(Australia\)](#)

Монгол Улсын Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд өгөх АИХЭГ-ын санал дүгнэлт

Хуулийн 15.3 дахь заалтыг эвлэрүүлэн зуучлах ажиллагааг сайшаан дэмжихийн тулд шударга, итгэл үнэмшилтэй байх үүрэг болгож эерэг байдлаар тусгаж өгөх боломжтой.

7.4. Гуравдагч этгээдийн болон шүүхийн эрх, үүргүүд

113. Гуравдагч этгээдийг талуудын хүсэлтээр эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд оролцуулж болно – үүнийг ерөнхийдөө хүлээн зөвшөөрдөг. Гэхдээ талуудын зөвшөөрөлгүйгээр эвлэрүүлэн зуучлалд оролцож болохгүй. Үүнийг 16.1-д илүү тодорхой болгох хэрэгтэй.
114. Хуулийн 27.2-т шүүх нь эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр байгуулсан эвлэрлийн гэрээг баталгаажуулна гэж заажээ. Энэ заалт нь эвлэрлийн гэрээг шүүхийн шийдвэр гэдгээр нь хүлээн авч, шуурхай хэрэгжүүлэх боломжийг олгон баталж буй заалт гэж байгаа эсэх нь тодорхойгүй байна. Цаашлаад энд эвлэрүүлэн зуучлагчийн үүрэг ямар байх нь тодорхойгүй байна. Эвлэрүүлэн зуучлагчид нь шударга үнэнч байх ёстой бөгөөд тэдний үүрэг эвлэрүүлэн зуучлах ажиллагаагаар дуусгавар болдог. Энэхүү заалт нь 27.1-д заасны дагуу эвлэрлийн гэрээний үүргийг дагаж мөрдөөгүй тохиолдолд шүүхэд хандахад хамаарч болох юм. Энэ тохиолдолд Сингапурын эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 5-р зүйл, ЮНИСТРАЛЫН Загвар хуулийн 19-р зүйлд заасан албадан хэрэгжүүлэх шаардлагаас татгалзах (албадан хэрэгжүүлэхээс татгалзах үндэслэл) тухай оруулах нь чухал юм. Энэ санал 30.2-т мөн хамаарна. Шүүхэд эвлэрлийн гэрээний үүргийг хэрэгжүүлүүлэх шийдвэр гаргахаас татгалзах шалтгаан байж болно.

8. Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны нууцлал, нотлох баримтаар үнэлэгдэхгүй байх**8.1. Нууцлалтай холбоотой үүрэг хариуцлагууд**

115. Ерөнхийдөө нууцад хамаарах асуудлыг энэ хуульд хангалттай авч үзээгүй байна. Холбогдох заалтууд нь 18.2, 18.3, 18.4, 18.6 зэрэг заалтууд байгаа бөгөөд шүүх болон арбитрын хянан шийдвэрлэх ажиллагаанууд дээр нууцыг хадгалах, эвлэрүүлэн зуучлах ажиллагааны явцад бий болсон мэдээллийг нотлох баримтаар хүлээн зөвшөөрөхгүй зэрэг янз бүрийн асуудлуудыг тусгажээ (дээр 4.2. дахь хэсэгт тайлбарласан нууцлал нь эвлэрүүлэн зуучлах ажиллагааны чухал зарчим байдаг тухай болон бусад холбогдох тайлбаруудыг үзнэ үү). **Эдгээр заалтыг бүгдийг нь нууцлал болон нотлох баримтаар үнэлэгдэхгүй байх тухай тусад нь заасан нэг зүйл, эсвэл хэд хэдэн зүйл заалт болгон нэгтгэн тусгавал зүйтэй юм.**
116. Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд нууцлалыг хангах үүргийг эвлэрүүлэн зуучлагчдад хандан тусгаж өгсөн боловч талууд, өмгөөлөгчид болон бусад оролцогчдод хамааруулж заагаагүй байна. Цаашилбал, заалтуудыг 18-р зүйлд заасан бусад үүргийн хамт нэгтгэн тусгажээ. **Эдгээр зүйл заалтыг эвлэрүүлэн зуучлагч, талууд, өмгөөлөгч, бусад оролцогчдод хамаарах нууцын заалтууд болгон дахин боловсруулахыг зөвлөж байна.** (дээрх 4.2. дахь хэсгийг үзнэ үү). Үүнтэй холбогдуулан дурдахад, ЮНИСТРАЛЫН Загвар хууль,⁶⁸ Сингапурын эвлэрүүлэн зуучлалын тухай хууль, Хонг Конгийн Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль (8, 9, 10-

⁶⁸ Дараахыг үзнэ үү: ялангуяа [Эвлэрүүлэн зуучлалын үр дүн бий болсон Олон улсын худалдааны зуучлалын тухай UNCITRAL Загвар хууль \(2018\)-ийн](#) 9-р зүйл (дотогш/дотогш урсгалтай нууцлал), 10-р зүйл (дотогш/гадагш урсгалтай нууцлал), 11-р зүйл (дотогш/шүүх урсгалтай нууцлал)

Монгол Улсын Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд өгөх АИХЭГ-ын санал дүгнэлт

р хэсэг) зэрэг нь хууль боловсруулагчдад хэрэгтэй удирдамж болж чадна. Үүний зэрэгцээ, хууль тогтоомжоор дотогш/гадагш болон дотогш/шүүхийн гэсэн урсгал чиглэлтэй нууцлалыг зохицуулахыг ерөнхийдөө зөвлөдөг боловч дотогш/дотогш чиглэлтэй нууцлалыг зохицуулахыг ер нь зөвлөдөггүй, үүнийг ихэвчлэн институцийн ёс зүйн дүрмээр зохицуулдаг, гэхдээ ЮНИСТРАЛЫН Загвар хуулийн 9-р зүйл нь энэ утгаараа ердийн биш юм.

8.2. Нууцлалыг хадгалахад үл хамаарах нөхцөлүүд

117. Нууцлалыг хадгалахад үл хамаарах нөхцөлүүд бол чухал зүйл. Эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд нууцлалыг нийтлэг ерөнхий байдлаар тусгах нь эвлэрүүлэн зуучлагчид, талууд, өмгөөлөгчид болон бусад хүмүүст үүрэг хариуцлага хүлээлгэдэггүй тул ажиллагааны шударга үнэн байдлыг бууруулдаг. Нууцлалын тухай олон улсын хуулиудын харьцуулсан тоймоос харахад үл хамаарах нөхцөлийн дараах үндсэн ангилал байна. Үүнд:

- Өөр байдлаар, эсвэл адил төстэй процедураар ил болж болох *байсан өмнөх мэдээлэл*. Энэхүү үл хамаарах нөхцөлийн ард буй зарчим нь өөр тохиолдолд нотлох баримтаар үнэлэгдэж, хүлээн зөвшөөрөгдөх байсан зүйл эвлэрүүлэн зуучлах ажиллагааны явцад ил болбол нотлох баримтаар үнэлэгдэхгүй гэсэн үг биш гэсэн утгатай.⁶⁹ Өөрөөр хэлбэл, талууд өөр байдлаар ил болгох боломжтой байсан мэдээллийг нуун дарагдуулахын тулд эвлэрүүлэн зуучлах ажиллагааг ашиглах ёсгүй, учир нь энэ нь эвлэрүүлэн зуучлалыг урвуулан ашигласанд тооцогдоно.⁷⁰
- *Олон нийтэд нээлттэй мэдээлэл*. Энэхүү үл хамаарах нөхцөл нь ерөнхийдөө нээлттэй байж байдаг мэдээлэл, эсвэл мэдээлэл авах эрх чөлөө,⁷¹ нууцлалын тухай хуулийн дагуу авах боломжтой мэдээлэлд хамаарна.⁷² Энэ нь талууд олон нийтэд нээлттэй байлгана гэж хоорондоо тохиролцсон, эсвэл хуулиар олон нийтэд нээлттэй болгох шаардлагатай, эвлэрүүлэн зуучлах ажиллагааны аль нэг үе шатанд бий болсон мэдээлэлд мөн хамаарна.
- *Хүлээсэн үүрэг/мэргэжлийн ёс зүйгээ зөрчих*. Үл хамаарах өөр нэг нөхцөл бол эвлэрүүлэн зуучлагч ба талуудын хооронд маргаан гарсан тохиолдолд, эсхүл эвлэрүүлэн зуучлагч болон зуучлалын ажиллагаанд оролцож буй бусад оролцогчид, тухайлбал хууль ёсны төлөөлөгчдийн мэргэжлийн ёс зүй зөрчигдөж байвал эвлэрүүлэн зуучлалын талаарх мэдээллийг нээлттэй байлгахыг зөвшөөрөх тохиолдол юм.⁷³

⁶⁹ Дараахыг үзнэ үү. Жишээ нь, [UMA](#)-ийн s 5, [Эвлэрүүлэн зуучлалын үр дүн бий болсон Олон улсын худалдааны зуучлалын тухай UNCITRAL Загвар хууль \(2018\)-ийн](#) 11(5) зүйл болон *AWA v Daniels* (1992) 7 ASCR 436 and *Aird and Aird v Prime Meridian* [2006] EWCA Civ 1886 хэргүүд.

⁷⁰ S Hughes, 'Uniform Mediation Act: To the Spoiled Go the Privileges' (2001) 85 *Marquette Law Review* 9.

⁷¹ Дараахыг үзнэ үү: [UMA](#)-ийн s 7(a)(2). АНУ-ын Холбооны түвшинд 1966 оны Мэдээллийн эрх чөлөөний тухай хууль, мужийн түвшинд Open Records Acts хууль, эсвэл Open Public Records Acts зэргийг үзнэ үү: [Washington's Open Records Act \(Revised Code of Washington \(RCW\) s 42.56\)](#) болон [California Public Records Act \(California Government Code §§ 6250 – 6276.48\)](#). Английн хувьд [Freedom of Information Act 2000](#), Австралийн хувьд [Freedom of Information Act 1982 \(Cth\)](#) холбооны түвшинд болон улсын түвшинд төрөл бүрийн FOI хуулиудыг үзэж болно.

⁷² Дараахыг үзнэ үү. Жишээ нь, Австралийн Хувийн нууцын тухай хууль [Privacy Act 1988 \(Cth\)](#).

⁷³ Тухайлбал, эдгээр үл хамаарах нөхцөлүүдийг [UMA](#)-ийн 6(a) (5) ба 6(a) (6) зүйлүүдэд тайлбарласан байдаг. Үүнтэй адил Флоридагийн [Эвлэрүүлэн зуучлалын нууцлал ба давуу эрхийн тухай акт](#) хуульд заасны дагуу эвлэрүүлэн зуучлагчийн буруутай үйлдлээс хамгаалах, эсвэл баталгаа болгож нууцыг дэлгэхийг зөвшөөрдөг (Эвлэрүүлэн зуучлалын нууц ба давуу эрхийн тухай хууль [FS 44.405]-ийг үзнэ үү; Үүний эсрэгээр, *Morgan Phillips v JAMS/Endispute LLC* (2006) Cal App 4th 795, 44 Cal Rptr 3d 782)-д хэлэлцүүлсэнчлэн Калифорнийн нууцлалын заалтыг харьцуулж үзнэ үү. Словакийн эвлэрүүлэн зуучлалын тухай хууль тогтоомжоор зуучлагчид мэргэжлийн үүргээ зөрчсөн эсэхийг нь үнэлэхэд шаардагдахаас бусад тохиолдолд нууцлалыг хадгалах үүрэг хүлээхгүй гэж заасан байдаг (дараахыг үз § [Эвлэрүүлэн зуучлал ба тодорхой хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулах тухай Словакийн 2004 оны 6-р сарын 25-ны хуулийн](#) 6). Үл хамаарах нөхцөлийн талаар заасан хэдий ч UMA-д эвлэрүүлэн зуучлагч

Монгол Улсын Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд өгөх АИХЭГ-ын санал дүгнэлт

- *Гэмт хэрэг үйлдэхээр төлөвлөх, оролдох, эсвэл одоо үргэлжилж буй эрүүгийн үйлдлийг нуух зорилгоор ирээдүйд гарч болзошгүй хүчирхийлэл, бусдад болон харилцаанд хор хөнөөл учруулах аюул заналхийлэл.*⁷⁴ Гэхдээ олон хууль тогтоомжид энэ талаар ихэнхдээ чимээгүй байдаг ба тухайн үл хамаарах нөхцөлийг нийтийн эрх ашиг, бодлогын үндэслэлд тусгах ерөнхий зарчимд нь тулгуурлах байдлаар шүүхэд хариуцуулж үлдээдэг. Бусад үл хамаарах нөхцөлийн хувьд, эдгээр заалтуудын гол зорилго нь эвлэрүүлэн зуучлах ажиллагааны шударга үнэн байдлыг хамгаалах, эрүүгийн үйл ажиллагаа явуулахаар санаархаж буй, эсвэл түүнд оролцож буй этгээдүүд үүнийг буруугаар ашиглахгүйн тулд нээлттэй орхидоггүй. Энд хүнийг бие махбодийн болон сэтгэл зүйн хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх нь ч бас олон нийтийн эрх ашигт хамаатай чухал асуудал юм. Гэхдээ энэ асуудалд хандах арга барил нь үндэсний эрх зүйн соёл, нийтэд хандсан төрийн бодлогоос ихээхэн хамаарна. Зарим тохиолдолд эвлэрүүлэн зуучлалд оролцож буй аль нэг тал эрүүгийн гэмт хэрэг үйлдсэн гэж хүлээн зөвшөөрвөл энэ нь үл хамаарах нөхцөлийг чөлөөлөх, хүчингүй болгох ёсгүй, учир нь үүнээс болж талуудын эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд оролцох итгэл алдарна гэсэн санал ч байдаг. Гэсэн хэдий ч зарим улс оронд эвлэрүүлэн зуучлагчдаас тодорхой төрлийн гэмт хэргийг мэдсэн бол цагдаагийн байгууллагад мэдээлэхийг шаарддаг зохицуулалтууд байдаг.⁷⁵
- *Хүүхэд ба эмзэг бүлгийг хүчирхийлэх.*⁷⁶ Хүүхэд болон нийгмийн бусад эмзэг бүлгийн гишүүдийг хамгаалах нь эмч, өвчтөний хоорондох харилцаа гэх зэрэг олон нөхцөл байдалд нууцлалтай харьцах төрийн бодлогын үл хамаарах нөхцөл байсаар ирсэн. Үүнтэй адилаар хүүхэд, эмзэг бүлгийн гишүүдийг хүчирхийлэх, үл хайхрах, орхигдуулах зэрэг авир үйлдлийг илрүүлэн харуулах эвлэрүүлэн зуучлалын мэдээлэл нь нууцлалыг хадгалах заалтад хамаарахгүй.
- *Тохиролцоонд буюу эвлэрэлд хүрэх боломж байгааг нотлох.* Нууцлалыг хадгалахад үл хамаарах нөхцөлүүд нь ихэвчлэн эвлэрүүлэн зуучлах ажиллагааны дараах арга хэмжээнүүд дээр үүсдэг, учир нь зуучлалын үр дүнд хүрсэн тохиролцоог батлах, салгах, эсвэл өөр этгээдэд арга хэмжээ авахуулахаар хэрэг үүсгэх зэрэг ажлууд гарч ирдэг (доороос харна уу).⁷⁷

нарыг ялангуяа эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд оролцож буй төлөөлөгчид болон бусад этгээдүүдийн эсрэг мэргэжлийн ёс зүйгээр зөрчин нотлох баримт гаргаж өгөхийг онцгойлон хориглодог (6 (с)).

⁷⁴ Энэ талаарх заалтуудыг дараахаас харж болно, жишээ нь, [UMA](#)-ийн s 5 (c) ба s 6 (a) (3), (4), [Европын удирдамжийн 7\(1\)\(a\)](#) зүйл болон өмнө дурдсан [Германы Эрүүгийн хууль](#).

⁷⁵ Дараахыг үзнэ үү: жишээ нь, Австралийн Эрүүгийн тухай хуулийн s 316-р зүйлд ноцтой гэм буруутай үйлдэл хийснийг мэдсэн хүн цагдаад мэдэгдэх ёстой бөгөөд энэ тухай мэдэгдээгүй бол хорих ял шийтгэгдэнэ. Энэ тайланг бичиж байх үед эвлэрүүлэн зуучлагч нар энэ заалтад хамрагдаагүй байсан ба бусад эмч, өмгөөлөгч зэрэг мэргэжлийн хүмүүс уг заалтаас чөлөөлөгдсөн байв.

⁷⁶ Жишээнүүдийг [UMA](#) -ийн s 6(a)(7) болон Эвлэрүүлэн зуучлалын тухай Европын удирдамжийн [Directive 2008/52/EC](#) 7 (1) (a) хэсгээс үзэж болно.

⁷⁷ Жишээ нь, [Эвлэрүүлэн зуучлалын үр дүн бий болсон Олон улсын худалдааны зуучлалын тухай UNCITRAL Загвар хууль \(2018\)-ийн 11\(3\)2-т](#) эвлэрлийн гэрээг хэрэгжүүлж, мөрдүүлэх зорилгоор нотлох баримтыг нээлттэй болгож, хүлээн зөвшөөрнө гэж заажээ. Эвлэрүүлэн зуучлалын тухай Европын [Directive 2008/52/EC](#) удирдамжийн 7(1)(b)-д зуучлагчийн гэрчлэлийг хориглохтой холбоотой төстэй нэг заалт бий, үүнийг илүү нарийвчлан харилцааны нотлох баримтыг шүүхэд гаргаж өгөхийг эсвэл мөрдүүлэхийн тулд эвлэрүүлэн зуучлалын үр дүнд бий болсон *гэрээний* агуулгыг ил болгох зайлшгүй шаардлага гарах үед” [онцлох үүднээс ташуу бичив]. Энэ мэт үл хамаарах нөхцөлүүд дотоодын хууль тогтоомж, практикт ихэвчлэн байдаг. Жишээ нь, АНУ-д үл хамаарах энэ заалтыг [UMA](#)-ийн s 6(b) олон нийтийн ашиг сонирхлын заалтад тусгасан байдаг. Гэвч UMA-аар иймэрхүү нэхэмжлэлтэй холбоотойгоор эвлэрүүлэн зуучлалын харилцааны нотлох баримтыг шүүхэд гаргаж өгөхийг зуучлагчдаас албадаж шаардахгүй байхаар зааж өгчээ (6 (с)). Өөрөөр хэлбэл, эвлэрүүлэн зуучлагчдээс эвлэрлийн гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор талууд, эсвэл бусад оролцогчдын үйлдлийн талаар гэрчлэл өгөхийг шаардаж болохгүй, гэхдээ бусад эх сурвалжаас нотлох баримтыг ашиглаж болно. Тиймээс, UMA-ийн яг энэ үл хамаарах заалтуудын нөхцөл нь хууль эрх зүйн бусад хэрэгслүүдэд зааж өгсөн ижил төстэй нөхцлийг бодвол нууцлал хадгалахтай холбоотой аюулгүй байдлын талаас авч үзвэл зуучлагчдад үнэмлэхүй биш ч гэсэн арай илүү хязгаарлалттай байгаа юм. Эдгээр нөхцөл байдалтай холбоотой хэрэг

Монгол Улсын Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд өгөх АИХЭГ-ын санал дүгнэлт

- *Зардал тодорхойлох.* Зарим улс оронд шүүхүүд нь тухайн эвлэрүүлэн зуучлах ажиллагааны зардлын талаар өргөдөл өгсөн эвлэрүүлэн зуучлах ажиллагаанаас гарах, эсвэл тухайн эвлэрүүлэн зуучлах ажиллагаатай холбоотой шүүхийн хянан шийдвэрлэх ажиллагаанаас гарах хязгаарлагдмал нотлох баримтыг үнэлэн, зөвшөөрөхөд бэлэн байдаг. Энэ нөхцөлд нотлох баримт нь оролцогчдын үнэнч шударга биш байдлыг нь илэрхийлэх, эсвэл тухайн эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд ямар нэг үндэслэлгүй зан байдал гаргаж буй талаарх нотлох баримт болгон ашиглагдаж болно.⁷⁸

118. Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд нууцлалтай холбогдох заалтууд дээр үл хамаарах нөхцөлүүдийг оруулж өгөх, мөн дээр дурдсанчлан, дотогш/шүүх гэсэн чиглэлтэй нууцлалд хамаарах шүүхийн талаарх заалтуудыг харгалзан үзэхийг зөвлөж байна.

[БИЧВЭРИЙН ТӨГСГӨЛ]

маргааныг эвлэрүүлэн зуучлалын дараах асуудлаар дараагийн бүлэгт тодорхой авч үзнэ. Гэхдээ Английн [Brown v Rice and Patel \[2007\] EWHC 625 \(Ch\)](#) хэргийг энд дурдсан нь энэхүү үл хамаарах нөхцөлийг яаж өргөн утгаар тайлбарлаж болохыг харуулахад чиглэсэн юм. Энэ тохиолдолд эвлэрүүлэн зуучлуулах гэрээг оруулж байгаа нь эвлэрлийн гэрээ нь бичгээр үйлдэж, гарын үсэг зураагүй л бол дагаж мөрдөхөөр хүчин төгөлдөр болохгүй гэдгийг ойлгуулах зорилготой. Тэглээ ч эвлэрлийн гэрээг хэрэгжүүлэхийг эрмэлзэж буй тал нь талуудын хооронд ямар нэг тохиролцоо байгаа гэдгийг нотлохын тулд эвлэрүүлэн зуучлах ажиллагааны явцын баримт нотолгоог хүлээн зөвшөөрөхийг зорино. Эвлэрүүлэн зуучлах үйлчилгээг үзүүлж буй тал (ADR Group) болон нөгөө талын зүгээс эсэргүүцэл гаргасан ч шүүх эвлэрүүлэн зуучлалын ажиллагааны нотлох баримтыг ямар нэг тохиролцоонд хүрсэн тохиролцоо байгаа гэдгийг батлах үүднээс уг нотлох баримт нь журамд үл хамаарах нөхцөлд орно гэдэг үндэслэлээр хүлээн зөвшөөрсөн. Шүүгч өөрийн үзэл бодлыг зөвтгөх үндэслэлээ гаргахдаа талууд эвлэрүүлэн зуучлуулах гэрээндээ бичгээр тавьсан шаардлагыг шаардах тал дээр өөр өөр байж болно, татгалзаж, эсвэл бүр няцааж ч болно гэж үзсэн. Гэхдээ талууд зөвхөн бичгээр үйлдэж, гарын үсэг зурсан гэрээг хууль ёсны хүчин төгөлдөр гэж үзнэ гэж хүлээн зөвшөөрсөн тохиолдолд шүүх эдгээр шалгуурт нийцээгүй ямар нэг тохиролцоог бий болгохын тулд эвлэрүүлэн зуучлах ажиллагааны нууцлал бүхий мэдээллийг шалгаж нягтлаад байх шаардлагагүй гэдэг дохиог талууд шүүхэд өгч байна. Энэ үл хамаарах заалтыг *Brown v Rice and Patel* хэрэг дээр шүүхийн хэрэглэсэн энэхүү өргөн утгатай тайлбараас харахад талуудын болон бусад оролцогчдод санал болгож буй нууцлалыг хадгалж хамгаалах тал дээр итгэлтэй байхыг дэмжихгүй байна.

⁷⁸ Энэ дүгнэлтийн талуудын хүлээх үүрэг гэсэн 7.1 дэх хэсгийг үзнэ үү.

ХАВСРАЛТ:

Монгол Улсын Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль (2012 оны 5-р сарын 22)



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 5 дугаар сарын 22-ны
өдөр

Улаанбаатар хот

ЭВЛЭРҮҮЛЭН ЗУУЧЛАЛЫН ТУХАЙ

**Нэгдүгээр бүлэг
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь эрх зүйн маргааныг шүүхийн бус аргаар эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгчтэйгээр шийдвэрлэх эрх зүйн үндсийг тогтоох, эвлэрүүлэн зуучлалыг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

[/Энэ хэсэгт 2013 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

2 дугаар зүйл.Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль тогтоомж

2.1.Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай, Гэр бүлийн тухай, Хөдөлмөрийн тухай, Арбитрын тухай, Шүүхийн тухай, Шүүхийн захиргааны тухай хууль, энэ хууль, эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Иргэний эрх зүйн маргаан, хөдөлмөрийн ганцаарчилсан маргаан болон гэр бүлийн харилцаанаас үүссэн маргаанд эвлэрүүлэн зуучлалыг хэрэглэнэ.

3.2.Энэ хуулийн 3.1-д зааснаас бусад харилцаанаас үүссэн маргаанд эвлэрүүлэн зуучлалыг зөвхөн хуульд тусгайлан заасан тохиолдолд хэрэглэж болно.

Монгол Улсын Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд өгөх АИХЭГ-ын санал дүгнэлт

3.3.Эвлэрүүлэн зуучлалыг шүүхэд иргэний хэрэг, арбитраж маргаан үүсгэснээс хойш хянан шийдвэрлэх ажиллагаанд хэрэглэж болно.

3.4.Энэ хуулийн 3.1-д заасан харилцаанаас үүссэн маргаан нь эвлэрүүлэн зуучлалд оролцоогүй гуравдагч этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг, эсхүл нийтийн ашиг сонирхлыг хөндөхөөр бол эвлэрүүлэн зуучлалыг хэрэглэж болохгүй.

3.5.Хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн зохицуулалт эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэггүйгээр зохигчид сайн дурын үндсэн дээр маргаанаа шийдвэрлэх, түүнчлэн хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэх шүүгчийн үйл ажиллагаанд хамаарахгүй.

3.6.Арбитраж маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд эвлэрүүлэн зуучлагч оролцоулах эсэхийг журмаараа тогтоож болно.

4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“эвлэрүүлэн зуучлал” гэж талуудын хооронд үүссэн маргааныг шүүхийн бус аргаар шийдвэрлэхэд энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу дэмжлэг үзүүлэх эвлэрүүлэн зуучлагчийн ажиллагааг;

4.1.2.“талууд” гэж эвлэрүүлэн зуучлах журмаар энэ хуулийн 3.1-д заасан маргааныг зохицуулах хүсэлт гаргасан иргэн буюу хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй этгээдийг, түүнчлэн шүүх эвлэрүүлэн зуучлалыг зохистой гэж үзэж санал болгосныг зөвшөөрснөөр эвлэрүүлэн зуучлалд оролцох болсон зохигчийг;

[Энэ заалтад 2013 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

4.1.3.“эвлэрүүлэн зуучлагч” гэж тухайн маргаанд зуучлуулахаар талуудын сонгосон буюу зөвшөөрсөн, маргааны талаар шийдвэр гаргахад нь дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий мэргэшсэн этгээдийг;

4.1.4.“эвлэрлийн гэрээ” гэж маргаан буюу тодорхой санал зөрөлдөөнтэй асуудалд эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулсны үр дүнд талуудын хооронд бичгээр хийсэн хэлцлийг.

**ХОЁРДУГААР БҮЛЭГ
ЭВЛЭРҮҮЛЭН ЗУУЧЛАХ АЖИЛЛАГАА****5 дугаар зүйл.Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны зорилго, үндсэн зарчим**

5.1.Эвлэрүүлэн зуучлалын зорилго нь талууд өөрсдийн ашиг сонирхолд нийцэхүйц шийдлийг олоход нь зуучлагч дэмжлэг үзүүлж, тэдгээрийн хоорондын харилцааны зөрчил, маргааныг эвийн журмаар, шуурхай, зардал багатай зохицуулахад оршино.

5.2.Эвлэрүүлэн зуучлалыг дараах зарчимд үндэслэн явуулна:

5.2.1.талуудын сайн дурын үндсэн дээр хэрэгжих;

5.2.2.эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд оролцогчдын нууцыг хадгалах;

5.2.3.эвлэрүүлэн зуучлагч төвийг сахисан байр суурьтай байх;

Монгол Улсын Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд өгөх АИХЭГ-ын санал дүгнэлт

5.2.4.эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд талууд тэгш эрхтэй оролцох.

6 дугаар зүйл.Эвлэрүүлэн зуучлах журмаар маргаан шийдвэрлэх харьяалал

6.1.Талууд маргаанаа эвлэрүүлэн зуучлах журмаар шийдвэрлүүлэх хүсэлтээ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 14-16 дугаар зүйлд заасан харьяаллын дагуу анхан шатны шүүх дэх эвлэрүүлэн зуучлагчид, эсхүл энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан эвлэрүүлэн зуучлагчид гаргана.

6.2.Шүүх маргалдагч талуудад эвлэрүүлэн зуучлалын талаарх мэдээллийг бүрэн өгч, шүүхэд иргэний хэрэг үүсгэхээс өмнө болон хойно, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шат бүрд талуудыг эвлэрэх боломжоор хангаж, эвлэрүүлэн зуучлагчийн туслалцаа авах талаар сануулах үүрэгтэй.

6.3.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 132.4-т зааснаас бусад гэр бүлийн харилцаанаас үүссэн маргааны эвлэрүүлэн зуучлах ажиллагааг шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлэх ажиллагааны нэг гэж үзнэ.

6.4.Талууд маргааныг эвлэрүүлэн зуучлалын журмаар шийдвэрлүүлэхээр гэрээндээ хэлэлцэн тохиролцсон бол шүүхийн бус аргаар урьдчилан шийдвэрлэх журам тогтоосон гэж үзнэ.

6.5.Энэ хуулийн 6.3, 6.4-т заасан журмыг зөрчиж нэхэмжлэл гаргасан бол шүүх Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 65.1.3-т заасны дагуу уг нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзана.

7 дугаар зүйл.Шүүх дэх эвлэрүүлэн зуучлагч

7.1.Анхан шатны шүүх дээр орон тооны болон орон тооны бус эвлэрүүлэн зуучлагч ажиллана.

[Энэ хэсэгт 2013 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/](#)

7.2.Энэ хуулийн 7.1-д заасан эвлэрүүлэн зуучлагчийн үйл ажиллагааны зохион байгуулалт, хүний нөөцийн удирдлагыг Шүүхийн ерөнхий зөвлөл болон тухайн шүүхийн тамгын газар хариуцаж, холбогдох төсвийг тухайн шүүхийн төсвөөс гаргана.

8 дугаар зүйл.Төрийн болон төрийн бус байгууллага дахь эвлэрүүлэн зуучлагч

8.1.Төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоо үйл ажиллагааныхаа чиглэлийн дагуу тухайн салбарын эрх зүйн харилцаанаас үүссэн маргааныг шийдвэрлэх эвлэрүүлэн зуучлагчийг ажиллуулж болно.

8.2.Энэ хуулийн 8.1-д заасан зуучлагчаар дээд боловсролтой, эвлэрүүлэн зуучлагчийн сургалтад хамрагдан эрхийн гэрчилгээ авсан, тухайн чиглэлийн асуудлаар эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулах эвлэрүүлэн зуучлагчийн нэрсийн жагсаалтад бүртгэгдсэн мэргэшсэн эвлэрүүлэн зуучлагчийг ажиллуулна.

9 дүгээр зүйл.Эвлэрүүлэн зуучлагчид тавигдах шаардлага

9.1.Энэ хуулийн 7, 8 дугаар зүйлд заасан эвлэрүүлэн зуучлагчид дараах шаардлага тавигдана:

9.1.1.эрх зүйн бүрэн чадамжтай байх;

9.1.2.дээд боловсролтой байх;

Монгол Улсын Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд өгөх АИХЭГ-ын санал дүгнэлт

9.1.3.эвлэрүүлэн зуучлагчийн сургалтад хамрагдан эрхийн гэрчилгээ авсан байх;

9.1.4.эрх бүхий байгууллагын эвлэрүүлэн зуучлагчийн нэрсийн жагсаалтад бүртгэгдсэн байх;

9.1.5.ял шийтгэлгүй байх.

9.2.Эвлэрүүлэн зуучлагч нь үйл ажиллагаандаа энэ хуулийн 10.1-д заасан Эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөлөөс баталсан ёс зүйн дүрэм болон бусад журмыг баримтлан ажиллана.

10 дугаар зүйл.Эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөл

10.1.Шүүхийн ерөнхий зөвлөл нь эвлэрүүлэн зуучлагчийг сонгон шалгаруулах, гэрчилгээ олгох, бэлтгэх, давтан сургах ажлыг зохион байгуулах чиг үүрэг бүхий орон тооны бус Эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөл /цаашид “Зөвлөл” гэх/ -ийг байгуулна.

10.2.Зөвлөл нь шүүгч, өмгөөлөгч, судлаач зэрэг таван хүний бүрэлдэхүүнтэй байна.

10.3.Шүүхийн ерөнхий зөвлөл нь эвлэрүүлэн зуучлагчид гаргах өргөдөл, эвлэрлийн гэрээний болон мэдэгдэх хуудасны загварыг батална.

11 дүгээр зүйл.Зөвлөлийн бүрэн эрх

11.1.Зөвлөл нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

11.1.1.эвлэрүүлэн зуучлах ажиллагааны журам, дүрэм, эвлэрүүлэн зуучлагчийн зардал, ажлын хөлс, урамшууллын журам, эвлэрүүлэн зуучлагчийн ёс зүйн дүрэм, ажлын байрны стандартыг боловсруулах, батлах, хэрэгжилтэд хяналт тавих;

11.1.2.эвлэрүүлэн зуучлагчийг бэлтгэх, давтан сургах сургалтын хөтөлбөрийг боловсруулах, сургалт зохион байгуулах;

11.1.3.эвлэрүүлэн зуучлагчийг сонгон шалгаруулах, эрхийн гэрчилгээ олгох;

11.1.4.эвлэрүүлэн зуучлагчийг бүртгэх, нэрсийн жагсаалтыг олон нийтэд нээлттэй зарлах ажлыг зохион байгуулах;

11.1.5.эвлэрүүлэн зуучлагчийн эрхийг түдгэлзүүлэх, хасах, гэрчилгээг хүчингүй болгох, нэрсийн жагсаалтаас хасах;

11.1.6.Зөвлөлийн хуралдааны дэгийг тогтоох.

11.2.Зөвлөл нь зуучлагчийн нэрсийг анхан шатны шүүх, төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоонд санал болгоно.

11.3.Зөвлөлийн санал болгосон эвлэрүүлэн зуучлагчийн нэрсийн жагсаалтаас энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан байгууллага болон Шүүхийн ерөнхий зөвлөл эвлэрүүлэн зуучлагчийг сонгон бүртгэж, тэднийг холбогдох журмын дагуу ажиллах нөхцөл, боломжоор хангаж ажиллана.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ЭВЛЭРҮҮЛЭН ЗУУЧЛАХ АЖИЛЛАГААНЫ ОРОЛЦОГЧ

12 дугаар зүйл.Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны оролцогч

12.1.Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны оролцогч нь маргааны талууд, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, эрх ашиг нь хөндөгдсөн гуравдагч этгээд болон бусад этгээд байна.

[/Энэ хэсэгт 2013 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

12.2.Эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд хоёр ба, түүнээс дээш тал, нэг буюу хэд хэдэн зуучлагч оролцож болно.

12.3.Эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд талууд биечлэн, эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан оролцоно.

12.4.Хуульд өөрөөр заагаагүй бол эвлэрүүлэн зуучлах ажиллагааны явцад талууд харилцан зөвшилцсөний үндсэн дээр өмгөөлөгч, орчуулагч, хэлмэрч болон бусад этгээдийн туслалцаа авч болно.

13 дугаар зүйл.Эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд оролцогч талуудын эрх, үүрэг

13.1.Эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд оролцогч талууд дараах эрх эдэлнэ:

13.1.1.эвлэрүүлэн зуучлах журмаар маргаанаа зохицуулах талаар өөрийн хүсэл зоригийг аливаа дарамт, шахалтгүйгээр чөлөөтэй илэрхийлэх, эвлэрүүлэн зуучлах ажиллагаагаар маргаанаа шийдвэрлүүлэхийг зөвшөөрөх, татгалзах;

13.1.2.тохиролцох асуудлын хүрээг чөлөөтэй сонгох, эвлэрэх, шаардлага болон нэхэмжлэлээсээ татгалзах, хүлээн зөвшөөрөх, биелүүлэх;

13.1.3.эвлэрүүлэн зуучлагчийг зөвшөөрөх, татгалзах, сонгох талаар хүсэлт гаргах;

13.1.4.эвлэрүүлэн зуучлах ажиллагааны арга, хэлбэрийг сонгох, уг ажиллагаанд байр сууриа тодорхойлох, хамгаалах, мэдээлэл авах, маргаанд холбогдох баримт сэлтийг гаргаж өгөх, маргааныг зохицуулах тохиролцооны нөхцөлийг үнэлэх;

13.1.5.эвлэрүүлэн зуучлах ажиллагааны үйл явц, түүний үр дагавар, эвлэрлийн гэрээнд гарын үсэг зурснаас үүсэх үр дагаврын талаар мэдээлэл авах;

13.1.6.эвлэрлийн гэрээг сайн дураар биелүүлээгүйгээс үүсэх үр дагаврын талаар мэдээлэл авах;

13.1.7.эвлэрүүлэн зуучлалын аль ч үед уг ажиллагаанаас татгалзах;

13.1.8.эвлэрлийн гэрээнд гарын үсэг зурах;

13.1.9.эвлэрүүлэн зуучлал амжилтгүй болсон тохиолдолд, эсхүл энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр байгуулсан эвлэрлийн гэрээний талаар шүүхэд нэхэмжлэл гаргах;

13.1.10.хуульд заасан бусад эрх.

Монгол Улсын Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд өгөх АИХЭГ-ын санал дүгнэлт

13.2.Эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд оролцогч талууд дараах үүрэг хүлээнэ:

13.2.1.эвлэрлийн гэрээнд гарын үсэг зурсан тохиолдолд уг гэрээгээр хүлээсэн үүргээ сайн дураар, шударгаар гүйцэтгэх;

13.2.2.энэ хуульд заасан журмын дагуу эвлэрүүлэн зуучлах ажиллагааны хураамж, ажлын хөлс, зайлшгүй зардлыг хариуцах;

13.2.3.эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд идэвх санаачилгатай оролцох, эвлэрүүлэн зуучлагчийн дуудлага, товлосон уулзалтад хүрэлцэн ирэх;

13.2.4.хуульд заасан бусад үүрэг.

14 дүгээр зүйл.Эвлэрүүлэн зуучлагчийн эрх, үүрэг

14.1.Эвлэрүүлэн зуучлагч дараах эрх эдэлнэ:

14.1.1.энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан эвлэрүүлэн зуучлагч маргааны шинж байдлаас шалтгаалан талуудтай харилцан тохиролцож ажлын хөлс авах, эвлэрүүлэн зуучлах ажиллагааны зардлыг төлүүлэх;

14.1.2.нууцлалыг хадгалах зарчмыг баримтлан үйл ажиллагааныхаа талаар олон нийтэд мэдээлэх;

14.1.3.энэ хуульд заасан журмыг дагаж мөрдөн эвлэрүүлэн зуучлах үйл явцыг зохион байгуулахдаа өөрийн арга, хэлбэрийг сонгон хэрэглэх, маргааныг шийдвэрлэх талаар талуудад амаар болон бичгээр зөвлөмж өгөх;

14.1.4.эвлэрүүлэн зуучлалд идэвхтэй оролцохыг талуудаас шаардах, талуудыг ганцаарчилсан болон хамтарсан уулзалтад дуудан ирүүлэх;

14.1.5. маргааныг шийдвэрлэх хувилбарыг талуудад санал болгох;

14.1.6.хуульд заасан бусад эрх.

14.2.Эвлэрүүлэн зуучлагч дараах үүрэг хүлээнэ:

14.2.1.хууль тогтоомжид заасны дагуу эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулах боломжгүй тохиолдолд түүнээс татгалзах;

14.2.2.эвлэрүүлэн зуучлах ажиллагааны зарчмыг чандлан сахиж, үйл ажиллагаагаа талуудын аль алины эрх, ашиг сонирхолд нийцүүлэн тэдний тэгш оролцоог хангаж явуулах;

14.2.3.талуудад эвлэрүүлэн зуучлалын үйл явц, түүний зорилго, үр дагаврын талаар мэдээлэл өгөх;

14.2.4.маргаанд ямар нэг хувийн ашиг сонирхолгүйгээр төвийг сахин, эвлэрүүлэн зуучлах үйл явцыг удирдах;

14.2.5.эвлэрүүлэн зуучлагчийн ёс зүйн дүрмийг чандлан сахиж;

14.2.6.эвлэрүүлэн зуучлах ажиллагааны явцад талуудаас итгэмжлэн өгсөн баримт сэлтийг буцааж өгөх;

Монгол Улсын Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд өгөх АИХЭГ-ын санал дүгнэлт

14.2.7. талуудын аль нэгэнд эрх зүйн зөвлөгөө өгөх, туслалцаа үзүүлэхгүй байх;

14.2.8. хэлэлцэж байгаа асуудал бүрд талуудын хүсэлтийг бататгаж, харилцан буулт хийх нөхцөлийг бүрдүүлэх;

14.2.9. эвлэрүүлэн зуучлалын үйл явцын талаар тэмдэглэл хөтлөх, талуудад асуулт тавих, тайлбарыг баримтжуулах;

14.2.10. хуульд заасан бусад үүрэг.

15 дугаар зүйл. Эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд өмгөөлөгч оролцох

15.1. Өмгөөлөгч үйлчлүүлэгчийнхээ хүсэлтээр эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд оролцох тохиолдолд маргааныг эвлэрүүлэн зуучлалын журмаар шийдвэрлэх тохиролцооны нөхцөл болон үр дагаврын талаар түүнд тайлбарлах үүрэгтэй.

15.2. Өмгөөлөгч мэргэшсэн эвлэрүүлэн зуучлагч бол өөрийн явуулсан эвлэрүүлэн зуучлах ажиллагааны оролцогч аль нэг талд хожим тухайн асуудлаар хууль зүйн туслалцаа үзүүлэх буюу аль нэг талын өмгөөлөгчөөр оролцох, эсхүл урьд өмнө өмгөөлөгчөөр оролцож байсан хэрэгт эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулахыг хориглоно.

15.3. Талуудын хүсэлтээр өмгөөлөгч эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд оролцох тохиолдолд эвлэрүүлэн зуучлагчийн ажиллагаанд хөндлөнгөөс оролцох, талууд эвлэрэхэд саад учруулахыг хориглоно.

16 дугаар зүйл. Эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд гуравдагч этгээд оролцох

16.1. Эвлэрүүлэн зуучлалын үр дүнд хуулиар хамгаалагдсан ашиг сонирхол нь хөндөгдөхөөр бол гуравдагч этгээдийг өөрийнх нь, түүнчлэн зуучлагч болон талуудын хүсэлт, зөвшөөрлөөр уг ажиллагаанд оролцуулж болно.

16.2. Талуудын хүсэлтээр тэдний гэр бүлийн гишүүн, төрөл, садангийн хүн болон холбогдох бусад этгээдийг эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд оролцуулж болно.

17 дугаар зүйл. Эвлэрүүлэн зуучлагчийг татгалзан гаргах

17.1. Талууд дангаар, эсхүл харилцан тохиролцсоноор эвлэрүүлэн зуучлагчийг татгалзан гаргаж болно. Шүүхэд иргэний хэрэг, маргаан үүсгэснээс хойш эвлэрүүлэн зуучлагчийг татгалзан гаргасан бол энэ талаар шүүхэд мэдэгдэх үүрэгтэй.

17.2. Эвлэрүүлэн зуучлах ажиллагааг зарчмын дагуу хэрэгжүүлэхэд саад болох аливаа нөхцөл байдал бий болсон тохиолдолд эвлэрүүлэн зуучлагч уг ажиллагаанаас нэн даруй татгалзан гарах үүрэгтэй.

17.3. Энэ хуулийн 17.4-т зааснаас гадна эвлэрүүлэн зуучлагч өөрийн хүчин зүтгэлээр талуудыг эвлэрэлд хүргэж чадахгүй гэж үзсэн бол эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулахаас татгалзах, эсхүл талуудын санал, зөвшөөрлийн дагуу эвлэрүүлэн зуучлах ажиллагааг дуусгавар болгох эрхтэй.

17.4. Эвлэрүүлэн зуучлагч нь талуудын аль нэгтэй гэр бүлийн, төрөл, садангийн холбоотой, эсхүл аль нэг талд хууль зүйн зөвлөгөө өгсөн, нууц задруулсан, ёс зүйн дүрмийг ноцтой зөрчсөн бол талууд эвлэрүүлэн зуучлагчийг татгалзан гаргах эрхтэй.

**ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ
ЭВЛЭРҮҮЛЭН ЗУУЧЛАХ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ****18 дугаар зүйл.Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны нийтлэг үндэслэл**

18.1.Талууд эсрэг талдаа мэдэгдэхгүйгээр зуучлагчтай уулзах, тухайн маргаанд өмгөөлөгчөөр ажиллах талаар эвлэрүүлэн зуучлагчид хүсэлт, шаардлага тавих зэрэг хууль бус үйлдэл, эс үйлдэхгүйгээр эвлэрүүлэн зуучлагчийн төвийг сахисан байр суурийг алдагдахуйц үйлдэл хийхийг хориглоно.

18.2.Эвлэрүүлэн зуучлагч өөрийн ажил үүргийн хүрээнд олж авсан мэдээллийг ажил үүргээ гүйцэтгэж байх үед болон ажлаас чөлөөлөгдсөнөөс хойш задруулж үл болно.

18.3.Эвлэрүүлэн зуучлагч эвлэрүүлэн зуучлах ажиллагааны явцад олж авсан баримт сэлтийг хууль бусаар ашиглахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна.

18.4.Хуульд зааснаас бусад тохиолдолд ажил үүргээ гүйцэтгэх замаар уг хэргийн байдлыг мэдэх болсон эвлэрүүлэн зуучлагчийг гэрчээр дуудах буюу мэдүүлэг авч болохгүй. Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны явцад ил болсон мэдээллийг талуудын зөвшөөрөлгүй бусдад задруулсан этгээд энэ хуульд заасан хариуцлага хүлээнэ.

18.5.Талууд эвлэрүүлэн зуучлалыг сонгосон, уг ажиллагаанд оролцсон байдал нь шүүхээс Иргэний хуулийн 79.1, 82.4-т заасны дагуу хөөн хэлэлцэх хугацааг сэргээх, эсхүл уг хугацааг тасалдсан гэж үзэх үндэслэл болно.

18.6.Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны үед талуудын гаргасан аливаа тайлбар нь шүүхээр маргааныг хянан шийдвэрлэхэд нотлох баримтын хэмжээнд үнэлэгдэхгүй.

[/Энэ хэсгийг 2013 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

19 дүгээр зүйл.Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулах газар

19.1.Эвлэрүүлэн зуучлах ажиллагааг уг ажиллагааны хаалттай явагдах зарчмыг хангах боломжтой зориулалтын танхим, эсхүл талуудын тохиролцсон бусад газарт явуулна.

20 дугаар зүйл.Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулах хугацаа

20.1.Эвлэрүүлэн зуучлах ажиллагааг 30 хоногт багтаан явуулах бөгөөд талуудын хүсэлтээр энэ хугацааг нэг удаа сунгаж болно.

20.2.Энэ хуулийн 30.1-д заасны дагуу явуулах эвлэрүүлэн зуучлах ажиллагааг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 71.1-д заасан хугацааны дотор явуулна.

21 дүгээр зүйл.Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны нөхцөл

21.1.Талууд энэ хуулийн 7, 8 дугаар зүйлд заасан эвлэрүүлэн зуучлагчид хандсан, шүүхэд иргэний хэрэг үүсгэснээс хойш зохигчид өөрсдөө эвлэрүүлэн зуучлалыг хэрэглэхээр тохиролцсон, эсхүл шүүгч эвлэрүүлэн зуучлалыг хэрэглэх нь зохистой гэж үзэж санал болгосныг зохигчид зөвшөөрснөөр уг ажиллагаа эхэлнэ.

21.2.Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа нь талууд оролцуулахыг зөвшөөрснөөс бусад этгээдийн хувьд хаалттай явагдана.

Монгол Улсын Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд өгөх АИХЭГ-ын санал дүгнэлт

21.3.Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны явцад талуудыг албадах, тэдгээрт дарамт, шахалт үзүүлэх зэрэг аливаа хэлбэрээр нөлөөлөхийг хориглоно.

21.4.Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны оролцогчид уг ажиллагааны явцад олж авсан мэдээллийг мэдээлэл гаргагчийн бичгээр гаргасан зөвшөөрөлгүйгээр бусдад задруулахыг хориглоно.

21.5.Энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан эвлэрүүлэн зуучлагч нь талууд болон холбогдох этгээдийг гэрийн хаяг, шуудангийн хаягийн дагуу мэдэгдэх хуудсаар, эсхүл утсаар дуудаж ирүүлнэ.

21.6.Энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан эвлэрүүлэн зуучлагч Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 77 дугаар зүйлд заасан журмын дагуу талууд болон холбогдох этгээдийг шүүхийн мэдэгдэх хуудсаар дуудаж ирүүлнэ.

22 дугаар зүйл.Эвлэрүүлэн зуучлуулах өргөдөл гаргах

22.1.Эвлэрүүлэн зуучлалын журмаар маргаанаа шийдвэрлүүлэх хүсэлтэй этгээд эвлэрүүлэн зуучлагчид өргөдөл гаргана.

22.2.Эвлэрүүлэн зуучлагч өргөдөл хүлээн авсан тухай болон эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулах товыг талуудад мэдэгдэнэ.

22.3.Талууд эвлэрүүлэн зуучлагчийн нас, хүйс, мэргэшсэн чиглэл, дадлага, туршлага зэрэг асуудлаар эвлэрүүлэн зуучлагчид тусгайлан хүсэлт гаргаж болно.

23 дугаар зүйл.Эвлэрүүлэн зуучлагчийг сонгох

23.1.Талууд нэг ажиллагаанд нэг, эсхүл хэд хэдэн эвлэрүүлэн зуучлагчийг сонгож болно.

23.2.Энэ хуулийн 23.1-д заасны дагуу хэд хэдэн эвлэрүүлэн зуучлагч сонгосон бол зуучлагчид дотроосоо ахлах зуучлагчийг сонгоно.

23.3.Шүүх дэх эвлэрүүлэн зуучлагч ачаалал нэмэгдсэн, тусгай мэргэжлийн эвлэрүүлэн зуучлагч шаардлагатай болсон, эсхүл талууд өөр эвлэрүүлэн зуучлагч сонгосон тохиолдолд тухайн маргаанд орон тооны бус эвлэрүүлэн зуучлагчийг оролцуулна.

24 дүгээр зүйл.Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулах хэлбэр

24.1.Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны эхний уулзалтад талуудыг заавал оролцуулна. Энэ уулзалтаар эвлэрүүлэн зуучлагч эвлэрүүлэн зуучлах ажиллагааны дэг, журам, талуудын эрх, үүргийг танилцуулж, талуудын шаардлага, тайлбарыг сонсож, эвлэрүүлэн зуучлах ажиллагааны цаашдын чиглэлийг тодорхойлно.

24.2.Эвлэрүүлэн зуучлах ажиллагааг талуудыг хамтран оролцуулах зарчмын дагуу явуулна. Эвлэрүүлэн зуучлагч нь зөвхөн шаардлагатай тохиолдолд талуудтай ганцаарчилсан уулзалт хийнэ.

24.3.Нэг уулзалтын хугацаа нь талуудын тайлбарыг бүрэн сонсох, харилцан ойлголцоход хангалттай байвал зохино.

25 дугаар зүйл.Тэмдэглэл

25.1.Эвлэрүүлэн зуучлагч буюу түүний даалгавраар эвлэрүүлэн зуучлах ажилтан ажиллагаа бүрийн тэмдэглэлийг цаг тухайд нь хөтөлнө.

Монгол Улсын Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд өгөх АИХЭГ-ын санал дүгнэлт

25.2.Тэмдэглэлийг монгол хэлээр хөтлөх бөгөөд түүнд уулзалтыг хэзээ, хаана хийсэн, эхэлсэн, дууссан цаг, эвлэрүүлэн зуучлагч болон уулзалтад оролцсон талуудын овог, нэр, хаяг, талуудын асуулт, хариулт, тайлбар, санал нэгдсэн байдал, шийдэл, дараагийн ажиллагааны арга, хэлбэр, товыг тэмдэглэнэ.

25.3.Тэмдэглэлд эвлэрүүлэн зуучлагч болон талууд гарын үсэг зурна.

25.4.Эвлэрүүлэн зуучлагч талуудаас гаргаж өгсөн баримт бичиг болон эд зүйлсийг өөрсдийнх нь хүсэлтээр буцаан олгоно.

25.5.Талуудтай харилцан тохиролцсоны үндсэн дээр эвлэрүүлэн зуучлах ажиллагааны явцад үйлдсэн баримт бичиг болон тэмдэглэлийг хадгалах хүрээ, хугацааг тогтоож болно.

25.6.Эвлэрүүлэн зуучлагч нь Зөвлөлөөс баталсан журмын дагуу эвлэрүүлэн зуучлах ажиллагааны тэмдэглэл болон бусад баримтын хадгалалт, хамгаалалтыг хариуцаж, зөвхөн талуудын зөвшөөрлөөр бусдад үзүүлэх эрхтэй.

26 дугаар зүйл.Эвлэрлийн гэрээ

26.1.Талуудын тохиролцооны агуулгыг талууд өөрсдөө, эсхүл тэдний хүсэлтээр эвлэрүүлэн зуучлагч нэгтгэн тусгасан эвлэрлийн гэрээний төслийг боловсруулна.

26.2.Эвлэрлийн гэрээг монгол хэл, эсхүл талуудын тохиролцсон хэлээр боловсруулна. Монгол хэлнээс өөр хэлээр боловсруулсан гэрээний албан ёсны орчуулгыг уг гэрээний салшгүй хэсэг болгон хавсаргана.

26.3.Эвлэрлийн гэрээнд он, сар, өдөр, тухайн эвлэрүүлэн зуучлагчийн овог, нэр, маргалдагч талуудын овог, нэр, хаяг, эвлэрүүлэн зуучлал эхэлсэн он, сар, өдөр, маргааны агуулга, түүний талаарх талуудын байр суурь, тохиролцсон зүйлс болон бусад асуудлыг ойлгомжтой, тодорхой тусгаж, талууд болон зуучлагч гарын үсэг зурж баталгаажуулна.

26.4.Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны үр дүнд хийгдсэн эвлэрлийн гэрээ Иргэний хуульд нийцсэн, гуравдагч этгээдийн хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлыг хөндөөгүй байна.

26.5.Эвлэрлийн гэрээгээр талууд болон зохигчид эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр эвлэрэх, шаардлагыг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх, шаардлага болон нэхэмжлэлээсээ татгалзаж болно.

27 дугаар зүйл. Эвлэрлийн гэрээний гүйцэтгэлийг хангах

27.1.Энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр байгуулсан эвлэрлийн гэрээгээр хүлээсэн үүргээ үүрэг гүйцэтгэгч биелүүлээгүй бол нөгөө тал нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 3.1-д заасны дагуу шүүхэд хандах эрхтэй.

27.2.Энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр байгуулсан эвлэрлийн гэрээг тухайн шатны шүүгч баталгаажуулж, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 74.2, 74.6 дахь хэсэг, 75 дугаар зүйлд заасан журмын дагуу захирамж гаргана.

[/Энэ хэсэгт 2013 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

27.3.Энэ хуулийн 30.2-т заасны дагуу талуудын эвлэрлийг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгосон тохиолдолд улсын тэмдэгтийн хураамжийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 74.5-д заасны дагуу шийдвэрлэнэ.

Монгол Улсын Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд өгөх АИХЭГ-ын санал дүгнэлт

[/Энэ хэсгийг 2013 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

28 дугаар зүйл.Эвлэрүүлэн зуучлал дуусгавар болох

28.1.Талуудын хүсэлт болон эвлэрүүлэн зуучлагчийн санаачилгаар дор дурдсан үндэслэлээр эвлэрүүлэн зуучлалын ажиллагааг дуусгавар болгож болно:

28.1.1.аль нэг тал эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд оролцоогүй;

28.1.2.уулзалт, ярилцлага удаа дараа хангалттай үр дүнд хүрээгүй, цаашид үр дүнд хүрэхгүй нь ойлгомжтой болсон буюу эвлэрүүлэн зуучлал амжилтгүй болсон;

28.1.3.талууд эвлэрүүлэн зуучлалаар маргаанаа шийдвэрлүүлэх талаар идэвх санаачилгагүй хандсан;

28.1.4.талууд эвлэрүүлэн зуучлалыг дуусгавар болгох хүсэлт гаргасан;

28.1.5.эвлэрүүлэн зуучлалын хугацаа дууссан, цаашид сунгах боломжгүй болсон;

28.1.6.эвлэрүүлэн зуучлагчийг талууд татгалзсанаар уг ажиллагааг цаашид үргэлжлүүлэх боломжгүй болсон.

29 дүгээр зүйл.Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны хураамж, зардал, хөлс

29.1.Шүүх дэх эвлэрүүлэн зуучлагчаас маргаан зохицуулахтай холбогдсон үйлчилгээ үзүүлсний төлөө талууд болон зохигчдоос төлж байгаа мөнгөн хөрөнгийг улсын тэмдэгтийн хураамж гэнэ. Эвлэрүүлэн зуучлуулах өргөдөл гаргасан этгээд улсын тэмдэгтийн хураамжийг хуульд заасны дагуу урьдчилан төлнө.

29.2.Эвлэрүүлэн зуучлагчаас маргааныг зохицуулахтай холбогдон зайлшгүй гарах зардлыг эвлэрүүлэн зуучлах ажиллагааны зардал гэнэ. Шүүх дэх эвлэрүүлэн зуучлагчийн зардлыг төсвөөс санхүүжүүлнэ.

29.3.Энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан эвлэрүүлэн зуучлагчийн зардал, ажлын хөлсийг талууд гэрээгээр тохиролцоно.

29.4.Шүүх дэх орон тооны бус эвлэрүүлэн зуучлагчийн ажлын хөлсийг Шүүхийн ерөнхий зөвлөл тогтооно.

**ТАВДУГААР БҮЛЭГ
ЗАРИМ ТӨРЛИЙН МАРГААНЫГ ЭВЛЭРҮҮЛЭН ЗУУЧЛАХ АЖИЛЛАГАА****30 дугаар зүйл.Иргэний хэрэгт эвлэрүүлэн зуучлалыг хэрэглэх**

30.1.Шүүхэд иргэний хэрэг маргаан үүсгэснээс хойш талууд хамтарч хүсэлт гаргасан, эсхүл шүүгч эвлэрүүлэн зуучлалыг хэрэглэх нь зохистой гэж үзэж санал болгосныг талууд зөвшөөрсөн тохиолдолд эвлэрүүлэн зуучлах ажиллагааг явуулж болно.

30.2.Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны үр дүнд талууд эвлэрсэн бол шүүх Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу талуудын эвлэрлийг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгоно.

Монгол Улсын Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд өгөх АИХЭГ-ын санал дүгнэлт

30.3.Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа амжилтад хүрээгүй дуусгавар болсон тохиолдолд шүүх хэргийг ердийн журмаар хянан шийдвэрлэнэ.

30.4.Нэхэмжлэлийн хэд хэдэн шаардлагад иргэний хэрэг үүсгэсэн тохиолдолд талууд бүх шаардлага, эсхүл аль нэг буюу хэд хэдэн шаардлагын талаар эвлэрүүлэн зуучлагчийн туслалцааг ашиглаж болно.

30.5.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад талууд эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр нэхэмжлэлийн зарим шаардлагын талаар хоорондоо эвлэрсэн тохиолдолд эвлэрлийг тухайн маргааныг эцэслэн шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрт тусгана.

30.6.Иргэний хэрэг үүсгэснээс хойш явагдах эвлэрүүлэн зуучлах ажиллагааны хугацааг шүүгч тогтооно.

31 дүгээр зүйл.Хөдөлмөрийн эрх зүйн маргааныг эвлэрүүлэн зуучлах ажиллагаа

31.1.Хөдөлмөрийн эрх зүйн маргааныг эвлэрүүлэн зуучлах ажиллагаа нь ажил олгогч болон ажилтны хооронд гарсан хөдөлмөрийн ганцаарчилсан маргааны хүрээнд явагдана.

31.2.Хөдөлмөрийн эрх зүйн маргааныг Хөдөлмөрийн тухай хуулийн 126.1-д заасан хөдөлмөрийн маргаан таслах комиссоор хянан шийдвэрлэсэн нь тухайн маргааныг Хөдөлмөрийн тухай хуулийн 127.1-д заасны дагуу шүүх хянан шийдвэрлэхдээ эвлэрүүлэн зуучлах ажиллагааг ашиглахад саад болохгүй.

32 дугаар зүйл.Гэр бүлийн холбогдолтой маргааныг эвлэрүүлэн зуучлах ажиллагаа

32.1.Энэ хуулийн 6.3-т заасан шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлэх журмын дагуу явуулсан эвлэрүүлэн зуучлах ажиллагаа амжилтгүй болсон нь шүүхэд иргэний хэрэг үүсгэснээс хойш гэр бүлийн холбогдолтой маргаанд эвлэрүүлэн зуучлах ажиллагаа дахин явуулахаас татгалзах үндэслэл болохгүй.

32.2.Шүүх Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 132.1-д заасан гэрлэгчдийг эвлэрүүлэх бүх талын арга хэмжээг шүүх дэх эвлэрүүлэн зуучлагч, эсхүл талуудын сонгосон эвлэрүүлэн зуучлагчаар дамжуулан хэрэгжүүлнэ.

32.3.Шүүхээс тогтоосон хугацаанд гэрлэгчид эвлэрээгүй бол шүүх гэрлэгчдийн хооронд үүссэн гэрлэлт цуцлахаас бусад тэтгэвэр, тэтгэлэг, тэтгэмж, дундын хөрөнгө хуваахтай холбогдсон маргаанд шүүх дэх эвлэрүүлэн зуучлагч, эсхүл гэрлэгчдийн сонгосон эвлэрүүлэн зуучлагчийг оролцуулж болно.

32.4.Гэрлэгчдийг эвлэрүүлэх ажиллагаанд сэтгэл зүйч болон төрөл, садан, найз нөхөд, хамтран ажиллагсдыг оролцуулж болно.

**ЗУРГАДУГААР БҮЛЭГ
БУСАД ЗҮЙЛ****33 дугаар зүйл.Эвлэрүүлэн зуучлах ажиллагааг олон нийтэд мэдээлэх**

33.1.Эвлэрүүлэн зуучлах ажиллагааг олон нийтэд сурталчлах, тайлбарлан таниулах, талуудыг эвлэрэхэд дэмжлэг үзүүлэх зэрэг ажлыг эвлэрүүлэн зуучлагч, шүүхийн тамгын хэлтэс, алба болон шүүхийн мэдээлэл, лавлагааны алба хэрэгжүүлнэ.

34 дүгээр зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

Монгол Улсын Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд өгөх АИХЭГ-ын санал дүгнэлт

34.1.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хууль, эсхүл Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

34.2.Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль зөрчсөнөөс учирсан хохирлыг Иргэний хуульд заасны дагуу гэм буруутай этгээд нөхөн төлнө.

/Энэ зүйлийг 2015 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

35 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

35.1.Энэ хуулийг 2013 оны 4 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

/Энэ хэсэгт 2013 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ДЭМБЭРЭЛ